



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 05 ДУГААР САРЫН 16-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 05 дугаар сарын 16-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-8
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	9-92
1.Хууль, тогтоолын төслийг эцэслэн батлах	9-11
2.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдээгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл /Засгийн газар 2025.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	11-58
3.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.05.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	58-92

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
05 дугаар сарын 16-ны өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 64 гишүүн хүрэлцэн ирж, 50.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 00 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Т.Аубакир, Х.Баасанжаргал, П.Батчимэг, Ж.Баясгалан, С.Бямбацогт, А.Ганбаатар, Х.Ганхуяг, Г.Дамдинням, С.Замира, М.Мандхай, Ц.Мөнхтуяа, Н.Наранбаатар, П.Наранбаяр, Д.Пүрэвдаваа, Б.Тулга, А.Ундрраа, Ч.Ундрам, Н.Учрал, Б.Уянга, Д.Үүрийнтуяа, Б.Хэрлэн, Д.Цогтбаатар, О.Цогтгэрэл, С.Цэнгүүн, Д.Энхтуяа, М.Энхцэцэг, С.Эрдэнэбат;

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Л.Оюун-Эрдэнэ;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Амарсайхан, Н.Батсүмбэрэл, Х.Баттулга, Д.Бум-Очир, Э.Одбаяр;

Хоцорсон: Ч.Анар -01 минут, Э.Бат-Амгалан -01 минут, Б.Батбаатар -01 минут, Б.Батцэцэг -54 минут, Б.Бейсен -12 минут, Д.Ганбат -1 цаг 01 минут, Д.Ганмаа -20 минут, Л.Гантөмөр -03 минут, Ц.Даваасүрэн -06 минут, Б.Жавхлан -01 минут, Ж.Золжаргал -07 минут, Ч.Лодойсамбуу -02 минут, С.Лүндэг -04 минут, З.Мэндсайхан -01 минут, М.Нарантуяа-Нара -05 минут, Н.Номтойбаяр -05 минут, С.Одонтуяа -03 минут, О.Саранчулуун -02 минут, Ц.Туваан -01 минут, Г.Тэмүүлэн -1 цаг 01 минут, Г.Уянгахишиг -07 минут, Ж.Чинбүрэн -06 минут, Б.Чойжилсүрэн -13 минут.

Нэг.Хууль, тогтоолын төслийг эцэслэн батлах

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Д.Амарбаясгалан: 1.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56
Татгалзсан: 26
Бүгд: 82

68.3 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Х.Болормаагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Х.Болормаагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 29
Бүгд: 82
64.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: 1.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 21
Бүгд: 82
74.4 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 44
Татгалзсан: 38
Бүгд: 82
53.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: 1.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 23
Бүгд: 83
72.3 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын нийт гишүүдийн олонх хуулийн төслийг эцэслэн батлахыг дэмжээгүй тул “Хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов./10:14/

2.Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68
Татгалзсан: 16
Бүгд: 84

Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар буюу 81.0 хувиар хууль батлагдлаа.

3.“Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66

Татгалзсан: 18

Бүгд: 84

78.6 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар, Р.Сэддорж нарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 81.0 хувийн саналаар баталсанд тооцов.

Уг асуудлыг 10 цаг 15 минутад хэлэлцэж дуусав

Хоёр.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл /Засгийн газар 2025.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Ж.Дэлгэрсайхан, Р.Ринчинбазар, А.Энхбат, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Анар, Хөгжлийн төслийн бодлого, зохицуулалтын газрын дарга Л.Балчинлуvsан, Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Эдийн засгийн эрх чөлөө, өрсөлдөх чадварын судалгааны хэлтсийн дарга Ц.Мөнхдэлгэр, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Болормаа нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл, С.Эрдэнэболд, Л.Соронзонболд, О.Батнайрамдал, М.Бадамсүрэн, Л.Мөнхбаясгалан, А.Ариунзаяа, Б.Жаргалан, Д.Энхтүвшин, Ж.Батжаргал, Ж.Баярмаа, Ц.Сандаг-Очир, Г.Очирбат, Ж.Галбадрах, Б.Батбаатар, О.Саранчулуун нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан, Монгол Улсын

Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Сангийн сайд Б.Жавхлан, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номин, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн А.Энхбат, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж нар хариулж, тайлбар хийв.

Үдийн завсарлагааны цаг болсон тул үдээс өмнөх хуралдаан 3 цаг 00 минут үргэлжилж, 13 цаг 00 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 15 цаг 10 минутад эхлэв.

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа 13 цаг 10 минутаас хуралдааныг даргалав.

Хууль, тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг Улсын Их Хурлын гишүүдийн асуулт, хариултаар үргэлжлэв.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу, Н.Номтойбаяр нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Н.Номтойбаяр хуулийн төслийг дэмжиж үг хэлэв.

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх санал хураалтыг хэлэлцэх асуудлын дарааллын 3 дахь асуудлыг хэлэлцэж дууссаны дараа хамтатган явуулахаар хойшлуулав./15:26/

Гурав.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.05.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга Р.Эрдэнэбүрэн, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Бүс, орон нутгийн удирдлага зохицуулалтын газрын дарга П.Зоригтбаатар, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Д.Саруул, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга А.Энхманлай, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга М.Үнэнбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны референт Б.Баярсайхан нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга Р.Эрдэнэбүрэн, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, П.Сайнзориг, Б.Пүрэвдорж, С.Эрдэнэболд, П.Ганзориг, М.Бадамсүрэн, Ө.Шижир, Л.Мөнхбаясгалан, Д.Жаргалсайхан, Ц.Сандаг-Очир, Г.Очирбат, О.Саранчулуун, Ж.Алдаржавхлан, Д.Батлут нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа, Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга Р.Эрдэнэбүрэн, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Д.Саруул, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга А.Энхманлай, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга М.Үнэнбат нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан 17 цаг 24 минутаас хуралдааныг даргалав.

Д.Амарбаясгалан: 1.Байнгын хорооны саналаар Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	46
Татгалзсан:	46
Бүгд:	92

50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлангийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	44
Татгалзсан:	48
Бүгд:	92

47.8 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Номтойбаярын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Н.Номтойбаярын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	50
Татгалзсан:	42

Бүгд: 92
54.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: 1.Байнгын хорооны саналаар Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 39
Бүгд: 92
57.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

2.Байнгын хорооны саналаар Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 37
Бүгд: 92
59.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Байнгын хорооны саналаар “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 37
Бүгд: 92
59.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Хуралдаан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийн санал хураалтаар үргэлжлэв.

Д.Амарбаясгалан: 1.Байнгын хорооны саналаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 32
Бүгд: 92
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

2.Байнгын хорооны саналаар “Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичиг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59
Татгалзсан: 33
Бүгд: 92
64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 5 цаг 26 минут үргэлжилж, 126 гишүүнээс 92 гишүүн хүрэлцэн ирж, 73.0 хувийн ирцтэйгээр 17 цаг 36 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 05 дугаар сарын 16-ны өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 00 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Нийт 64 гишүүн ирцэд бүртгэгдэж, 50,8 хувьтай байгаа учраас 2025 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Гишүүд суудлаа эзэлье, шууд санал хураалт авна шүү. 1 дүгээрт хуулийн төслүүдийг эцэслэн батална 3 төсөл байна. 2 дугаарт Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-гоос 28 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын өрийн удирдлагын 26-аас 28 оны стратегийн баримт бичиг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. 3 дугаарт Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. Хэлэлцэх асуудалд оръё.

Ирцэд бүртгэгдсэн гишүүд танхимд орж ирье. Санал хураалт явагдана. Энэ хооронд ирц бүртгэлийн нэг санал хураалт явуулчихъя. Санал хураалт ирц бүртгэл. Ирцэд орсон гишүүд танхимд орж ирье. Санал хураалтад орж амжаагүй Рэгдэл гишүүн, Сарнай гишүүн, Батшугар, Баярбаатар, Батлут, Бадамсүрэн нарын гишүүд ирц бүртгэлийнхээ санал хураалтад орохгүй байна. Саранчулуун. Гишүүд суудлаа эзэлчих ирц бүртгэлийн санал хураалт дахиж явуулаадахъя. Ирцэд орсон гишүүдээс хэн, хэн орж ирээгүй байна вэ нэг хараадахъя. Санал хураалт. Санал хураалтад Гантөмөр, Батсуурь, Энхнасан гэсэн 3 гишүүн, Лүндэг гэсэн 4 гишүүн оролцоогүй байна гэдэг чинь 64. Энэ 15-ныг хүртэл чөлөө авч, томилолт авч явсан хүмүүс яагаад өнөөдөр чуулгандаа ирээгүй байна вэ? Ирц бүртгэлээрээ олон нийтэд парламентын веб сайтаар дамжаад байнгын ил тод явагдаж байгаа. Хэн сууж байгаа, хэн ирэхгүй байгаа, хэн хаашаа явсан бүх мэдээлэл парламентынхаа веб сайтаар дамжаад олон нийтэд явж байгаа. Ингээд бүртгүүлсэн гишүүд танхимдаа орж ирж, суудлаа эзэлсэн байна. Ирц бүртгэлийн санал хураалт явуулъя. Тэгээд өнөөдөр хуулийн төслүүд эцэслэн батлах учраас дандаа 64-өөр санал батлагдах ёстой. Ирц бүртгэлийн санал хураалт. Сарнай гишүүн, Батсуурь гишүүн, Далайн Батбаяр гишүүн, Пунсалмаа гишүүн, Доржханд сайд, Жавхлан сайд гээд 5 хүн санал хураалтад орж чадаагүй байна. Одонтуяа сайд. Санал хураалт руу оръё. Нийт 72 гишүүн байгаа юм байна.

Нэг.Хууль, тогтоолын төслийг эцэслэн батлах

Хэлэлцэх асуудалдаа оръё. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийг эцэслэн батална. Хуулийн төслүүдийн эцэслэн батлуулах хувилбарыг Байнгын хороод бэлтгэн гишүүдэд тараасан байна. Монгол

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.2-т нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн хууль эцэслэн баталсанд тооцно гэж заасан байна. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 56 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдсангүй. Би өөрөө татгалзсан. 1 горимын санал гаргах гээд байгаа юм уу гишүүд, гараа өргөөрэй хэн, хэн горимын санал гаргах хүсэлтэй байгаа юм бэ? Баярмаа гишүүн гаргахгүй юм уу? Хөххүүгийн Болормаа гишүүн горимын санал.

Х.Болормаа: Төхөөрөмж ажиллаагүй учраас горимын санал, дахин санал хураах горимын санал гаргаж байна. Дэмжиж өгнө үү.

Д.Амарбаясгалан: Болормаа гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүй болгох горимын саналаар санал хураалт. 53 гишүүн дэмжиж, 64.6 хувиар горимын санал дэмжигдлээ. Санал хураалтыг дахин явуулна. Гишүүд анхаарлаа төвлөрүүлээрэй. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 61 гишүүнээр хууль дэмжигдсэнгүй. Тусдаа шүү дээ, тусдаа. Энэ чинь эхлээд Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох. 61 болсон байна. Хууль батлагдсангүй эцэслэн. Батшугар гишүүн горимын санал.

Э.Батшугар: Сая техник ажилласангүй. Тэгээд саяын санал хураалтыг хүчингүй болгоод, шинээр санал хураалт явуулах горимын санал гаргаж байна. Батшугар гишүүний саналаар горимын санал хураалт явуулъя. Хүчингүй болгох горимын санал. 44 гишүүн буюу 53,7 хувиар горимын санал дэмжигдсэн байна. Үндсэн санал хураалтаа дахиж явуулъя. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 60 гишүүнээр хууль дэмжигдсэнгүй. 3 удаагийн санал хураалт явууллаа. Тэгээд үндсэндээ энэ гишүүд зохицуулалтаа зөв хийж орж ир гэсэн л байр суурь гэсэн үг шүү дээ ер нь тэгээд, дахиад орж ирэх боломжтой. Дахиад орж ирэх боломжтой. Тэгэхээр зохицуулалтыг нь зөв хийгээд, дахиж оруулж ирэх шаардлага байна гэсэн үг. Тариаланчдад болон гурилын үйлдвэрүүдэд ямар нэгэн эрсдэл учрахгүй. Өнгөрсөн жил энэ хууль батлагдсантай холбогдож дагаж гарсан тогтоол байгаа. Тэр тогтоолоор бүх зохицуулалтыг хийх нөхцөлийг Улсын Их Хурлаас хангаж өгсөн. Тэгэхээр ЗГ-ын түвшинд энэ дээрээ анхаарч ажиллах нь зөв гэж үзэж байна. Надад хуулийн төсөл буцаах тогтоолын төсөл аваад ирээч. Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 44.2-т нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн бол эцэслэн батлагдсанд баталсанд тооцно гэж заасан байгаа. Тэгээд олонх дэмжээгүй учраас эцэслэн баталсанд тооцохгүй хууль санаачлагчид буцаагдаж байна.

2.Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 68 гишүүн дэмжиж хууль эцэслэн батлагдлаа.

Хамт өргөн мэдүүлсэн Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын

томьёоллоор санал хураалт явуулна. Энэ чинь энэ Зээлийн мэдээллийн сангийн тухай хуулийг дагаж байгаа тогтоол. Тэгэхээр тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 66 гишүүн буюу 78,6 хувиар тогтоолын төсөл дэмжигдлээ. Сэддорж гишүүнийг дэмжсэнээр протоколд тэмдэглэе. Хэнийгээ? Батшугар гишүүнийг дэмжсэнээр протоколд тэмдэглэе. Хууль тогтоолын төслүүд эцэслэн батлагдлаа. Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсэгт талархал дэвшүүлье. Төсвийн байнгын хороо, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан саналын дагуу, энэ хууль дэмжигдээгүй учраас энэ нь явахгүй. Зээлийн мэдээллийн сангийн эцсийн найруулгыг бэлтгэж, Байнгын хорооноос оруулж ирээд, өнөөдрийн чуулганаар эцсийн найруулгыг сонссонд тооцох ажил хийгдэх ёстой гэж бодож байна.

10.15 цаг

Хоёр.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл /Засгийн газар 2025.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Дараагийн асуудалд оръё. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-гоос 28 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн ЗГ-ын өрийн удирдлагын 2026-аас 28 оны стратегийн баримт бичиг батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Лувсаннямын Гантөмөр танилцуулна. Индэрт урьж байна.

Л.Гантөмөр: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-гоос 2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг та бүхэнд танилцуулж байна. Манай эдийн засаг 2024 онд 4,9 хувиар өсөж, нэрлэсэн ДНБ 80 их наяд төгрөгт, нэг хүнд ноогдох ДНБ нь 6898 ам.долларт хүрсэн. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-гоос 2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлд эдийн засгийн өсөлтийг 2026 онд 6 хувь, 2027-гоос 2028 онд тус тус 6,5 хувь байхаар тооцож тусгалаа. Дунд хугацаанд зэсийн баяжмал, нүүрс, төмрийн хүдэр, алт зэрэг голлох бүтээгдэхүүнүүдийн үйлдвэрлэлийн өсөлтийн нөлөөгөөр уул уурхайн салбарын өсөлт тогтворжих бол хөдөө аж ахуй, худалдаа, үйлчилгээ, боловсруулах болон барилгын салбарын өсөлтийн нөлөөгөөр уул уурхайн бус салбарын өсөлтийг 6 хувиас дээш хувь байхаар тогтвортой хадгалагдахаар тооцож байна. Хуулийн төсөлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого болон нийт зарлагын хэмжээг 2026 онд 33,5 их наяд төгрөг, 2027 онд 35,6 их наяд төгрөг, 2028 онд 39,1 их наяд төгрөг байхаар тусгалаа.

Тодруулбал нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого болон нийт зарлагыг 2026 онд ДНБ-ий 31,7 хувь, 2027 онд 30,4 хувь, 2028 онд 29,6 хувь болж үе шаттай буурахаар төлөвлөж байна. Төсвийн зардлын нийт эдийн засаг дахь харьцааг ийнхүү хязгаарласнаар цаашдын эрэлтийн гаралтай инфляцын дарамтыг бууруулах, ингэснээр зээлийн хүү буурах суурь нөхцөл бүрдэх, эдийн засаг дахь төрийн оролцоо багасах, хувийн хэвшлийн оролцоо нэмэгдэх зэрэг бодит ач

холбогдолтой гэдгийг энд тэмдэглэн хэлье. Хуулийн төсөлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 2026-аас 2028 онд алдагдалгүй байхаар, нэгдсэн төсвийн суурь тэнцлийг 2026 онд ДНБ-ий 3 хувьтай тэнцэх хэмжээний ашигтай, 2026-аас 2027 онд тус тус ДНБ-ий 2 хувьтай тэнцэх хэмжээний ашигтай байхаар тооцож тусгасан болно. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-гоос 2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагуудыг нэгэн зэрэг хангасан болно.

Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-гоос 2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон ЗГ-ын өрийн удирдлагын 2026-аас 2028 оны стратегийн баримт бичгийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Төслүүдийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Хөххүүгийн Болормаа уншиж танилцуулна. Индэрт урьж байна.

Х.Болормаа: Эрхэм гишүүддээ энэ өглөөний мэндийг хүргэе. Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг танилцуулъя. Улсын Их Хурлын эрхэм дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-гоос 2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн ЗГ-ын удирдлагын тухай, удирдлагын 2026-аас 2028 оны стратегийн баримт бичиг батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Төсвийн байнгын хороо 2025 оны 5 сарын 14-ний өдрийн хуралдаанаар үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явууллаа. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, 8.1.4 дэх заалт, Өрийн удирдлагын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт ЗГ стратегийн баримт бичгийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийн хамт жил бүрийн 5 сарын 1-ний өдрийн дотор Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Улсын Их Хурал жил бүрийн 6 дугаар сарын 1-ний өдрийн дотор хэлэлцэн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, хэлэлцэн батлахаар заасны дагуу Монгол Улсын ЗГ-аас Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, ЗГ-ын өрийн удирдлагын 2026-аас 2028 оны стратегийн баримт бичиг батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг боловсруулан өргөн мэдүүлсэн.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-гоос 2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлд эдийн засгийн өсөлтийг 2026 онд 6 хувь, 2027-гоос 2028 онд тус тус 6,5 хувь, инфляцыг 2026 онд 7 хувь, 2027 онд 6,4 хувь, 2028 онд 6 хувь байхаар. Мөн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого болон нийт зарлагын хэмжээ 2026 онд 33 их наяд 479,5 тэрбум төгрөг, 2027 онд 35 их наяд 628,6 тэрбум төгрөг, 2028 онд 39 их наяд 86 тэрбум төгрөг байхаар тооцож, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого болон нийт зарлага 2026 онд ДНБ-ий 31,7 хувь, 2027 онд 30,4 хувь, 2028 онд 29,6 хувь болж үе шаттай буурч, дунд хугацаанд нэгдсэн төсөв алдагдалгүй байхаар тооцсон байна. ЗГ-ын өрийн

нэгдсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдлийг 2026 онд ДНБ-ий 50 хувь, 2027 онд 45 хувь, 2028 онд 45 хувь байхаар тооцсон байна.

Байнгын хорооны хуралдаанаар хууль, тогтоолын төслүүдийн хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлээгүй болно. Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-гоос 2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн ЗГ-ын өрийн удирдлагын тухай, Өрийн удирдлагын 2026-аас 2028 оны стратегийн бичиг баримт батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-гоос 2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн ЗГ-ын өрийн удирдлагын 2026-аас 28 оны стратегийн баримт бичиг батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүгдээсээ хүсэж байна. Анхаарал тавьсан та бүхэндээ баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Лувсаннямын Гантөмөр Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Болдын Жавхлан Сангийн сайд, Жамсрандоржийн Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Равсалын Ринчинбазар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны ТНБД, Жигжидийн Ганбат Сангийн яамны ТНБД, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Бат-Ирээдүйн Анар Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын дарга, Лхагвасүрэнгийн Балчинлуvsан Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн төслийн бодлого, зохицуулалтын газрын дарга, Мижиддорж Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Отгондэмбэрэлийн Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Цасчихэрийн Мөнхдэлгэр Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Эдийн засаг, эрх чөлөө, өрсөлдөх чадварын, Эдийн засгийн эрх чөлөө, өрсөлдөх чадварын судалгааны хэлтсийн дарга.

Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Нийт 27 гишүүний нэр ирсэн байна. Ирсэн дарааллын дагуу Баатаржавын Мөнхсоёл гишүүн асуулт асууя.

Б.Мөнхсоёл: Өглөөний мэнд. Асуулт 3 гол асуулт байгаа юм. Тэгэхээр бид Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гаргасан тайлан байгаа, дүгнэлт байгаа. Түүн дээр ч миний саналууд давхцаж байгаа. Тухайлбал Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Стратегийн баримт бичгийн төслийг Эдийн засаг, хөгжлийн

асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ирүүлсэн макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт төлөв байдлын таамаглалд үндэслэн боловсруулж, жил бүрийн 4 дүгээр сарын 15-ны дотор ЗГ-т хүргүүлэх гэж заасан.

Тогтвортой байдлын зөвлөлөөс ДНБ-ий бодит өсөлтийг 26 онд 5,4 хувь, 27 онд 5,5 хувь, 28 онд 5,7 хувь байх таамаглалыг ирүүлсэн байхад Монгол Улсын нэгдсэн төсвийн 26 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 27-гоос 28 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлд эдийн засгийн өсөлтийг 26 онд 6, 27-гоос 28 онд тус тус 6,5 хувь байхаар тооцсон байна. Алтны экспортын биет хэмжээг болохоор 26 онд 12,8 тонн, 27 онд 13,5 тонн, 28 онд 13,2 тонн байх таамаглалыг ирүүлсэн байхад, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтүүдийн төсөөллийг боловсруулахдаа ашигласан төсөөлөл нь дээрх хэмжээнээс 28 оны хувьд 7, 27-гоос 28 оны хувьд 11 тонноор тус тус их байна. Энэ мэт өөдрөг төсөөлөл дээр үндэслэсэн төсвийн төлөвлөлт ирэх жилүүдэд биелэх магадлал хэр байна вэ гэсэн асуултыг асууя? Хуулийн төсөлд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл ямар байр суурьтай байгаа бол? Энэ миний хийсэн дүгнэлт байна.

Асуулт 2 дугаар асуулт болохоор инфляцтай яг адилхан 26 онд 7 хувь, 27 онд 6,4 хувь, 28 онд 6 хувь байхаар тусгасан. Үүнийг Монголбанкны байр суурь ямар байгаа бол? Хэр бодит боломжтой байгаа вэ? Энэ биеллээ олох гэж асууж байгаа юм.

3 дугаар гол асуулт юу вэ гэхээр Монгол Улсын 28 оны хөгжлийн төлөвлөгөөний төсөлд өчигдөрхөн бид ярьсан. Татварын орчны шинэчлэлийг хийнэ гэж тусчихсан байгаа. Энэ том бодлогын өөрчлөлт. Тэгэхээр энэ мэт томоохон бодлогын өөрчлөлт түүнээс төсөвт үзүүлэх нөлөөллийн тооцоо энэ төсөлд хэр зэрэг туссан бэ гэсэн ийм 3 тодорхой асуултыг асуучихъя. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Сангийн яам, Лувсаннямын Гантөмөр сайд хариулт өгье.

Л.Гантөмөр: Мөнхсоёл гишүүний асуултад хариулъя. Энэ удаа бид 2026 оны эдийн засгийн өсөлтийг 6 хувь гэж энэ төсвийн хүрээний мэдэгдэл дээрээ оруулж ирж байгаа. Тэгээд 6 хувийн төсөөлөл зөвхөн ЗГ хийж байгаа төсөөлөл биш, Монголбанк ч гэсэн өнөөдөр 6 хувиар төсөөлж байгаа, Валютын сан 6 хувь гэдэг төсөөлөл гаргаж байгаа, Дэлхийн банк 6 хувь гэдэг төсөөлөл гаргаж байгаа. Тийм учраас энэ ЗГ өөрөө нэг өөдрөг тоо зохиогоод, бусад ийм даруу төлөв гэдэг ийм зүйл эсхүл тооны зөрүү гэдэг зүйл их бага шүү гишүүнээ. Энийг нэг дэх асуултад ийм хариулт байна.

2 дугаарт бид татварын шинэчлэлийг хийхдээ олон улсын зах зээлийн тогтворжилтыг харна. Харж байж хийхгүй бол дэлхийн худалдаа ийм тогтворгүй байгаа үед бид хамаагүй яаран дааран хөнгөн гоомой юм хийхгүй. 26 ондоо хийлээ гэхэд энэ татварын шинэчлэл 27 оноос хэрэгжинэ шүү дээ. Тийм учраас бид энэ их яарсан алхам хийж болохооргүй байна. Бид хэдэн сарын өмнө яаралтай хийчихье гэж харж байсан бол сүүлийн үед энэ худалдааны дайн өөрөө өдрөөс өдөрт өдөр болгон өөрчлөгдөж байна гэдгийг бүгдээрээ ойлгож, татварынхаа ерөнхий өөрчлөлт шинэчлэлтийн ерөнхий зургийг бүгдээрээ хараад, ойлголцоод, тэгээд яг хэлэлцүүлж батлах, хэрэгжүүлэх хугацаагаа нарийн ойлголцох ёстой

гэдэг ийм зүйл байна. Баярлалаа. Нэмж хариулах хэрэгтэй 4 номерын микрофон дээр манай Энх-Амгалан.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулт өгье.

Б.Жавхлан: Мөнхсоёл гишүүний асуултад хариулт нэмж хариулъя. Тэгэхээр татварын шинэчлэлийг бид хийнэ, энэ 4 жил бүтэн хийнэ. Тэгэхээр энэ удаа хэлэлцэж байгаа асуудал маань энэ төсвийн хүрээ шүү хязгаар. Татвар төсвийн хүрээ 2 яаж холбогдох вэ гэхээр ирэх жилээс ингээд 26 оноос татварын шинэчлэлээ хийхээр бол хийгээд эхлэхээр орлого талд нөлөөлнө. Тэгэхээр төсвийн хүрээн дээр орлогын доод хязгаар, зарлагын дээд хязгаар орж ирж байгаа гэсэн үг. Тэгэхээр бид 2026 оны төсөв өргөн баригдах үед ирэх оны төсөв дээр татварын шинэчлэл хэрхэн яаж нөлөөлөх вэ, орлого талд хэрхэн яаж нөлөөлөх вэ, зардал талд хэрхэн яаж нөлөөлөх вэ гэдгийг илүү их тодорхой ийм тоотой орж ирнэ. Тэгэхээр энэ удаа энэ төсвийн хүрээ дандаа хязгаар тоо.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Мөнхсоёл гишүүн тодруулж асууя.

Б.Мөнхсоёл: Хариулт өгсөн. Тэгэхээр нэмээд нэг зүйл тодруулж асуухад иргэд юу асууж байна вэ гэхээр, хэвлэл мэдээлэл ч гэсэн төсвийн тодотгол хийх үү? Эхний 3 сарын байдлаар 1,2 их наяд дутчихлаа, алтны экспортоор нөхнө гэж хэлж байна. Энэ дээр юу гэж бодож байна гээд санал асуугаад яваад байгаа юм. Тодорхой мэдээлэл хэрэгтэй байгаа. Энэ дээр нэмээд хэлчих хэрэгтэй байх.

Тэгээд 2 дугаарт нь ер нь төсвийн хүрээний мэдэгдэл дээр зарим тохиолдолд шалтгаан, үндэслэлээ сайн оруулж ирээд өөрчлөлт хийх боломжтой гэдэг хувь хүний байр суурь байдаг. Энэ тал дээр ямар бодолтой байна вэ? Яагаад гэхээр сая Гантөмөр сайдын хэлсэнчлэн геополитикийн асуудлууд байна. Эрдэс баялгийн үнэ борлуулалтын хэмжээний өөрчлөлтүүд таамагласнаас илүү өндөр хэлбэлзэлтэй байна. Энэтэй холбогдуулаад ийм асуулт гарч ирж байгаа юм логигоор. Энэ дээр хариулт авчихъя гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Жамбалын Ганбаатар гишүүн асуулт асууна, тодруулсан хариулт авах юм уу? Жамбалын Ганбаатар гишүүн гараад явсан байна. Батжаргалын Заяабал гишүүн алга байна. Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууя, асуулт давхацсан. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууя. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэболд: 2 асуулт байгаа. 1 дүгээрт нь болохлоороо энэ нөгөө гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийг тэнцвэржүүлсэн үнээр тооцох аргачлалыг эргэн харах шаардлагатай гээд дүгнэлт өгчихсөн байгаа шүү дээ Сангийн сайдаа. Энэ дээр яг ямар боломжууд байгаа юм бэ?

2 дугаарт иргэд гадуур энэ долларын ханш их он дуусахад ер нь 4000 давах гээд байгаа юм биш шүү ч гэдэг юм уу их тийм айдас болгоомжлолтой байгаад байна л даа. Энэ дээр та нэг тайлбар өгөөч. Тэр нөгөө томоохон мега төслүүд буюу ингээд уран эд нартай холбоотой зүйлүүдийг энэ эдийн засгийн нөлөөлөлд эергээр тооцчихсон байгаа нь өөрөө эрсдэлтэй байна гээд ийм дүгнэлт харагдаад байна. Энэ дүгнэлт дээр нэг та тайлбар өгөөч.

3 дугаарт нь болохлоороо бид нөгөө энэ яах вэ мэдээж хүрээний мэдэгдэл гэдгийг ойлгож байгаа. Гэхдээ сая өнгөрсөн намрын чуулган, ингээд хаврын чуулганы эхэн хэсэг дээр нэлээн анхаарал татсан чухал зүйл юу байсан бэ гэхлээрээ утааны жишээлбэл сонсголын үеэр маш олон зүйлүүд яригдсан. Ялангуяа энэ нөгөө эрх зүй, эдийн засаг, технологи, эрүүл мэндийн ингээд цогц асуудал юм байна гээд. Хүн амын талаас илүү шахуу хувь нь оршин амьдарч байгаа Улаанбаатар болон хот суурин газруудад хүний эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж, амь насанд заналхийлж байгаа хорт хавдрын үүсвэр болж байгаа энэ зүйл эдийн засгийн болон эрүүл мэндийн утгаараа асар их хохирол аваад байна.

Тэгээд энэнээс үүдээд жишээлбэл Мөнхсайхан сайдтай намрын чуулган дээр ярьж байсан. Олон улсын жишгээр бараг 7 хувь руу эрүүл мэндийн төсөв чинь ингээд харьцаад байгаа шүү дээ тийм ээ. Гэтэл манайхан ингээд 3 хувь хүрэхгүй байгаад байдаг. Тэгэхээр энийг ингээд үе шаттайгаар нэмэгдүүлье гээд. Адаглаад тэр нөгөө Монгол хүний өвдөөд байгаа, амь нас, эрүүл мэндэд нь зонхилох заналхийлэл учруулаад байгаа өвчнийг судалдаг тийм том төв байгуулъя эд нар ч гэдэг юм уу. Тэгэхээр ер нь энэ 2 дахь асуулт нь Мөнхсайхан сайд руу ер нь энэ төсвийн хүрээний мэдэгдэл эдийн засаг, макро эдийн засгийнхаа нөхцөл байдлыг энэ анализыг харж байгаад яг энэ 26 оны төсөв орохтой зэрэгцээд энэ бүх зүйлүүдээ ингээд зоригтой оруулмаар байна гэдгийг л хэлэх гээд байгаа юм. Тэгж байж энэ нөгөө ахиад л нэг 2,7, 8 хувьтай ч юм уу эсхүл 9 хувьтай гэхээсээ илүүтэйгээр энэ 4 жилийн хугацаанд одоо үлдэж байгаа 3 жилийн хугацаанд бүүр 5 давуулах, 6 руу дөхүүлэх, тэгээд гол нь энэ нөгөө 21 аймаг чинь 6 бүсэд байгаад байгаа бол тэр бүс болгонд нь тэр сүүлийн оношилгоо, тэр технологийн асуудал, хүний нөөцийн асуудал, тэр ер нь эрүүл мэнд болон энэ боловсролын дэд бүтцийг цогцоор нь нэг тийм бярттай шийдэхэд анхаармаар байгаад байгаа юм.

Тэр утгаараа энэ төсвийн хүрээний мэдэгдэл, төсөөлөл ч юм уу энэ бүх зүйл макро эдийн засгийн энэ орчныг ярьж байхад энэ мэдээллүүдээ давхар өгч яваасай гэж хүсээд байгаа юм. Яагаад ингэж хэлж байгаа вэ гэхлээрээ утааны асуудал гэхэд чинь хот нэг байр суурьтай, Эрүүл мэндийн яам нэг байр суурьтай, Байгаль орчин, уур амьсгалын яам нэг байр суурьтай, янз бүрийн байр сууриуд байгаад байгаа юм. Тэгээд энэ дээр энэ Улсын Их Хурал чинь нэгэнт бодлого тодорхойлж байгаа учраас энэ одоо байгаа асуудлуудаа энэ төсвийнхөө том макро түвшинтэйгээ уялдуулж шийдлүүдийг нь хангах дээр та бүхний байр суурийг сонсьё. Эхний асуулт Жавхлан сайдаас, 2 дахь асуулт нь болохоор Мөнхсайхан сайдаас тодруулъя. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Сангийн сайд Болдын Жавхлан.

Б.Жавхлан: Гол нэрийн бүтээгдэхүүн гэж ДНБ-ий 3 хувиас дээш орлого төвлөрүүлдэг Эрдэнэболд гишүүнээ би таны асуултад хариулж байна. Тийм манай экспортын бүтээгдэхүүнүүдийг хэлдэг. Түүн дээр манай одоогоор нүүрс, зэс 2 л байгаа Өөр бүтээгдэхүүнүүд энэ босгыг давдаггүй. Үүний гол аргачлалыг бид арваад жилийн өмнө Олон улсын валютын сан, Дэлхийн банкны зөвлөмжөөр тухайн үед мөн хөтөлбөрт хамрагдаж байсан тэр асуудлууд дотор энэ орж байсан ийм төлөвлөлт дотор. Тэр нь юу вэ гэхээр энэ 2 бүтээгдэхүүн дээр өнгөрсөн 20 жил, тухайн жил, дараагийн 3 жил гээд нийт 24 жилийн дунджаар үнийг нь авдаг. Өөрөөр хэлбэл 1, 2 жилийн хэт их тийм хэлбэлзлээс цэвэрлэдэг гэсэн үг төсөөллүүдээ. Тийм учраас аль болох хамгийн эрсдэл багатайгаар нь ингэж

тооцдог ийм аргачлалтай. Энийг нэг эргэж энэ аргачлалаа харъя гээд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ийм санал ирж байсан. Тэгэхээр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс энэ дээр нэлээн өөр ямар саналаар, яаж өөрчлөх ийм бодол төлөвлөлт байгаа юм илүү сайн хариулт өгчихвөл их зүгээр байна.

Ханш дээр асууж байна. Тэгэхээр энэ ханшны асуудал манай гадаад худалдааны эдийн засагтай ийм улсын хувьд их савлагаатай байдаг. Тэгэхээр ханш хөдөлж байна гэдэг бол гадаад худалдаа, валютын нөөц, төлбөрийн тэнцэлтэй л холбоотой асуудал. Тэгэхээр богино хугацаандаа бид экспорт дээр онцгой анхаарах ёстой. Дунд, урт хугацаан дээрээ мэдээж гадаад худалдаа, төлбөрийн тэнцэл дээр онцгой анхаарах ёстой. Төлбөрийн тэнцлийн хувьд бид эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг үйлдвэрлэгч улс л болох ёстой. Худалдааны эдийн засгаас үйлдвэрлэлийн эдийн засаг руу шилжих ёстой. Ингэхийн тулд бид энэ 14 мега төслөө л бид ярьж төлөвлөж байгаа. Энэ 14 мега төслийг хийгээдэхвэл бид олон хязгаарлалтаас гарах юм байгаа юм. Өнгөрсөн 4 жилийн хувьд бид Шинэ сэргэлтийн бодлого, энэ шилжээд 14 мега төсөл рүүгээ орсон. Тэгж байж бид төлбөрийн тэнцэл маань үйлдвэрлэгч улсын гадаад худалдаа энэ түүхий эдүүдийн үнийн савлагаанаас үл хамаарсан эрсдэл багатай ийм эдийн засгийн төлөвлөлт рүү шилжиж орох ёстой. Болсон байх, бусдыг нь өөр газраас асуух шиг боллоо.

Д.Амарбаясгалан: Жавхлан сайд гүйцээж хариулъя.

Б.Жавхлан: Эрдэнэбат гишүүн, түрүүн хэн Мөнхсоёл гишүүн асуугаадах нь лээ. Тэр алттай холбоотой асуудал ийм шүү Мөнхсоёл гишүүнээ. Алт 3 хөтөлбөр төсөвт нэг их нэмэртэй зүйл биш шүү, төсөвт нэмэртэй зүйл биш. Алт ерөөсөө л Монгол Улсын валютын нөөц. Хуучин бид 22 тонн алт авч байсан юм хамгийн өндөртөө одоо 15 хүрэхгүй байна. Одоогийн ханшаар 22 тонн гэдэг 2,5 тэрбум доллар болчихоод байгаа юм. Өөрөөр хэлбэл өнөөдөр байгаа Монгол Улсын валютын нөөцийн 50 хувь нь байхгүй юу. Тэгэхээр нөөцөө бид 50 хувиар нэмэгдүүлэх боломж байгаа, 2,5 тэрбум доллароор. Харин 2,5 тэрбум доллароос төсөвт орж ирэх зүйл гэвэл АМНАТ л байгаа. Энэ АМНАТ нь ДНБ-ий дөнгөж 0,3 хувь орчим л, 350 орчим тэрбум төгрөг л орж ирнэ. Энэ нь төсвийн алдагдлыг нөхөхөд, алдагдал гэдэг юм уу төсвийг түрүүн таны хэлснээр алдагдлыг нөхөх хэмжээний тийм орлого огтоос биш. Тэгэхээр.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Болсон уу Эрдэнэболд гишүүн? Мөнхсайхан сайд нэмэлт хариулт өгье.

Т.Мөнхсайхан: Эрдэнэболд гишүүнтэй 100 хувь санал нэг байна. Бид эрүүл мэнд 1 дүгээрт гэсэн мөртөө төсөв мөнгө олигтой нэмэгдэхгүй. Яг ковид, ковидын үед нэг ДНБ-ий 4 хувьд хүрсэн юм. Тэгээд одоо буцаад 3 хувьдаа хүрчихсэн. Олон улсын тооцоо судалгаагаараа ДНБ-ий доор хаяж 6 хувь, ЗГ-ын нийт санхүүжилтийн доор хаяж 12 хувьд хүрэх ёстой байтал манайх өнөөдрийн байдлаар 9 хувьтай байгаад байгаа юм. Тэгээд бид ер нь макро эдийн засгийнхаа байдлыг харж байгаад боломжтой бол 6 хувьд нь хүргээч. Үнэхээр эдийн засгийн нөхцөл байдал боломж муутай хүнд байвал жилдээ ДНБ-д эзлэх хувийг нэг хувиар нэмэгдүүлээч гээд ирэх оны төсвийн төсөөлөлд бид дор хаяж 4 хувьд хүргэх ийм байдлаар төсөөллөө өгчихсөн байж байгаа. Тэгээд 28 он гэхэд бид яг олон улсынхаа жишгийн доод хэмжээ буюу ДНБ-ий 6 хувь, ЗГ-ын нийт зардлын 12 хувьд хүргэнэ гэдэг ийм тооцооллоор Эдийн засгийн хөгжлийн яам, Сангийн яамд энэ саналуудаа хүргүүлээд.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуулт асууя. Алга байна. Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуулт асууя.

Л.Соронзонболд: Бүгдэд нь өглөөний мэнд хүргэе. Энэ төсвийн хүрээний мэдэгдлийг ингээд танилцуулгыг уншихаар уул уурхайн салбарт хэрэгжиж байгаа энэ мега төслүүд их чухал гээд заагаад байдаг. Гэтэл эдгээр мега төслүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай байгаа санхүүжилтийг тусгах энэ төсвийн орон зай ер нь байгаа юм уу гэдэг ийм асуулт байгаад байгаа юм. Тэгэхээр энэ 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэлд мега төслүүдээс хэдийг нь хэдэн хувийн гүйцэтгэлтэй гэж хэрэгжүүлнэ гэж харж тооцсон бэ? Төслийн, жишээлбэл газрын тосны үйлдвэр байна. Газрын тосны үйлдвэрийн хэрэгжилтийн гүйцэтгэл хэдэн хувьтай гэж тооцож байгаа юм бэ? Нөгөө яг гүйцэтгэл хийгээд байгаа байгууллага нь болохоор 50 хувьд хүргэж болно гэж бодоод байдаг. Гэтэл манай төсвийн хүрээний орон зай нь болохоор хэдэн хувийн 20 хувьтай юм уу, 10 хувьтай байлгахаар ингээд нөхцөл байдал нь байгаад байх шиг байгаа юм. Тэгээд энэ дээр нэг тайлбар өгөөч гээд.

Тэгээд энэ өрийн удирдлагын гүйцэтгэлтэй холбоотойгоор нэг асуудал байгаад байна. 2023-аас 2024 онд Өрийн удирдлагын зөвлөл ингээд хуралдаагүй гэсэн ийм тайлан байна лээ. Тэгэхээр энэ хуралдаагүй шалтгаан нь юу байсан бэ гээд 1 дүгээрт? 2 дугаарт болохоор энэ 2026-аас 28 оны төсвийн хүрээний мэдэгдэл дээр энэ хувилбаруудаас сонголт хийсэн байх ёстой. Тэгэхээр энэ хувилбаруудаас яагаад энэ хувилбарыг сонгосон бэ гэдэг энэ шалтгаанаа тайлбарлаач гэж асуумаар байна.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Лувсаннямын Гантөмөр сайд хариулт өгнө.

Л.Гантөмөр: Тэгэхээр бид гадаад эх үүсвэрийн хөрөнгө оруулалтаар 2, 3 төслөө явуулж байгаа. Энэний нэг нь газрын тосны үйлдвэр байгаа, нөгөөдөх нь Эрдэнэбүрэнгийн цахилгаан станц. Энэ 2 дээр нэлээн том хөрөнгийн ачаалал ирнэ. Тэгээд бид энэ 25 юу, 26, 27, 28 онд нийлээд 8,1 их наяд төгрөгийн гадаад эх үүсвэрийг дайчлах гэдэг ийм төлөвлөлтийг хийж байгаа. Тэгээд энэ төлөвлөлт дотор бүрэн багтах бололцоотой. Зүгээр бусад төслүүдээ хойшоо тавьж явна гэж ойлгоорой. Тэгэхээр нөгөө талдаа тухайн үйлдвэрлэлийн маань эрчимтэй байдал, баталгаатай байдал, сайн төлөвлөлт гэдэг зүйл хамгийн чухал байгаа юм. Тийм учраас энэ явна гэж ойлгох хэрэгтэй.

Нөгөө талдаа бид мега төслүүдийн эрчимжилт өөрөө эдийн засгийн өсөлтийг 6 хувьд байлгахад чухал нөлөөтэй байна гэж байгаа юм. Энэ түрүүн Мөнхсоёл гишүүн асууж байна лээ. Мега төслүүд чинь ер нь явах нь эргэлзээтэй байдлыг манай Тогтвортой байдлын зөвлөл өгч байна шүү. Тэгээд эргэлзээтэй байдал юу вэ гэвэл хийж явж байгаад ямар нэгэн эсэргүүцэлтэй тулгарахаараа зогсдог ийм манай өөрийн дутагдал байгаа байхгүй юу манай ЗГ-ын уламжлалт. Тэгэхээр энэ удаа арай өөр гэж харж байгаа юм. Хамтарсан ЗГ гэж харж байгаа юм. Хамтарсан ЗГ учраас аливаа нэг саад бэрхшээлийг давж гарах тэр чадамж чансаа нь бусад өмнөх Засгийн газруудаасаа илүү байх болов уу гэдэг нь сая жишээлбэл энэ Гашуунсухайт-Ганцмодны хил холболтын асуудал дээр харагдаж байна шүү дээ. Тийм учраас бид энэ хил холболтын төсөл байна. Мөн эрчим хүчний Эрдэнэбүрэнгийн цахилгаан станцын ажил энэ зун эхэлчихнэ. Дээр нь газрын тос боловсруулах үйлдвэрлэл байна. Дээр нь Орано компанийн төслийн

ажил эхлээд явж байна, ажил нь явж байгаа. Кокс химийн үйлдвэрээ энэ зундаа эхлүүлчихнэ. Ер нь зэс боловсруулах үйлдвэрийн төсөл бэлэн байгаа шүү. Зүгээр хөрөнгийн төсвийн, төслийнх нь санхүүжилтийн хэлбэрийг эцэслэж шийдээгүй байгаа. Түүнээс бусад нь асуудалгүй бэлэн байгаа төсөл энэ байгаа гэх мэтчилэн энэ эрчим хүч, үйлдвэрлэлийнхээ төслүүдийг түлхэхэд энэ 6 хувиа бид энэ төслүүдийг явуулна гэдэг сонголт нэг 6 хувь.

Өөр дээшээ өөдрөг бодож болно, өөдрөг төсөөлж болно. Тэгэхдээ тэр өөдрөг төсөөллөөс бид арай хямгатай явъя л гэж байгаа юм. Дэлхийн зах зээл өөрөө их савлагаатай байгаа учраас айхтар өндөр түвшинд тооцоололгүйгээр яг тогтвортойгоор нөгөө бидний 28 онд очих цэг рүүгээ бид алхаж байгаа гэдгийг танд хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Отгоншарын Батнайрамдал гишүүн асуулт асууя.

О.Батнайрамдал: Та бүхэндээ өглөөний мэнд хүргэе. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026, цаашлаад 27-гоос 28 оны төсвийн төсөөллийн тухай бид ярьж байна. Тэгэхээр ер нь дараагийн богино, дунд хугацаандаа дэлхийн эдийн засаг хаашаа чиглэж байгаа, бүтээгдэхүүний үнэ хаашаа явж байгааг бид заавал авч үзэх хэрэгтэй л дээ. Ер нь дэлхийн эдийн засгийн төсөөллийг аваад үзэхээр Дэлхийн банкны судалгаагаар дэлхийн эдийн засаг 25, 26 ондоо 2,7 хувьтай өснө гэж нэг ёсондоо өөрсдийнхөө forecast-аа бууруулсан дүр зураг харагдаж байгаа. Европ нэг хувиар өснө гэсэн. Нэг ёсондоо өсөлтүүдийг ер нь цаашдаа буулгасан, дараагийн 3 жилдээ тийм өнгөтэй дүр зураг харагдахгүй байгаа юм. Тэгэхэд бидний төсөөлж байгаа дунд хугацаандаа бид ДНБ-ий бодит өсөлт 6, цаашаа өсөөд эсрэгээрээ 6,5, 6,5 хувьтай өснө гэсэн ер нь нэлээн өөдрөг төсөөлөлтэй хараад байна л даа. Бусад хөгжиж буй Монголтой ойролцоо орнуудын дараагийн 3 жилийн ДНБ-ий өсөлтийг харахаар 4 хувьтай л харагдаж байгаа юм л даа. Тэгэхээр энэ нэлээн өөдрөг төсөөллийг та бүхэн 1 дүгээрт юу гэж бодож байгаа вэ гэж асуумаар байна.

2 дугаарт яах вэ Монгол Улсын 3Г талаасаа яах вэ өөрийнхөө өрийн удирдлагаа сүүлийн 4, 5 жил нэлээн сайн manage хийж авч явсан. Гэхдээ нэг зүйлтэй харьцуулмаар байна, Оюу толгой төсөлтэй харьцуулмаар байна. Оюу толгой төсөл дээр Монгол Улсын эдийн засаг дээр байгаа зээлээс илүү том зээл явж байгаа 20 орчим тэрбум долларын зээл. Тэрний хүү нь хэд гээч Оюу толгой төсөл дээр байгаа харилцан хамаарал бүхий этгээдийн зээл гэж бид бүхэн ярьдаг. Нэг ёсондоо Рио Тинтоогоос авч байгаа зээл 11,1 хувийн хүүтэй байдаг. Энийг сая жишээлбэл хамгийн сүүлд Улаанбаатар хотын босгосон бондын хүү 7,75 гэж гарсан байгаа юм. Нэг ёсондоо бид нарын энэ 2 хүүгийн зөрөө 3,35, Оюу толгой төсөл дээр бид бараг 20 орчим тэрбум доллар дээр тэгэхээр бид илүү 3,35 хувийн хүүгээр илүү төлж байгаа ийм дүр зураг харагдаад байгаа байхгүй юу. Энэ бол макро эдийн засагтаа нэлээн нөлөөлөх зүйл шүү дээ. Ер нь Оюу толгой төсөл дээр ч гэсэн зээлийн хүүг дахин авч үзэх 7 жил тутам дахин авч үзэх хувь нийлүүлэгчдийн зээлийн гэрээн дээр туссан байдаг. Тэр жил нь 2025 онд тохиож байгаа. Тэгэхээр энэ тал дээр ямар байр суурьтай байгаа юм болоо гэсэн 2 багц асуултыг асуугаад хариултаа авч байгаад тодруулъя.

Д.Амарбаясгалан: Гантөмөр сайд хариулт өгье.

Д.Гантөмөр: Яах вэ бид зөвхөн нүүрс дээр авч байгаа цохилтоо эдийн засгийн өсөлттэйгөө шууд уяж хараад хэрэггүй л дээ. Дэлхий нийт өөрийнхөө эдийн засгийн өсөлтийг бууруулж харж байгаа нь тодорхой байгаа. Маш их эрсдэлийг хэлж байгаа. Жишээлбэл сая 90 хоногийн хугацаанд Хятад улс Америк улстай хийх худалдааныхаа татварыг 115 хувиар бууруулахад гарч байгаа эффект эргээд Хятадын эдийн засгийг 0,5 функтээр өснө гэдэг ийм прогноз өгч байгаа юм. Юу гэсэн үг вэ гэхлээр Англи, Америкийн худалдааны хэлэлцээрийн дараа тэр эдийн засгийн тооцоолол хөдөлж байна. Тэгэхээр маш их бужигнаантай байна гэдгийг л харж байгаа юм.

Бид дотоод нөөцөө бүрэн дайчилж чадвал бид жишээ нь нүүрсний үнийг 80 доллар, 77 доллар гээд ингээд даруу төлөвөөр тооцож байгаа шүү дээ. Бидний өөрийнх нь үйлдвэрлэх чадвар, дээр нь нэвтрүүлэх чадвар асар их нэмэгдсэн шүү гэдгийг бид харж байгаа. 6 хувиас дээш өсөөд илүү халалт явбал өөрөө энэ эдийн засаг нь паникт орох юм байна гэдэг зүйл харагдаж байгаа юм. Тийм учраас их тийм 5-аас 6 хувийн өсөлт гэдэг өөрөө манайд их тогтвортой байх юм байна. Айхтар халалтгүйгээр болох юм байна гэдэг ийм зүйл байгаа юм шүү 1.

2 дугаарт ер нь Оюу толгой төсөл эхлэхдээ хамгийн өндөр эрсдэлтэй төслүүдийн нэг байсан. Улс төрийн нөхцөл байдал тогтворгүй, гэрээ хэлэлцээр нь баталгаагүй, олон улсад байгаа нэр хүнд нь ямар хэмжээнд байлаа. Тэр үед олдож байсан мөнгө үнэтэй. Одоо бол Оюу толгой төсөл баталгаатай, татварынхаа маргаануудыг шийдчихвэл энэ ажил хийгээд сурчихсан тэр 1км-ийн доороос металлаа гаргаад, бүтээгдэхүүнээ гаргаад чадаж байна. Технологи нь шийдэгдсэн. Тийм учраас таны хэлдгээр зээлийнхээ хүүг бууруулаад явах бололцоотой, зээлийнхээ эх үүсвэрийг ч гэсэн солих бололцоотой. Тэгэхдээ энэ Риогийн хэлэлцээр хийх асуудал гэж харж байгаа. ЗГ буюу Засаг манай 34 хувийг төлөөлж байгаа хүмүүст бид тийм л чиглэл өгнө. Зардал бууруул, зардал бууруулахад хамгийн том нь хүүгийн өртөг байгаа, өртөг бууруулах хэлэлцээр хийгээрэй гэж. Тэгэхдээ манай ЗГ-ын 7, 74 гэдэг яг үүлэн чөлөөний нараар бид нэг тийм тоо авсан шүү. Энэ бол тогтвортой байнга манай бондын хүү ийм байх юм байна гэсэн зүйл биш. Тийм учраас бид энэ нөгөө айхтар тарифуудын зодоон эхлэхийн өмнө хөдөлсөн. Мэдээж манай үнэлгээ байнга л хөдөлнө. Тэгэхдээ бид нарын өнөөдөр ингээд оруулж байгаа төсвийн хүрээ өөрөө Монгол Улсын ЗГ, Монгол Улсын Их Хурал нэлээн.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Батнайрамдал гишүүн тодруулж асууя.

О.Батнайрамдал: Тантай санал нэг байна л даа. 2009 онд анх гэрээ байгуулж байх дүр зураг өөр байсан. Өнөөдрийн дүр зураг өөр. Бид сая зээлжих зэрэглэл хүртэл сайжирсан шүү дээ. Тэгэхээр энэ ч гэсэн зээлийн хүүд шууд нөлөөлнө. Тэгэхээрээ зээлийн тэр хувь нийлүүлэгчдийн гэрээгээр бид зээлийн хүүгээ дахин авч хэлэлцэх 7 жилд нэг удаа дахин авч хэлэлцэх эрх бид нарт байдаг. Тэгэхээр энэ эрхээ 2025 онд тохиож байхад заавал хэрэгжүүлээрэй гэж байгаа юм.

2 дугаарт ер нь Оюу толгой төсөл сая 26 оны хөгжлийн төлөвлөгөө дээр ч гэсэн туссан байна лээ. Ер нь цаашдаа орлого сайжирч байгаа, ер нь 4-өөс 5 тэрбум долларын орлого олох юм. Гэхдээ энэ нь Монгол Улсын эдийн засагт шууд өндөр эерэг нөлөөтэй гэсэн нэг дүгнэлт хийгээд байна лээ л дээ. Яг гаднаас орж ирэх мөнгөн урсгал нь тэгж нэг их өөрчлөгдөхгүй шүү дээ, 1,5-аас 1,7 тэрбум л

байхгүй юу. Энэ бол цаашдаа нэг их өөрчлөгдөх тоо биш л дээ. Тэгэхээр энэ бодолт дээр хэрхэн нөлөөлсөн бэ гэж Жавхлан сайдаас асуучихмаар байна.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн асуулт асууя.

М.Бадамсүрэн: Хамгийн том асуудал энэ үнийн өсөлт инфляцтай холбоотой. Энэ дээр ер нь бие даасан яг ямар бодлогыг ирэх хугацаанд хэрэгжүүлэх вэ? Ер нь ингээд сумын түвшинд, хөдөө орон нутгийн түвшинд очиж байгаа бараа, бүтээгдэхүүний үнэ асар өндөр байгаа. Тэгээд энэ дээр ямар нэгэн хийгдсэн судалгаа байгаа юу? Энэ чиглэлээр ер нь ямар арга хэмжээ хийхээр төлөвлөсөн бэ? Тээвэр логистикоосоо болж байна уу эсвэл татвараас болж байна уу энэ дээр судалсан зүйл байна уу?

2 дугаарт нь энэ инфляц гэдэг зүйл яг үнэндээ тооцож байгаа аргачлал нь зөв байгаа юу? Яг бодит байдал дээр юмны үнийн өсөлт маш өндөр байгаа. Тэгээд инфляцыг бууруулах талаар зөвхөн ингээд Монголбанканд ер нь гол нь даатгасан эндээс нэг бодлогын хүүг 2 хувиар нэмэгдүүлсэн нэг ийм л арга хэмжээ аваад яваад байх юм уу эсвэл энэ инфляцыг бууруулах талаар ер нь тусдаа бие даасан, шаардлагатай бол хууль, ер нь бодлогын ямар арга хэмжээнүүд авахаар ирэх энэ төсвийн хүрээний мэдэгдэлд тооцож байгаа вэ? Энэ инфляцын дарамт гэдэг зүйл үнэхээр маш өндөр байгаа шүү яг үнэндээ. Цалин 6 хувиар өсгөсөн ч гэсэн инфляцыг хязгаарлах, бууруулах чиглэлээр яг дорвитой бодлого би хийхгүй байна гэж миний хувьд харж байгаа. Тийм учраас энэ дээр ямар бодлого хэрэгжүүлэх вэ?

3 дахь нь энэ эдийн засгийн яг эрүүл бүтэц бол хувийн хэвшилд тулгуурлах ёстой. Тэгээд хувийн хэвшилд тулгуурлах чиглэлээр олон ажлыг өмнө нь хэрэгжүүлж Засгийн газар, Сангийн яам оруулсан боловч ялангуяа ингээд ийм төрийн, орон нутгийн төрийн өмчөөр гүйцэтгэж байгаа чиг үүргийн хүрээнд энэ ажилтан, албан хаагчдын эсэргүүцлээс болоод энэ зогссон. Тэгэхээр энийг цаашид энэ шинэчлэлийг хэрэгжүүлэх, хувийн хэвшилд энийг тулгуурлаж хариуцуулах, төсөв дээр энэний нэгж тарифыг ашигтай байх хэлбэрээр, гэхдээ төрд байснаас хэмнэлттэй байх хэлбэрээр зохион байгуулах энэ шаардлагыг хэрэгжүүлэхийн тулд тэтгэмжийг тухайлбал жилээр олгох сонголттой байдаг юм уу, дараа нь хувийн хэвшилд шилжсэн тэр албан хаагчдыг хэвийн тогтвортой үйл ажиллагаа явуулахад нь энэ баталгааг нь гаргаж өгсөн хэлбэрээр байдаг юм уу ингээд энийг их тодорхой болгож өгөх ийм шаардлагатай байна гэж үзэж байгаа. Ер нь хувийн хэвшилд тулгуурлаж хөгжих чиглэлээр яг ямар дорвитой реформ хийх вэ гэдэг?

Дараагийнх нь энэ төсвийн урсгал зардалтай холбоотой асуудал байгаа. Урсгал зардлыг бууруулахгүй бол үнэхээр болохгүй байна. Яг үнэндээ татвар, нийгмийн даатгалын шинэчлэлийг хийж хэрэгжүүлнэ. Энийг зорьж байгаа гэж ЗГ мэдэгдэж байгаа боловч энэ урсгал зардлыг үлэмж хэмжээгээр бууруулах энэ бодлогыг зоригтой шинэчилж хийхээс өөр арга байхгүй. Ингээд хараад байхад энэ ингээд л нэг ийм нэгдсэн хурал зөвлөгөөн, тэгээд гадаад, дотоод томилолт дэндүү их байгаа шүү дээ яг үнэндээ бол. Тэгэхээр энэ гадаад томилолтыг зоригтой маш их хэмжээгээр бууруулах хэрэгтэй. Шаардлагатай бол тэгээд Ерөнхий сайд гол, гол сайд нь яваад, тэгээд бусад хүмүүс нь яваад байх тийм шаардлага байгаа юм уу олон арваараа? Тэгээд энэ зүйлээс эхэлнэ, тэгвэл том хэмжээний ийм орон зай гарч ирэх боломж бүрдэнэ гэж үзэж байгаа. Тэгэхээр энэ дээр ер нь яг тодорхой

ямар шинэчлэл хийхээр бэлтгэж байгаа вэ? Энэ эдийн засгийн асуудал гэдэг өрх айл хүн бүрд хамааралтай зүйл байгаа.

Дараагийнх нь энэ хувийн хэвшлийг дэмжихийн тулд энэ жижиг өрхийн бичил бизнесийг дэмжих чиглэлээр энэ хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг яаж нэмэгдүүлэх вэ? Энийг ерөөсөө нэмэгдүүлэх чиглэлээр нэг төсвөөс ийм хараат байдлаар яваад байгаа юм. Энийг жоохон чөлөөлж, ийм хөрөнгө, эх үүсвэр байгаа бол энийгээ эргэлтэд оруулж, энэ хүн бүр чинь нэг өөрийн чаддаг, чаддаг зүйлээ хийж хэрэгжүүлж байж эдийн засагтаа хувь нэмэр оруулна шүү дээ. Тэгэхгүй бол бүгдийг ингээд төр өөрөө л харах юм шиг, өөрөө зохион байгуулах юм шиг бүх юманд ингээд оролцсон байдлаар яваад байгаа энэ эдийн засгийн бүтцийг бүтнээр нь нэлээн өөрчлөх хэрэгтэй гэж бодож байгаа. Би санаж байна жижиг, дунд үйлдвэрлэлийн зээл гээд нэг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Лувсаннямын Гантөмөр сайд хариулт өгье.

Л.Гантөмөр: Тийм. Энэ үнийн өсөлт сүүлийн 2 жилийн хугацаанд явж байгаа өсөлтийг хүмүүс их тодорхой анзаарч байгаа. Юу анзаарагдаж байгаа вэ гэхлээр мөнгөний нийлүүлэлт нэмэгдэхээр үнэ өсдөг юм байна. Хэрэгцээ нь нэмэгдээд, эрэлт нь нэмэгдээд, эрэлт нь тодорхой болчихоор үнэ өсдөг юм байна гэдгийг бүгдээрээ харж байгаа. Импортын хэмжээ ч гэсэн энийгээ дагаад нэмэгдчихдэг юм байна лээ. Бид жишээлбэл 24 оны импортын өсөлт 26 хувьтай байсан шүү дээ. Тэгээд 26 хувийн өсөлтийн импорттой улс одоо 11, юу 25 онд 10 хувийн өсөлт байна уу гэж харж байгаа. Энэнээс бага хувиар импортыг бид хязгаарлах тухайд онцгойлон бодлого барих учиртай. Ингэж байж бид үнийн өсөлтийг, валютын ханшийн тогтвортой байдлыг цаашаагаа хадгалж явна.

Жишээлбэл Дарханд ямар нэгэн байдлаар хүн болоод тодорхой яам, тамгын газар очиход л тэнд байгаа орон сууцын үнэ өсчхөж байгаа шүү дээ. Ийм байдлаар энэ юу хэлж байна вэ гэхлээр худалдан авагч нь чадалтай болох тусам л нөгөө талдаа бүтээгдэхүүнийхээ үнийг өсгөөд байдаг нэг ийм зүйл байгаа. Ер нь бид яг ямар бараа, хаанаас аваад Монгол Улсад хэдээр зараад байгаа тухай бүрэн хэмжээний судалгаа хийж байгаа. Бүрэн хэмжээний судалгаа. Төсөв өөрөө яг энэ үнийг өсгөдөг гол хэрэгсэл болж байна гэдэг тантай санал нэг байна. Тийм учраас төсвийн худалдан авалтыг хэрхэн тэр 1000 дахин, 100 дахин өссөн үнээр биш хийх вэ гэдэг асуудал байгаа. Жишээлбэл маск 50 төгрөг байна Эрээнд, манайд 500 төгрөг байна. 100 төгрөгөөр авсан маскаа манайхан 1000 төгрөгөөр шахаж байна. Эмнэлгийн ор тэнд ямар үнэтэй байна, манайд ямар үнэтэй байна гээд бүх харьцуулалтыг манай яам хийж байгаа.

Тэгэхээр одоо төсвийн худалдан авалтыг бид хэрхэн хямд үнээр хийх вэ, энэ худалдан авалт хямд явбал, нөгөө эрэлт талынхаа зохицуулалтыг бид хийж чадвал үнийн өсөлт тогтвортой байх ийм бололцоо байна. Тийм учраас урсгал зардлыг бууруулахдаа бид энэ үнийн зохицуулалт, худалдан авалтын хэлбэрээ харж байж, дамын наймаанаас салж байж хийнэ гэдэг ийм зорилттойгоор ажиллаж байгаа. Яг энэ хүрээндээ бид цахим засаглалаа илүү төгөлдөржүүлнэ. Ингэж чадвал бид төрийн албаныхаа тоог цөөлнө. Цөөлсөн төрийн албан хаагчид дээр хийх программыг та санал болгож байна. Энэнтэй санал нэг байна. Энэ дээр тодорхой программ хэрэгжүүлнэ.

Дээр нь тэр ЖДҮ зээл. Бид энэ банкнуудаар зээл өгүүлээд, тэрнийхээ хүү болоод, даатгал дээр ажиллаж байгаа нь аягүй сайн хувилбар болчихсон, маш сайн хувилбар энэ. Тийм учраас.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Болдын Жавхлан Сангийн сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя. Ер нь гишүүний гаргаж байгаа зарчмын саналтай би мянган хувь санал нийлж байна. Монгол Улсын төсвийн 75 хувийг нь урсгал зардал эзэлдэг юм, 25 хувь нь хөрөнгө оруулалт. Энэ 75 хувийн 60 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, цалин, халамж байдаг. Үлдсэн 15 хувь нь л үйл ажиллагааны зардал. Саяын таны ярьж байгаа гадаад томилолтын зардал бүүр бага 2,5 хувийг л эзэлдэг. Тэгэхээр бид урсгал зардал дээрээ дорвитой хэмнэлт хийе, дорвитой өөрчлөлт хийе гэвэл цалин, тэтгэвэр, тэтгэмж, энэ халамж дээрээ л дүн шинжилгээ хийж, үүн дээрээ л бүтцийн өөрчлөлт хийх ёстой юм байгаа юм. Тэрнээс биш урсгал зардал дээрээ бид бүсээ чангалаад, чангалаад таны саяын хэлж байсан шиг, зорьж байсан шиг тийм дорвитой хэмнэлт гарахгүй юм байгаа юм 1-д. 2-т үүнийг яаж багасгах вэ гэхээр ийм байгаа. 2025 оны төсөв батлагдах үеэр дагасан тогтоол дээр ЗГ-т нэг үүрэг өгсөн байгаа.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Жавхлан сайд гүйцээж хариулъя.

Б.Жавхлан: Төсвийн урсгал зардлыг нэмэгдүүлээд байгаа энэ хууль эрх зүйн орчны талаар танилцуулга оруулж ир гээд. Ингээд танилцуулгаа Улсын Их Хуралд Засгийн газар хүргүүлсэн байгаа шүү. Энэ дээр та бүхэн маань нэг ажиллаад өгөөч. Түүн дээр гол санаа юу байгаа вэ гэхээр 208 хуулийн 1024 заалтаар Монгол Улсын төсвийн урсгал зардлыг хуульчилчихсан байдаг. Өөрөөр хэлбэл бараг л бүх ажлыг төрийн чиг үүрэгт оруулаад багтаагаад, төсөвтөө багтаагаад, багтахгүй цаана нь байгаад дахиад 14 их наяд төгрөгийн зардал энэ хаалганы цаана хүлээгээд байж байгаа. Тэгэхээр энэ бүгд дээр дүн шинжилгээ хийгээд, үүн дээр бүтцийн өөрчлөлт хийж, энэ урсгал зардлыг хуулиар нь багасгаж байж, бид төсөв дээрээ дорвитой өөрчлөлт хийж чадна. Тийм учраас энэ дээр Улсын Их Хурлын гишүүд маань энэ ЗГ-аас хүргүүлсэн санал дээр, энэ дээр маш сайн анхааралтай ажиллаад, энэ хуулиудыг эрэмбэлж зогсоохыг нь зогсоож.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Бадамсүрэн гишүүн тодруулж асууя.

М.Бадамсүрэн: Энэ хүн бүрийн хийж чаддаг юмыг нь хийхэд нь л сайн дэмжмээр байгаа юм. Тэгэхгүй бол манай энэ хамгийн сүүлд хийсэн судалгаагаар Монгол Улсын эдийн засаг буюу дотоодын бүтээгдэхүүнд жижиг, бичил бизнесийн эзэлж байгаа хувь хэмжээ ердөө 5,5 хувь гэж гарч байгаа байхгүй юу. Гэтэл олон улсын дундаж 40 ба түүнээс дээш байгаа. Тэгээд эндээс харагдаж байгаа зүйл нь ингээд ажилгүйдэл их байна л гэж яриад байдаг, хүн бүр, өрх бүр хийж чадах юмыг нь яаж хөнгөлөлттэй зээлийн бодлогоор, борлуулалтын бодлогоор, бусад бодлогоор яаж дэмжих вэ гэдэг орхигдоод байгаа юм. Энийг яг ямар бодлого ирэх онуудад барих вэ?

2 дугаарт нь энэ хөнгөлөлттэй зээлийн хүртээмж бага байгаа гэдэг нь юунаас харагдаж байна гэхээр жилдээ нэг удаа конкурс зарлаж байгаа юм шиг ганцхан удаа жижиг, дунд үйлдвэрлэлийн зээл олгодог. Жилд ганц удаа шүү дээ.

Гэтэл бусад орнуудад энэ хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэр нь тогтмол байж байдаг, шаардлагаа хангасан иргэн, өрх, бичил жижиг бизнес нь очоод авдаг энэ боломжийг бүхэл бүтэн Монгол Улс яагаад бүрдүүлж чадахгүй энэ олон жил.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн асуулт асууя.

Л.Мөнхбаясгалан: ЗГ-ын 14 мега төслийг ихэнх нь төр, хувийн хэвшлийн түншлэл, тэгээд гадаадын хөнгөлөлттэй зээл байдаг. Тэгэхээр Жавхлан сайдаас асууя. Энэ гадаадаас авч байгаа урт хугацааны, хатуу зарчимтай, хөнгөлөлттэй зээлүүдээ төсөв рүүгээ оруулаад, буцаад нөгөө том төслүүдээ санхүүжүүлэхдээ алдагдалгүй төсөв, төсвийн таазандаа яг тохируулаад дусал дуслаар өгч байгаа нь хэр оновчтой вэ? Энийг өөрчлөхөөр зарим гишүүд хуулийн төсөл, анхдагч хуулийн төсөл санаачилсан байгаа. Та дэмжиж байгаа юу, энэ бодлыг, энэ бодлогыг хийх ёстой юу?

Дээрээс нь өнгөрсөн жилийн 2025 оны улсын төсвийг баталж байхад эрүүл мэндийн салбар үнэндээ уналтад орсон. Бараг мөнгө гаргадаггүй. Гэтэл энд хүн төвтэй байна гээд тэргүүлэх чиглэл дээрээ тавьчихсан байдаг. Эрүүл мэндийн салбарт ямар бодлого хэрэгжүүлэх вэ? Эрүүл мэндийн салбар гэдэг дандаа тийм сэтгэл хөдлөл, хүний эмзэглэл дээр явмааргүй байна. Өнгөрсөн жил 40 гишүүн гарын үсэг зурж байж хавдар дээр Хавдрын эмнэлэг дээр мөнгө тавиулж байсан. Одоо тэрийг халаад ямар бодлого хэрэгжүүлэх вэ?

Дээрээс нь Номин сайдаас асуулт асууя. Үндэсний сөрөн тэсвэрлэх чадвар гэдэг ганцхан Батлан хамгаалах яам дээр байдаг гэж би боддоггүй цэрэг зэвсэг дээр. Үндэсний сөрөн тэсвэрлэх чадвар гэдэг Монгол хүний оюун ухаан дээр, өв соёл дээр, соёл урлаг дээр тогтдог байх ёстой. Өнгөрсөн жил таны бусдад өөрийнхөө салбарын бодлогыг таниулж чадаагүйн улмаас таны төсөв дээрээс харамсалтай мөнгөнүүд танагдаж байсанд би их харамсалтай байсан л даа. Тэгэхээр өв соёлоо, оюун ухаанаа, соёл урлагаа экспортлохын тулд, энийг үнэд оруулахын тулд Соёлын яамнаас ямар бодлого чиг баримжаа баримталж ажиллах вэ?

Д.Амарбаясгалан: Мөнхбаясгалан гишүүн маш үлгэр жишээ асуулт асууж байна. Нэр цохож асууж байгаа юм. Энэ их зөв юм байгаа юм. Ер нь асуулт тодорхой, хариулт тодорхой байна гэдэг бидний ажлыг илүү үр бүтээлтэй, үр бүтээмж өндөртэй байх үндсэн суурь шалтгаан нь болно шүү гэж гишүүддээ хэлж байгаа юм. Жавхлан сайд эхний асуултад хариулъя.

Б.Жавхлан: Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя. Таны эхний асуултыг би 100 хувь дэмжиж байгаа шүү, 100 хувь дэмжиж байгаа. Та дэмжиж гарын үсэг зурсан байна лээ. Хэвлэлийн хурал дээр орж байгаа харагдсан. Тэгэхээр энэ дээр ийм л юм байгаа юм. Бид 14 мега төсөл гэж байна. Эдийн засаг маань сүүлийн жилүүдэд маш хурдтай өсөж тэлж байна, ингэхээс ч аргагүй, цаашдаа ч илүү тэлэх ёстой, илүү хөгжих ёстой. Энэ нь маш хүртээмжтэй айл өрхөөр орох ёстой юм байгаа юм. Ингэхийн тулд бид хэд хэдэн томоохон зээл, хөрөнгө оруулалтуудыг авч байгаа. Энэ дотор манай нэг төсвийн дүрэм байдаг, 30 жилийн өмнө батлагдсан төсөв маань гадаадын зээл, тусламжийнхаа зарцуулалтыг нь, өөрөөр хэлбэл ашиглалтыг нь төсөв дотроо бичиж явдаг. Тэгсэн

мөртөө нөгөө талдаа авч байгаа эх үүсвэрээ орлого талдаа бичдэггүй байхгүй юу. Тэгэхээр энэ маань өөрөө цаашдаа энэ гадаад зээлийн ашиглалт улам томрох тусмаа төсөв дотор маш том хэмжээний орон зай эзэлнэ.

Тэгэхээр бид өөр бусад төсвийнхөө саяын таны ярьдаг эрүүл мэндийн зардал багасна, боловсролын салбарын зардал багасна, бусад сургууль, цэцэрлэгийн хөрөнгө оруулалтууд багасна. Тийм учраас цаашдаа бид өөрөөр хэлбэл эх үүсвэртэй, эх үүсвэр нь буцаагаад түүгээрээ зарлагаддаг, дараа нь өөрөө тэр төсөл нь өөрөө өөрийгөө төлөөд явдаг ийм шалгуурууд хангасан төслүүдийг бид төсөв дотроо багтаана, төсөв дотроо багтаана. Төсөв гэдэг маань өөрөө энэ чинь маш олон үзүүлэлтүүдээс бүрддэг. Энэ дотор зээлтэй холбоотой бидний хамгийн харж биелүүлж явж байх ёстой зүйл бол зээлийн өрийн тааз юм байгаа юм, ЗГ-ын өрийн тааз. Төсвийн хүрээний мэдэгдэл дээр жишээ нь хууль дээрээ 60 гэж байж байхад төсвийн хүрээн дээр бид бүүр 50 болгоод багасгая гээд ороод ирчихсэн байгаа юм, 50 хувь дотроо. Таны санаачилсан тэр хууль энэ 50 дотроо хамаагүй тэр доор багтаж байгаа.

Тийм учраас бид өрийн тааз дотроо багтаж амьдраад, энэ том авсан энэ өр зээлүүдийнхээ ашиглалтыг нь, үр өгөөжийг нь сайжруулаад, ялангуяа энэ таны тэр гишүүдийн маань санаачилсан тэр 3 төсөл юм байгаа юм. Нефть боловсруулах үйлдвэр, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц, Сэлбэ сэргэлт. Энэ 3 төслийг бушуухан дуусгаад ашиглалтад оруулаад, эргэлтэд оруулах хэрэгтэй байгаа юм. Нэг төслийн жишээ авъя. Нефть боловсруулах үйлдвэр жилд 2 тэрбум долларыг бид гадагш нь төлдөг бол ядаж 50 хувийг нь авч үлддэг болох гэж байгаа л ийм төсөл шүү дээ. Тэгэхгүй одоо бид ингээд нэг жил, жил ингээд дусаагаад, дусаагаад энэ үйлдвэрээ ашиглалтад оруулъя гэвэл 10 жил хэрэгтэй байгаа. Өчигдөр бид юунаас Энэтхэгээс ирсэн төслийн дагуу ирсэн хүмүүстэй ирж уулзлаа, хугацаандаа ашиглалтад оруулна гэж байна. Ганцхан та нар санхүүжилтээ битгий тасалдуулаарай. Тэгвэл бид 28 оны 1 дүгээр улиралд багтаагаад ашиглалтад өгөхөд ямар ч саадгүй байна, бид газар дээр нь ирээд үзлээ гэсэн. Үнэхээр бид үндэсний тийм шатахуунаа ашиглаад эхэлье гэж байгаа бол бушуухан энэ зээлээ.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Чинбатын Номин сайд асуултад хариулъя. 1 минут.

Ч.Номин: Мөнхбаясгалан гишүүнтэй маш санал нэг байна. Манай Соёлын салбарын хувьд ер нь бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэх, Монгол урлаг дэлхийн тайзнаа, соёлын өв дэлхийд гарах, дээрээс нь Соёлын өвийг сэргээн засварлах, хүүхэд, залуучуудын хөгжлийн хөтөлбөр гэх мэтчилэн хөтөлбөрүүдийг тусгаж авч явж байгаа. 2026 он болон 2027, 2028 онуудынхаа ажил дээр. Энэ ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт орсон байгаа. Бидний хувьд бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэх ажил бол нийгмийн соён гэгээрлийг нэмэгдүүлэх хамгийн чухал ажил гэж үзэж байгаа.

Соёлын салбарын хувьд хэдийгээр бид өнгөрсөн онд төсөв дээр таналттай байсан хэдий ч өнгөрсөн 4 жилийн хугацаанд тогтмол төсөв өсөж явсан буюу соёлын орон зайнуудыг нэмэгдүүлэх, Чингис Хаан музейг барих гэх мэтчилэн энэ зүйлүүд дээр хөрөнгө оруулалтууд хийгдээд явж байгаа гэдгийг хэлэх нь зүйтэй болов уу гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулъя, 1 минут.

Б.Жавхлан: Түрүүн Батнайрамдал гишүүн асууж байсан. Тэр Оюу толгой дээр жишээ нь бид хувь нийлүүлэгчдийн зээлийн хүүг эргэж харах, дахин хэлэлцээрт орох энэ асуудлуудаа цаад талдаа тавьчихсан. Тэгээд цаад талаас баг ирээд ингээд хэлэлцээр удахгүй эхлэх юм байгаа юм шүү 1 дүгээрт.

2 дугаарт таны тэр хэлсэн, хэлж анхааруулж байгаа зүйл дээр бид маш сайн анхаарч ажиллах ёстой. Өмнө нь 2018 онд нэг удаа Улсын Их Хурал дээр тийм тогтоол орж ирж байсан юм. Оюу толгойн бүх борлуулалтын орлогыг Монгол Улсын эдийн засаг дотор оруулж дамжуулж байх ядаж, ядаж дамжуулж байх. Гэтэл тэр тогтоол маань батлагдаж чадаагүй харамсалтай нь. Энийг харин сая бид ураны гэрээ Ораногийн гэрээн дээр бид энийг маш сайн анхаарч энэ алдааг давтахгүй байх үүднээс тодорхой хэмжээг, тодорхой хэмжээнд борлуулалтын орлогыг Монгол Улсын банк санхүүгийн байгууллагуудаар, Монгол Улсын эдийн засгаар заавал дамжуулж байх гэдэг ийм заалтыг харин оруулж чадсан байгаа. Тэгэхээр цаашдаа мөн Оюу толгойн асуудлууд яригдах бүрд энэ зүйлийг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн тодруулж асууя.

Л.Мөнхбаясгалан: Төсвийн зардлын реформ хийнэ гээд тэгсэн. Түрүүн Жавхлан сайдынхаар урсгал зардлын бараг 60 хувь нь нийгмийн халамж, тэтгэвэр, тэтгэмжид явж байгаа. 100 хүн, татвар төлдөг 100 хүн тутмын 57 нь халамж авдаг гэсэн. Тэгэхээр төрийн албан хаагчдын цалинг хасах журмаар явах гээд байна уу, төрийн албан хаагчдыг цомхотгох хэлбэрээр үү эсвэл энэ төсвийн урсгал зардал дээр ямар реформ хийх юм бэ? Тэгээд түрүүн нөгөө Эрүүл мэндийн сайд хариулах ёстой юм уу, хэн хариулах ёстой юм эрүүл мэндийн салбар заавал хүний сэтгэл хөдлөл, эмзэглэл нэг тийм хүмүүнлэг сэтгэхүй дээр явмааргүй байна. Энэ яг төрийн бодлого болоод чухал явмаар байгаа байхгүй юу. Энэ дээр яг хэн нь хариулах юм бэ?

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулт өгье, 1 минут.

Б.Жавхлан: Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя. 3 юман дээр л анхаарах ёстой юм урсгал зардлыг хэмнэхийн тулд. 1 дүгээрт хэмнэлт, 2 дугаарт бүтээмж, 3 дугаарт хувийн хэвшил хийж болох зүйлийг хувийн хэвшлээр л хийлгэх хэрэгтэй төсөв дээрээс биш. Ийм 3 чиглэлээр л бид ажиллаж чадваас бид урсгал зардал дээрээ сайн хэмнэлт хийж чадна л гэсэн үг. Бүх хэмнэлтийг дэмжинэ. Бүтээмж гэдэг маань 1 төгрөгөөр 2 төгрөгийн ажил хийх, 1 төгрөгөөр 3 төгрөгийн ажил хийх. Цаашдаа ингэж чадвал нөгөө ирээдүйд 3 төгрөг гарах ёстой зардал маань 1 төгрөг гарна л гэсэн санаа юм байгаа юм. Дээрээс нь хувийн хэвшлийн хийж болох ажлуудыг төр маш их урдур нь орж хийдэг. Энийг л болих хэрэгтэй юм байгаа юм. Ийм 3 чиглэлээр л гэсэн үг.

Д.Амарбаясгалан: Лувсаннъямын Гантөмөр сайд эрүүл мэндийн салбарын бодлогын асуудал дээр хариулт өгье.

Л.Гантөмөр: Бид 26 оныг нөгөө боловсролын жил болгоод боловсролынхоо асуудлуудыг бүрэн шийдье гэдэг ийм зурагтай байгаа. Эрүүл мэндийн салбар дээр бүх түвшинд нь анализыг нь бид байнга харж байгаа, хийж байгаа. Жишээлбэл эмчийн хүрэлцээгээрээ Монгол дэлхийд хэдэд байна вэ, орны тоогоороо дэлхийд хэдэд байна вэ, үйлчилгээ нь яг ямар түвшинд байна вэ, урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүд нь зөв байна уу, үгүй юү гээд. Тэгээд зүгээр дүгнэлт бол хамгийн эхний дүгнэлт Монгол хүн өөрөө өөрийнхөө эрүүл мэндэд маш хариуцлагагүй хандаж байгаа. Урьдчилан сэргийлэх тухай ойлголт алга. Тийм учраас бид нэгэнт байдал ийм учраас өрхийн эмнэлгүүдийг хөгжүүлэх нь эхний ээлжид хамгийн чухал байна. Өрхийн эмнэлэг буюу өрхийн эмнэлэг үйлчлүүлэгч иргэн хоёрын хоорондох цахим холболт аягүй чухал байна гэж 1 дүгээрт.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гантөмөр сайд гүйцээж хариулъя.

Л.Гантөмөр: 2 дугаарт мэдээж эмчилгээний асуудал байгаа. Манайхан маш их гадагшаа явж эмчлүүлж байгаа. Оношлох төхөөрөмж энэ тэр хангалттай болчихсон, оношилгоо алдаад байгаа юм алга. Гол юм бол эмчилгээ. Тэгэхээр эмчилгээ дотроо хавдрын эмчилгээ. Хавдрын эмчилгээг л бид яг дэлхийн түвшинд байгаа тэр эмчилгээний шинэ эмчилгээнүүдийг бид яг өнөөдөр эрдэм шинжилгээний хувьд нь судлах зардлыг нь гаргах ажлыг эрчимтэй хийж байгаа. Жишээлбэл бай эмчилгээ гэдэг зүйл гараад ирчихсэн. Хавдар дээр 1200 эм байдаг бай эмчилгээнд зориулагдсан 1200 эм. Энэ 1200 эмээс Монголд хүлээн зөвшөөрөгдсөн 6-хан ширхэг байгаа. Нэг үгээр хэлбэл хүн бүрд таарсан, хавдар болгонд зориулагдсан эмчилгээг өнөөдөр дэлхий хийгээд, хүнээ үхүүлэхгүй байхад манайх зөвхөн хагална, оёно. Ингээд амьдрах хугацаа их богинохон гэдэг ийм зүйл байгаад байгаа юм. Тэгээд Мөнхбаясгалан.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Мөнхбаясгалан гишүүн дахин тодруулъя.

Л.Мөнхбаясгалан: Хавдрын шаардлагатай 1200 эмээс 6-хан ширхэг нь зөвшөөрөлтэй гэж би сая зөв сонсчхов уу? Энийг тэгээд яагаад зөвшөөрлийг нь олгодоггүй юм бэ? Энийг ингээд олгохгүй байх тусмаа тэр эмүүд чинь хууль бусаар орж ирээд, үнэ нь нэмэгдээд, гараас гар дамжаад тийм юу нь бизнес болоод байгаа юм л даа. Тэгэхээр энэ шаардлагатай эмийг яагаад Монгол Улсад орж ирэх эмийн жагсаалтад оруулдаггүй юм бол?

Д.Амарбаясгалан: Мөнхсайхан сайд хаана байна вэ? Энэ эмийн асуудлаар өнгөрсөн намрын чуулганаар Улсын Их Хурлаас тогтоол гарчхаад, одоо хэрэгжиж өгөхгүй яваад байгаа юм. Монгол Улсад зарагдаж байгаа эм, эмийн чанартай холбоотой асуудал байнга яригддаг. Иргэд маань авч хэрэглэж байгаа эм бол хангалттай түвшний чанар алга байна. Эм уугаад эдгэхгүй байна, эцсийн мөчид нь эмнэлгийн орон дээр очдог ийм нөхцөл Монголчуудад байна л гэдэг асуудал яригдаад байгаа шүү дээ. Тэгээд энэ чанартай эмийг ялангуяа Өмнөд Солонгос, Япон, Сингапурын зах зээл дээр баталгаажуулалтын байгууллагаар албан ёсоор баталгаажсан эмийг аль ч эмийнх нь компани дахин тусгай зөвшөөрөл авахгүйгээр Монголын зах зээл дээр зарж болдог энэ тогтолцоог бүрдүүл гэдэг байдлаар Улсын Их Хурлаас тогтоол гарсан.

Энэ гишүүд хоорондоо муудалцаад байгаа нэг сэдэв чинь энэ байгаад байгаа юм. Тэгээд энийг хувийн аж ахуйн нэгжүүд хийгээд өгөхөөр яам өөрөө хийгээд байна гэж хэрүүл болоод байгаа шүү дээ. Тэгэхээр энийг л бид энэ эмийн

салбарыг жоохон либералчилж өгөхгүй бол иргэд чанартай эм хэрэглэж чаддаггүй, иргэдэд ойлгуулахдаа хямд эмээр үйлчилнэ гээд ойлгуулчихсан. Нөгөө хямд эм нь орц багатай эм ирчихдэг, өвчнөө бүрэн эдгээж чаддаггүй, нэг өвчин туссан хүн эм уугаад ч эдгэдэггүй нэг хор уршигтай үлдэж байдаг ийм байдал яг энэ салбар дээр байна. Тийм учраас Гантөмөр сайдын хэлдэг шиг манай Монголд ямар хэрэгцээ байдаг вэ гэхээр эмнэлгийн ор олон байх хэрэгцээ байж байдаг. Яагаад гэвэл тэр хүн эмээ уугаад эдгэж чадахгүй байгаа учраас эмнэлэгт очиж хэвтэж эмчлүүлэх шаардлага гардаг байхгүй юу.

Тэгэхээр энийг Улсын Их Хурал энэ гаргасан тогтоолынхоо хэрэгжилтийг ЗГ-аас, Эрүүл мэндийн яамнаас байнга шаардаж ажиллах ёстой. Эрүүл мэндийн салбар нь өөрөө өрсөлдөөнтэй байх ёстой. Манайд нэг муу тал байдаг. ДЭМБ, өндөр хөгжилтэй улсуудын эрүүл мэндийнх нь салбар нь албан ёсоор баталгаажуулчихсан байгаа эмийг Монголд зарахын тулд Монгол ахиж баталгаажуулна гэж хэлээд хүнд суртал гаргаад суучихдаг байхгүй юу. Тэгэхээр энийг л бид цэгцэлж өгч чадвал ард иргэдийг өвчин зовлонгоос эрт ангижруулах, заавал өвдөж эмнэлгийн орон дээр очиж хэвтэхгүй байх тэр нөхцөлийг бүрдүүлж өгөх хамгийн том боломж гэдэг талаас харж байгаа юм. Тэгэхээр ер нь эрүүл мэндийн салбарт жоохон либерал бодлого хэрэгтэй энэ дээр бол. Ингээд асуултад Эрүүл мэндийн сайдын өмнөөс хариулчихлаа. Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн асуулт асууна, алга байна. Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууя.

А.Ариунзаяа: Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027, 2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл өргөн барьсан сайд Гантөмөр буюу Эдийн засаг, хөгжлийн яамнаас асууя. Яах вэ та хариулахгүй ч байсан болно. Хариулахгүй байх нь өөрөө том хариулт болно. 3 жил алдагдалгүй төсөв батална гэдэгтээ итгэлтэй байна уу? Энэ зөв үү? Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн өгч байгаа дүгнэлт 2026 оны макро эдийн засгийн тооцооллын өндрөөр төсөөлөхдөө алт, Баян хөндийн төсөл, ураны олборлолт болон экспорт нэмэгдэх, эрчим хүч, дэд бүтцийн зэс хайлуулах үйлдвэр, гангийн үйлдвэр, нүүрс химийн цогцолбор зэрэг нэр бүхий төслүүд бүгд хэрэгжих, мөн хөдөө салбарт хэрэгжиж буй хэдий ч макро эдийн засагт төдийлөн нөлөөлөхгүй байгаа зарим төслүүдийн үр дүн 2025 болон 26 онд гэнэт нөлөөлнө гэж үзсэн нь эрсдэл дагуулж байна гэж Төсвийн тогтвортой байдлын зөвлөл дүгнэсэн байна.

Нэр бүхий гишүүдийн өргөн барьсан байгаа төслийн талаар, хуулийн төслийн талаар гишүүд ярьж байна. Авсан байгаа зээлээ ашиглаж чадахгүй байна гэдэг асуудлыг ярьж байна. Улсын Их Хурлын гишүүд төсөв батлахдаа тэнэг хүмүүс биш. Энэ тэндээс авсан зээл ийм юманд зарцуулж байгаа, орлого тал нь энэ байна, зарлага тал нь энэ байна гээд бүртгээд төсөвтөө оруулаад явахад юу нь болохгүй байгаа юм бэ? Яагаад үүнийгээ бичээд алдагдалтай ч гэсэн зөв үнэн төсвөө баталж болохгүй байгаа юм бэ гэдэг ийм асуултыг асуумаар байна.

10 жилийн өмнөх цаг хугацааг бид эргэн санах ёстой. ОУВС-ийн хөтөлбөрт бид яагаад орох болсон бэ? Үүнийг ч гэсэн Төсвийн тогтвортой байдлын зөвлөл дүгнэж бичжээ. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн төсвийн төслийн хамт нэгдмэл байдлаар шийдвэрлэх нь бодлогын зөв сонголт юм гэж. Улсын төсвийн урсгал төсөв болон хөрөнгө оруулалтыг төсвийн гадуурх ямар нэгэн сувгаар дамжуулан зарцуулах нь буруу. Нэгдсэн нэг төсвийн сувгаар зарцуулах ёстой гэдгийг 2017 онд ОУВС-тай хамтран хэрэгжүүлсэн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд мөрдлөг болгож ирсэн. Ер нь төсвийн гадуур олон сувгийг

бий болгох нь төсвийн сахилга бат, хяналтыг сулруулдаг болохыг олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын зүгээс байнга анхааруулж ирсэн болно гэж байна. Алдаанаасаа суралцахгүй дахин, дахин алдаа гаргахыг Улсын Их Хурлын гишүүд дэмжих юм уу, үгүй юм уу би мэдэхгүй байна. Төсвийн төсөөллөө оруулж ирэхдээ магадгүй эдгээр гишүүдийн өргөн барьсан байгаа хууль, өргөн бариагүй ч гэсэн яригдаж байгаа энэ хууль батлагдана гэсэн ийм төсөөлөлтэй орж ирж байгаа бол эргэн бодох хэрэгцээтэй болов уу гэж бодож байна. Та хариулж болно, хариулахгүй байсан ч болно.

Д.Амарбаясгалан: Лувсаннямын Гантөмөр сайд хариулъя.

Л.Гантөмөр: Ариунзаяа гишүүн бол Тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлт их сайн байна. Тийм учраас та нар алдагдалтай төсөөлөл оруулж ир гэнэ. Наадах чинь логикийн зөрчил байна. Тогтвортой байдлын зөвлөл эрсдэлтэй гэж байгаа зүйл дээр бид аль болохоор алдагдалгүй л явна, өөр арга байхгүй. Тэгээд та бүхэн маань нэг зүйлийг ойлгоорой. Манай эдийн засаг ингээд алдагдал бий болгоод, тэгээд бүтээн байгуулалтаа хийх гэж зүтгэх нь зөв шүү дээ. Бид намар тэгж үзээд, Их Хуралдаа зодуулаад ингээд номхорчихсон шүү дээ. Тэгэхдээ нөгөө талдаа манай дотоодын үйлдвэрлэл сэргэхгүйгээр бид хамаагүй мөнгө нийлүүлж ерөөсөө болохгүй юм байна лээ. Яагаад гэвэл бид импортоо дийлэхгүй гэдгийг 24 оны манай импорт хэлчихсэн. Импорт чинь өндөр байвал тэр дээр үеийн Валютын сан руу гүйж ордог үед ч гэсэн тэгсэн юм. Мөнгө баахан хэвлээд, ар дээр нь импорт өсөөд, валютгүй болчихсон. Нэг үгээр хэлбэл үйлдвэрлэлгүй дотооддоо мөнгө эргэдэггүй улсын зовлон энэ юм байна.

Тийм учраас хэдүүлээ энэ үйлдвэрлэл гэдэг зүйл бол мега төслүүдэд ороод яваад байгаа юм шүү. Үйлдвэрлэлээ хийхийн тулд эрчим хүчээ хийнэ гэдэг энэ логикууд явна. Тэгэхээр түрүүн Жавхлан хэлсэн шүү дээ. Төсвийн хүрээ гэдэг дээд, доод хязгааруудыг хэлж өгч байгаа юм. Бид алдагдалгүй гэдгээрээ төсвийнхөө зардлын дээд хязгаарыг батлаад авъя л даа. Тэгвэл энэндээ захирагдаад явахад нөгөө инфляцаас бид айхгүй байна, төгрөгийн ханшаас айхгүй байна. Тэгэхээр манай энэ өсөж байгаа эдийн засаг, тэлж байгаа эдийн засаг, үйлдвэрлэлийг нэвтрүүлэх гэж байгаа эдийн засагт хамгийн чухал зүйл валютын ханш. Ханшаа алдвал хөрөнгө оруулалт ирэхгүй ийм зүйл байгаа учраас бид энэ алдагдалгүй гэдэг зүйл дээрээ гараад ирсэн юм энэ юун дээр.

Нөгөө талдаа төсвийн хөрөнгийг айхтар дайчлахгүйгээр бид 14 мега төслөө урагшлуулах ийм хандлага руу орж байгаа байхгүй юу даа. Тийм учраас та бүхэн маань энэ төр, хувийн хэвшлийн түншлэл, гаднын хөрөнгө оруулалт, манай Эрдэнэс Тавантолгой компани, Эрдэнэс Монгол компани, Эрдэнэт үйлдвэр энэ хүмүүс өөрснөө нэлээн том хөдлөх нь гэж төсөөлөөсэй гэж бодож байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулт өгье.

Б.Жавхлан: Хариулчхаж болно гэсэн ойлголт байгаа шүү дээ. Ариунзаяа гишүүний асуултад нэмж зүгээр мэдээлэл өгье. Тэр төсвөөс гадуур гэдэг ойлголт байхгүй байх. Улсын Их Хурлын гишүүдийн танилцуулсан санаачилж байгаа тэр хуулийг бол дэмжиж байгаа гэдгийг би дахин хэлье. Тэгэхээр ямар өнцгөөс вэ гэхээр тэр 3 төсөл маань өөрөө манай эдийн засгийг хөдөлгөх boost хийх хамгийн гол суурь 14 мега төсөлд орсон ийм зүйл юм байгаа юм. Би нэг л жишээг нь хэлье.

Нефть боловсруулах үйлдвэр 5,6 их наяд төгрөгийн бид зээл авсан, Их Хурал дээр шийдчихсэн. 2025 онд зээлийн ашиглалтын хязгаарлалтынх нь дүн нь 350 тэрбум төгрөг. Өөрөөр хэлбэл энэ хурдаар явбал дор хаяж 10 жил бүтээн байгуулалтын ажил нь явна. Өнөөдөр бид авчихсан байгаа 88 зээлийн төсөл явж байгаа, 88 зээлийн төслийг 1,5 их наяд.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд хараахан төсөл өргөн бариагүй байгаа. Зүгээр Улсын Их Хурлын гишүүдийн хооронд ер нь энэ ЗГ-ын түвшинд яриа хэлэлцээр нь хийгдчихсэн байгаа, ашиглагдаж чадахгүй байгаад байгаа энэ зээлүүдийг яаж, тийм Их Хурал дээрээс мэдээж шийдвэр гараад явчихсан байгаа энэ зээлүүдийг яаж эргэлтэд оруулах юм бэ гэдэг дээр л гаргалгаа гаргах гээд явж байгаа гэж ойлгож байгаа юм. Ер нь зүгээр Их Хурлын зүгээс мэдээж улсын төсөв алдагдалгүй батлах зорилгыг аль, аль талдаа тавиад явж байгаа. Алдагдалгүй баталснаар ямар зүйлүүд бий болж байна гэхээр хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил эрс удаашрах, эрс багасах ийм нөхцөл байдал бодитой бий болчхож байна. Тэгэхээр энийг зөвхөн алдагдалгүй төсөв гэдгийн цаана ингээд төр юу ч хийхгүй суугаад байх уу, эсхүл олон улсад бүрэн хүлээн зөвшөөрөгдсөн олон төрлийн санхүүгийн хэрэгслүүдийг хэрэглэдэг болох уу гэдэг дээр асуудал яригдаж байгаа гэж ойлгож байгаа юм.

Энэ зээл, тусламжийг цаг хугацаанд нь хий хүү төлөхгүйгээр хэрэглэдэг болох уу, зарим төрлийн хөрөнгө оруулалтыг олон улсын жишгээр концесс хэлбэрээр алдаа дутагдалгүй, хуулийн хүрээнд хийдэг болох юм уу, зарим төрлийн хөрөнгө оруулалтыг баялаг солилцоо хэлбэрээр хийдэг болох юм уу, зарим төрлийн хөрөнгө оруулалтыг томоохон уул уурхайн төслүүдийн урьдчилгаа төлбөр хэлбэрээр нь хийлгэдэг болох юм уу гэдэг дээр Улсын Их Хурлын гишүүдээс Сайнзориг гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг гараад, идэвхтэй ажиллаж байгаа. Энэ төслөө намын бүлгүүдэд, Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлд танилцуулаад явж байна. Хувийн хэвшилтэй, хөрөнгө оруулагч нартай энэ асуудлуудаар уулзаж, ярилцаж байна. Тэгэхээр бид аль болох л цаг хугацааг алдахгүй, хуулийн хүрээнд, зөв хөрөнгө оруулалт хийх тэр бодлогыг л дэмжих ёстой. Энэ нь заавал буруу, эсхүл энэ нь заавал зөв гэж суухдаа гол нь биш. Бид бусад улс орны сайн жишгийн дагуу энэ санхүүгийн олон төрөлт хэрэгслүүдийг хэрэглэж чаддаг л улс болох ёстой гэсэн ийм байр суурины үүднээс асуудалд хандаад явж байгаа.

Тэгэхээр яах вэ Сангийн сайд, Эдийн засгийн хөгжлийн сайд нар мэдээж ЗГ дээр энэ асуудлыг яриад явахад хүндрэлтэй, зөвхөн Засгийн ажил мэтээр зарим улс төрчид хараад байдаг. Тэгэхээр энийг Улсын Их Хурал дээр энэ санаачилгыг авч ажиллах нь зүйтэй гэсэн ийм байр сууриар ажиллаж байгаа шүү гэдгийг хэлье. Батбаярын Жаргалан гишүүн асуулт асууя.

Б.Жаргалан: Та бүхэнд өглөөний мэнд хүргэе. Өчигдрөөс эхлээд Улсын Их Хурал маш чухал асуудлуудыг хэлэлцэж байна. Анх удаа энэ Их Хурал улсын төсвөө бүтэн циклээр нь батлах гэж байна. Тэгэхээр улсын төсөв хэрхэн яаж батлагддаг вэ гэхлээр эхлээд энэ Хөгжлийн төлөвлөгөө, Төсвийн хүрээний мэдэгдлээ батлаад, араас нь намрын чуулганаар улсын төсвөө яг эдгээр зүйлийн дагуу боловсруулагдаад орж ирдэг. Тэгэхээр өнөө, маргаашийн хэлэлцүүлгүүд энэ сард болох хэлэлцүүлгүүд дээр бид маш их ач холбогдол өгөх ёстой юм. Тэгэхээр саяын гишүүдийн яриад байгаа, Хурлын даргын яриад байгаа ийм нэгдсэн ойлголтуудаа бий болгох ийм боломж завшаан гэж хараад байгаа.

Тэгэхээр уг нь энэ завшаан дээр Ерөнхий сайд маань орж ирээд, улсын төсвийнхөө хэлэлцүүлэгт оролцоод, гэр сүүлийнхээ төсвийн талаар ч гэсэн тайлбар юугаа хийгээд, тэгээд хамтдаа нэгдсэн ойлголтод нь хүрчихмээр л байгаад байгаа юм. Тэгэхээр Эдийн засгийн хөгжлийн яамнаас төсвийн хүрээний мэдэгдлийг өргөн барьсан байгаа. Төсвийн хүрээний мэдэгдэл дээр улсын нэгдсэн төсвийн урсгал зардлыг 25 оны хэмжээнд буюу 25,3 тэрбум төгрөгөөр оруулж ирсэн байна. Тэгээд би урсгал зардлыг улам цаашаа танах боломжтой гэж хараад байгаа юм. Хөгжлийн яам болохлоор төрийн албан хаагчдын орон тоог цомхотгох бодлогыг давхар оруулж ирж байгаа шүү дээ. Тэгээд урсгал зардлыг энэ 25,3 их наяд төгрөгөөс улам доошоо буулгах боломжтой гэсэн тийм бодол байхад Сангийн сайд маань болохлоор нөгөө дургүйд хүчгүй гэдэг шиг бүх урсгал зардлыг хуулиар баталгаажуулчихсан, цалин халамжаас цаашаа хэтэрдэггүй юм энэ тэр гээд юм яриад байдаг.

Гэтэл ер нь улсын төсвийг ноднин намар бид харж байхад үрэлгэн, давхардсан, хэт ийм данхайсан тийм зардлууд хаа сайгүй л байгаа шүү дээ. Тэгэхээр хэдүүлээ тэн дээрээ нэг ийм таналт хийхийг зорьё л доо. Та тэгэхээр тэр асуудал дээр нэг ийм бүүр дорвитойхон шиг, нэг итгэл үнэмшилтэйнхэн шиг урсгал зардлаа танах дээр ажиллаад өгөөч гэж хүсэх байна. Ядаж 22, 3 их наядад хүргэчихвэл сая гишүүдийн яриад байгаа хөрөнгө оруулалтын орон зай чинь тэр хэмжээгээр тэлнэ. Тэгж байж бид нарын эдийн засгийн өсөлт энэ 6 хувьд чинь хүрнэ. Тэгэхээр урсгал зардал дээрээ ажиллая гэж хэлмээр байна.

Тэгээд би өчигдөр Сангийн сайдаас энэ 2024 оны төсвийн тодотголд тавигдсан 300 гаруй тэрбум төгрөгийн ТЭЗҮ-ийн зардал ер нь юу болж байгаа вэ? Энэ том төслүүд дээр чинь яг ямар, ямар хэмжээний, ямар, ямар төслүүд дээр яг бодитоор ТЭЗҮ хийгдсэн байгаа вэ гэдгийг асуусан, та хариулаагүй, түүндээ хариулт авъя. Тэгээд үнэндээ бид макро эдийн засгийн үзүүлэлтүүдээ хянаж явах нь чухал. Инфляц, ханш. Тэгээд ханш дээр яах вэ гэхлээр бид экспортоо тэлэх хэрэгтэй шүү дээ. Тэгээд гол нь экспортын бус бүтээгдэхүүний, уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлье гэж яриад байгаа. Үүн дээр Гадаад яам ямар бодлого баримталж байгаа вэ гэдгийг асуумаар байна. Энд 2, 3-хан сайд сууж байна. Тэгэхээр Сангийн сайдаас сая асуулт асуулаа. Гадаад яамны сайдаас асуух нь бид уул уурхайн бус экспортын бараа, бүтээгдэхүүний зах зээлээ тэлэх, ер нь гадаад зах зээлээ тэлэх тал дээр танай яам дорвитой санаачилга гаргаад ажилламаар байна. Харамсалтай нь үр дүн харагдахгүй байна. Бид намар ч гэсэндээ төсөв батлах үед энийг аягүй их ярьсан. Гадаад харилцаагаа эдийн засагжуулъя гэдэг агуулгаар.

Гэтэл сая ингээд л баахан томилгоонууд яригдлаа. Түүн дээр нь дандаа улс төрчид явж байна. Тэгээд гадаад харилцаа чинь эдийн засагжиж байгаа зүйл ерөөсөө харагдахгүй байгаад байна. Тэгэхээр танай яам энэ тал дээр яг ямар дорвитой бодлого, шийдвэр гаргах юм бэ? Тэгээд цаашдаа бид ер нь энэ гадаад зах зээлийг хэрхэн яаж тэлэх юм бэ? Энэ Зүүн өмнөд Азийн зах зээл рүү яаж хандах юм бэ ч гэдэг юм уу, Европын зах зээл рүү яаж гарах юм бэ гэдэг зүйлүүд дээр хариулт авъя?

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан асуултад хариулъя. Жаргалан гишүүний асуултад хариулъя. 2024 оны төсвийн тодотголоор тавигдсан ТЭЗҮ-үүд дээр сайдууд маань өөрсдөө гүйцэтгэлийнхээ явцыг хэлчихвэл их сайн

байна. Тийм учраас сайд нь орж ирээд энэ дээр яг ямар хувьтай явж байгаа вэ. Ер нь бүх гэрээнүүд нь хийгдчихсэн, ТЭЗҮ-ийн ажлын яг процесс нь явж байгаа л гэсэн бид ийм мэдээлэлтэй байгаа шүү. Тодорхой хэмжээний санхүүжилтүүд нь ингээд гараад явж байгаа.

Урсгал зардал дээр Жаргалан гишүүнээ 3Г-ын хэмнэлтийг бид байнга дэмжинэ, бүтээмжийг байнга дэмжинэ, хувийн хэвшлийг байнга дэмжинэ, хувийн хэвшил хийж болох юмыг төр хэзээ ч хийж баймааргүй байгаа юм. Тэгэхээр хойшоо суусан зүйл ерөөсөө огт байхгүй. Харин та яг цагаа тулахаар битгий хойшоо суугаарай. Энэ Монгол Улсын төсвийн чинь 75 хувь нь яах аргагүй л урсгал зардал. Үүнийх нь 60 гаруй хувь нь ерөөсөө 3-хан салбар дээр байдаг 3-хан салбар дээр. Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн салбар дээр байдаг. Тэдгээр нь бүгд хуультай. Хуулийг нь таны ширээн дээр аваачаад тавьчихсан байгаа. Та түүн дээр мөн санаачилгатай байгаад, өөрөө хууль санаачлах эрх бүхий субъект нь. Энэ, энэ хуулиудаар ийм, ийм урсгал зардлыг нь зогсоочихвол үлэмж хэмжээний хэмнэлт гарах нь гэдгийг нь нэг зоригтой гаргаад ирээрэй. Тэгвэл их сайн байна. Урсгал зардал дээр үйл ажиллагааны зардлууд дээр бид хэмнэлт хийж болно. Харин энэ дээр харин бид хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх маш олон ажлуудыг тийш нь зоригтойгоор бид шилжүүлэх хэрэгтэй. Энийг өмнө нь бид шат дараатайгаар хэрэгжүүлэх гээд хэд хэдэн удаа оролдож байсан боловч тэр бүр амжилттай болдоггүй юм байна лээ.

Тийм учраас энэ дээр салбар салбарын маш том манлайллууд хэрэгтэй, Улсын Их Хурал дээрээс шийдвэр гаргаад, тэндээсээ эргэж буцахгүй байх гээд олон л зүйлүүд болдог юм байна лээ. Энэ удаа төсвийн хүрээг ярьж байгаа. Та төсөв, төсвийн хүрээ хоёроо сайн ялгаж байгаа байх гэж ингэж бодож байна. Тийм учраас төсвийн хүрээн дээрээ ямар ч байсан бид тоонуудаа баталж аваад, ингээд удахгүй төсвийн бид өргөн барих төлөвлөлтийн ажлууд маань ингээд шувтрах байх. Тэр үеэр ч мөн одоо энэ жилийн хувьд онцлог гэвэл Улсын Их Хурал дээрээс хэд хэдэн ажлын хэсгүүд гараад салбар яамнуудтай, манайтай ч гэсэн нэлээн ойрхон ажиллаж байгаа. Тэр зээлийн ашиглалт дээр гарч байгаа санаачилга ч гэсэндээ ер нь энэ ажлын хэсгүүдтэй нэлээн ажлууд нь уялдаж ингэж явж байгаа гэдгийг хэлье. Түрүүн Амарбаясгалан дарга нэлээн тодорхой хэллээ. Танд их баярлалаа.

Д.Амарбаясгалан: Гадаад харилцааны сайд Батцэцэг хариулт өгье.

Б.Батцэцэг: Жаргалан гишүүний асуултад хариулъя. Энийг өмнө нь олон удаа асууж байсан. Гадаад худалдаа эрхлэхэд, экспортыг нэмэгдүүлэхэд, гадаад харилцааг эдийн засагжуулахад эрх зүйн орчин нь хангалттай бүрдчихсэн. Бүх айл манай бараа, бүтээгдэхүүнийг авъя, сонирхолтой байна. Бүх айл манайтай хамтарч ажиллая уул уурхайн салбарт гээд. Бид нарт өөрт дотоодод асуудал их байна. Бүх асуудлыг улс төржүүлдэг, хууль, эрх зүйн орчин нь сайн бүрдээгүй, хөрөнгө оруулагчдад ирэхэд нь тодорхойгүй, өмнө нь гомдоочихсон хөрөнгө оруулагчдын гомдлыг барагдуулаагүй, хэлсэн амандаа хүрдэггүй, салбар яамнуудынх нь зарим бодлого нь тодорхойгүй. Зөвхөн ганцхан жишээн дээр бид энэ критикал минерал дээр олон улстай хамтарч ажиллая гээд олон улс санал тавихад одоо хүртэл бид яг ямар бодлого баримтлах вэ, ямар эрх зүйн орчинтой байх вэ, өмнөх энэ салбарт хөрөнгө оруулаад гомдчихсон гадаадын хөрөнгө оруулагчдынхаа гомдлыг яаж барагдуулах юм. Энэ асуудлуудаа шийдээгүй учраас 1 дүгээрт.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Б.Батцэцэг: Дээрээс нь манай төслүүд шаардлага хангахгүй байна. Хөрөнгө оруулъя гэхэд бид бүх улстай боломж нь байна. Зөвхөн булангийн орнуудтай бид хөрөнгө оруулалтыг 20, 30 жил ярьж байна. Бүгд шаардлага хангасан, шалгуур хангасан ийм сайн төслөө хийгээд ир хөрөнгө оруулахад бэлэн байна гэдэг. Ийм төслүүдийг бид хийж чадахгүй, өгч чадахгүй, хамгаалж чадахгүй ингээд цаг хугацаа их алдаж байна. Манай бараа, бүтээгдэхүүнийг авъя гэхлээр стандартыг нь хангаж чаддаггүй, хорио цээрийнх нь дэглэмийг нь давж чаддаггүй, одоо гадаа экспортод явж байгаа бараа, бүтээгдэхүүн бол дандаа хувийн хэвшлүүдийн өөрсдийнх нь хөгжлийн хүрээнд л чадаад хийгээд явж байгаа. Тэгэхээр бид яг хувийн хэвшлээ дэмжиж чадаж байна уу, үгүй юү. Тэрнээс биш гадна талд орчин байна, эрх зүйн орчин нь бүх баримт бичгүүд нь байгуулагдчихсан, хэлэлцээрүүд нь хийгдчихсэн, бүрдчихсэн байна. Одоо бид өөрсдөө хариуцлагатай байх хэрэгтэй гэж хэлмээр байна.

Д.Амарбаясгалан: Батбаярын Жаргалан гишүүн тодруулж асууя.

Б.Жаргалан: Би Жавхлан сайдаас саяын тэр ТЭЗҮ-үүдийг асуугаад байхлаар салбарын сайдууд руу хандуулаад байх юм. Тэгэхээр уг нь тэр Сангийн сайд нь тэр ТЭЗҮ-үүдээ нэг санхүүжилтийг нь гаргаад, араас нь хөөцөлдөөд явмаар байна шүү дээ. Одоо энэ төслүүд байхгүй гээд Гадаад харилцааны сайд чинь хэлээд байна шүү дээ. Тэгэхээр одоо тэр төсвийн тодотгол батлаад, мөнгө нь тавигдсанаас хойш даруй бараг жил боллоо шүү дээ. Тэгээд ингээд мөнгө нь тавигдчихдаг, тоолуур нь тоологдоод яваад байхад төсөл ч байхгүй, бэлэн төсөл ч байхгүй, юу ч байхгүй сууж байж болохгүй биз дээ. Тэгэхээр энэ ажил дээрээ та хэд маань нэг сэтгэл гаргаад ажиллаж болохгүй юм уу? Түүнээс биш та хэд хууль санаачлах эрхтэй гээд Их Хурал руу чихээд суугаад байх юм. Засаг дээр чинь 23 сайд ажиллаж байгаа шүү дээ. Дор бүрнээ тодорхой асуудлууд хариуцаад, салбар хариуцаад ажиллаад байгаа. Тэгэнгүүт салбарын сайдууд нь болохлоор нэг нэгэн рүүгээ чихсэн тийм ч юм байхгүй, ийм ч юм байхгүй, ийм ч нөхцөл бүрдэхгүй байна гэж яриад байх юм. Тэгээд энэ сонгуулиас хойш чинь бүтэн жил өнгөрчихлөө.

Д.Амарбаясгалан: Жавхлан сайд хариулт өгье.

Б.Жавхлан: Манай Жаргалан гишүүн надаас л асуух дуртай байдаг юм. Өөр хариулчих хүмүүс энэ дотор зөндөө байж байна. Тэгэхдээ би дахиад л хариулъя. Тийм энэ чинь төсөв дээр нь тавьчихсан энэ ажлууд нь гэрээ нь хийгдээд 8 сарын 30-ны дотор дуусах ёстой, ингээд санхүүжилтээ аваад явж байгаа юм. Үгүй ээ энэ чинь бүхэл бүтэн яам нь байж байна, сайд нь байж байна. Яамгүй ч гэсэн асуудал эрхэлдэг сайд нь байж байна. Тэр ТЭЗҮ-г нь өөрийнхөө төсөв дээр авч байгаад баталж өгөөд санхүүжилт нь гаргаад явж байгаа сайдууд чинь тус тусдаа ингээд явж байгаа шүү дээ. Ингээд л явж байгаа. Тэгэхээр сайдууд нь илүү тодорхой хариулсан нь дээр.

Тэр түрүүн тэр өөрөө нэг юм асуугаад байсан. Тэр нөгөө хэд хэдэн төсөв гээд. Энэ бол 12 оны асуудал шүү та бол маш сайн мэдэж байх ёстой. Хөгжлийн банкаар гарч байсан тэр санхүүжилтүүд, тэр асуудлуудыг дараа нь тэр ОУВС-ийн хөтөлбөрт орох үед Монгол Улс хэд хэдэн төсөвтэй болчихсон байна, төсвөөс гадуур явж байгаа зардал чинь энэ байна шүү.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуулт асууя.

Д.Энхтүвшин: 3 асуулт асууя. 1 дүгээрт нь өртэй холбоотой. Төв банкны тухай хуулийн 38¹ дээр болохоор пассив нь активын хөрөнгөөсөө хэтэрсэн тохиолдолд ЗГ-ын үнэт цаас гаргана гэсэн ийм заалт байгаа. Тэгэхээр 2024 оны Төв банкны балансыг харахаар 4,9 буюу бараг 5 их наяд буюу одоогийн өрийн бараг 10 хувьтай тэнцэх хэмжээний ЗГ-ын үнэт цаас гаргахаар ийм хуулийн заалт байгаа. Энэ талаар Монголбанк, Сангийн яам ямаршуу байдлаар ажиллаж байгаа вэ? Энэ талаар яриа хөөрөө, энийг шийдэл гаргах ийм явц байгаа юу гэдэг 1 дүгээр асуулт байна.

2 дугаарт ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр дээр инфляцыг 5-аас доошгүй түвшинд хадгална гэсэн ийм зорилт байгаа. Тэгэхээр Төсвийн хүрээний мэдэгдэл маань ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөртэй нийцэх ёстой. Тэгэхээр оруулж ирсэн төслөөр харахаар 7, 6.4, 6 гэсэн байдлаар тодорхойлсон буюу 5 хувь гэсэн ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрөөсөө өөр хэмжээний ийм төсвийн хүрээний мэдэгдэл оруулж ирсэн байна. Энэ талаар тайлбар авъя.

3 дугаарт нь эдийн засгийн өсөлтийг 6 хувьд байхаар төлөвлөчихсөн байна. Энэ дээр уурхайн болон уул уурхайн бус салбаруудын өсөлтийн ялгаануудыг нь хэдэн хувь нь уул уурхайн өсөлтөөс, хэдэн хувь нь уул уурхайн бус салбарын өсөлтөөс орж ирэх вэ, энэ талаар мэдээлэл өгөөч? Ийм 3 асуулт байна.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан сайд хариулт өгье, Энхтүвшин гишүүний асуулт.

Б.Жавхлан: Юу гэж асуусан бэ, Төсвийн хүрээ гээд асуусан биз дээ. Төсвийн хүрээ гэж асуусан биз дээ?

Д.Амарбаясгалан: Лувсаннямын Гантөмөр сайд хариулт өгье.

Л.Гантөмөр: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. 26 оны эдийн засгийн өсөлтийг тооцохдоо бид уул уурхайн салбарын өсөлтөө 9,9 хувь гэж харж байгаа. Уул уурхайн бус салбарын өсөлтийг 3 аравны, уул уурхайн бус бусад салбар нь 5,3 хувьтай. Энэ дотор хөдөө аж ахуйн салбар нь 3,9 хувь, уул уурхай 9,9, боловсруулах үйлдвэр 5,1, цахилгаан, ус 10,6, барилгын салбарын өсөлтөө нэлээн өндөр харж байгаа 17,1 гэж. Яагаад гэвэл бид үйл ажиллагааны төлөвлөгөө дээрээ 150 мянган айлын орон сууцын хөтөлбөрөө батална гэж оруулж байгаа. Энэтэй уялдуулаад барилгажуулах ажил, барилгын салбарын өсөлтийг нэлээн түлхэж явна гэсэн ийм төлөвлөлттэй байна. Худалдааны салбарын өсөлтийг 6,5, тээвэр 4,4, үйлчилгээний бусад салбар 3,8, цэвэр татвар 5,7 гэсэн ийм төлөвлөлттэй байгаа.

Бараа, үйлчилгээний үнийн өсөлтийн тухайд бид 28 ондоо 6 хувь руугаа аваачна гэсэн ийм тооцоолол гарч байна. Яагаад ийм өөрчлөлт орж байна вэ гэхлээр энэ худалдааны дайнтай холбоотойгоор бараа, бүтээгдэхүүнүүдийн үнэ маш их хөдөлж байна. Өсөлт илт анзаарагдаж байна. Тийм учраас манайд орж ирж байгаа юм шүү дээ манайд нөлөөлж байгаа юм. Жишээлбэл Хятадын эдийн засаг идэвхжил өндөртэй байхад манайх импортоос асар өндөр хамааралтай амьдарч байна л даа. Тэгэхээр импортоос хамааралтай улс орны хувьд манай гол

нийлүүлэгч нь Хятад улс байдаг. Хятад улсын, Японы, Солонгосын бараа бүтээгдэхүүнүүдийн Америкт орж байгаа нэвтрэлт багасна гэдэг ийм тооцоолол байна. Багасаад ирвэл үйлдвэрлэл нь буурна, үйлдвэрлэл буурвал өртөг нь нэмэгдэнэ, өртөг нь нэмэгдэхээр манайд нийлүүлж байгаа барааны үнэ өсөөд явах ийм дүр зураг харагдаад байна гэсэн ийм тооцоолол 1 дүгээрт хийж байгаа.

2 дугаарт эрчим хүчний салбар либералчлагдахаар цаашаагаа саяын өссөн үнэ буурах тренд байна. Нөгөө талд нь дулааны үнэ гэдэг зүйл байгаа. Дулаан өнөөдөр дандаа алдагдалтай явж байгаа. Тэгэхээр энэ бол ашигтай явахгүйгээр орон сууцжуулалт өөрөө байхгүй болчхож байгаа юм. Тэгэхээр орон сууцын салбарын өсөлтөө хараад бид дулааны нийлүүлэлт дээр яалт ч үгүй шийдвэр гарах юм байна гэдэг ийм зургийг харж байгаа гэдгээ хэлье. Тэгээд Монголбанктай холбоотой асуудал дээр Сангийн сайд хариулна.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан нэмэлт хариулт өгье.

Б.Жавхлан: Төв банкны хууль дээр тийм заалт байдаг юм. Тэр бол 1990 онд ерөөсөө бид арилжааны банк, Төв банктэй болох ийм 2 шатлалтай системээс анх бий болсон суурь ойлголт л доо. Ер нь улс улсын Төв банкны хуулиуд дээр ийм заалтууд байдаг. Тэр нь юу вэ гэхээр ер нь яах вэ ЗГ-ыг хариуцлагажуулж байгаа л санаа юм байгаа юм. Өөрөөр хэлбэл дан ганц Төв банкны бодлогын хүүд захирагддаг инфляц гэж байхгүй шүү. Дан ганц Төв банкны бодлогоор хязгаарлагддаг, зохицуулагддаг валютын нөөц гэж байхгүй шүү. ЗГ энэ дээр тодорхой хэмжээний үүрэг хариуцлага хүлээх ёстой шүү. Төлбөрийн тэнцлээрээ дамжуулаад, гадаад худалдаагаараа дамжуулаад. Тийм учраас тодорхой хэмжээний хариуцлага ЗГ заавал үүрэлцэх ёстой гэдэг тийм нэг уяа байдаг, уяа байдаг. Тэгэхдээ тэрний дагуу ЗГ тэнд алдагдлыг хаах ч юм уу, тэр эрсдэлээс төсөв дээрээс.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Жавхлан сайд гүйцээж хариулъя.

Б.Жавхлан: Тэгэхээр тэрийг өмнө нь тийм зохицуулалт хийж байгаагүй. Цаашдаа яах вэ гэдгийг бид ярих ёстой. Энийг Улсын Их Хурал дээр ярих ёстой, ЗГ дээр Төв банктэйгаа бүгдээрээ сууж байгаад энийг ярилцах ёстой. Гэхдээ өнөөдрийн хуримтлагдсан засгийн юу, Төв банкны тэр бодлогын зардал гэж хэлбэл их илүү их оновчтой юм байгаа. Тэр хуримтлагдсан алдагдлын ер нь 90 гаруй хувь нь бодлогын хүүгийн эсвэл ханшны тэгшитгэл юм. Өөрөөр хэлбэл Төв банкны валютын нөөц нэмэгдэх тусмаа Төв банк валютын ханшийн алдагдалд ордог. Инфляц нэмэгдэх тусмаа, бодлого хатуурах тусмаа бодлогын хүүгийн зардал нь өндөр гараад, бодлогын энэ зардал нь нэмэгдэж, алдагдал нь өсөж байдаг ийм л зүйл юм байгаа юм. Өөрөөр хэлбэл эдийн засгийг тогтворжуулахын төлөө гаргаж байгаа ийм л зардал гэж ойлгох хэрэгтэй.

Д.Амарбаясгалан: Энхтүвшин гишүүн тодруулж асууя.

Д.Энхтүвшин: Эдийн засгийн өсөлт дээр нэг тодруулах асуулт байна. Тээврийн өсөлтийг 4,5 гэсэн, өмнө төсвийн хүрээний мэдэгдэл ярьж байх үед асууж байсан. Энэ тээвэр гэдэг дотор уул уурхайтай холбоотой тээвэр энэ дотор яваад байгаа. Тэгэхээр энийг салгаж уул уурхай руугаа уул уурхайтай холбоотой тээвэрлэлтээ оруулж ялгаж байгаа юу, энэ нь хэдэн хувь байгаа вэ гэсэн нэг асуулт байна?

Тэгээд ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр уг нь яах вэ хөтөлбөрүүд дээр энд нийцсэн байх ёстой гэхээр нөхцөл байдал бол мэдээж олон шалтаг шалтгаанууд байгаа байх. Тэгэхээр яах вэ үүндээ нийцүүлээд ямар зохицуулалтууд, ямар тохиргоонууд хийх юм гэдэг байдалтай уялдуулж явах ёстой юм уу гэсэн бодол байгаад байгаа юм. Тэгэхээр инфляцыг 5-аас доош түвшинд хадгална гээд үйл ажиллагааны хөтөлбөр дээрээ заачихсан, одоо болохоор ингээд ийм нөхцөл байдлаас ингээд энэ давахаас өөр аргагүй болж байна гээд. Яах вэ зүгээр тайлбарлаад бол ойлгож байна. Тэгээд өөр ямар нэгэн сонголт байхгүй байсан болоод л ингэж байгаа болов уу гэж.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Дэлгэрсайхан сайд байхгүй байна уу? Индэр 4-өөс Эдийн засаг, хөгжлийн яамны газрын дарга Энх-Амгалан хариулт өгье.

Л.Энх-Амгалан: Гишүүний асуултад хариулъя. Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Энх-Амгалан. Тээврийн өсөлтийн хувьд уул уурхайгаар уул уурхайн бүтээгдэхүүнийг тээвэрлэх ачаа тээвэр орж байгаа. Төмөр замаар нийт, төмөр замаар нийт 26 онд 53 сая тонн ачаа тээвэрлэхээс 38 сая тонн нь уул уурхайн бараа бүтээгдэхүүн байгаа. Авто замаар 26 онд нийт 90 сая тонн ачаа тээвэрлэхээс 83 сая тонн нь мөн уул уурхайн ачаа тээвэр байгаа. Ерөнхийдөө өсөлтийн хувь нь яг энэ дүнтэй жишээд хуваагдаж орж байгаа гэсэн үг.

Д.Амарбаясгалан: Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн дахин тодруулъя.

Д.Энхтүвшин: Тийм яах вэ энэ нөгөө өсөлтөө цэгцтэй байлгах үүднээс энэ баялгийн хараалттай холбоотой асуудлуудаас үүднээс энэ уул уурхай болон уул уурхайн бус салбарын өсөлт гээд байгаа. Тэгэхээр энийг уул уурхайтай холбоотой тээврийн хэсгийгээ уул уурхай руугаа оруулж болохгүй. Энэ угаасаа энэ өртөг нэмэгдүүлэх сүлжээний чинь нэг хэсэг учраас. Цаашдаа энэ чиглэлээр арга хэмжээ хийх бодол байгаа юу гэж асуумаар байна.

Д.Амарбаясгалан: Энх-Амгалан 4 дүгээр индрээс нэмэлт хариулт өгье.

Л.Энх-Амгалан: Энэ статистик тооцдог аргачлал бол Үндэсний статистикийн хороо дээр хийгддэг. Нийт улсуудын тээврийн салбарын харьцуулалтыг хийхэд ингэж тээврээ салбаруудад нь хувааж үздэггүй, яг л тээсэн ачааныхаа статистикийг л харуулж явдаг. Энэ асуудал бол яах вэ өмнө нь яригддаг байсан асуудал бол нөгөө төсвийн зарлагыг уул уурхайн ба уул уурхайн бус, уул уурхайн бусынх нь өсөлтөөс давуулахгүй гэдэг үүднээс энийг уул уурхайг нь салгах нь зөв юм шүү гэдэг асуудал яригддаг байсан юм. Одоо бол дүн нь өөр болсон учраас яг л статистикийн гаргадаг тоонуудыг ашиглаад л явж байна.

Д.Амарбаясгалан: Лувсаннъямын Гантөмөр сайд нэмж хариулт өгье.

Л.Гантөмөр: Тийм Энхтүвшин гишүүний саналыг би ойлгочихлоо. Ерөнхийдөө уул уурхайгаас хамааралтай байгаа эдийн засгийнхаа тоог нэг базчихаач гэж байгаа юм байна. Ингэж байж бид нөгөө үлдэж байгаа салбарынхаа өсөлтийг их зөв харах юм байна. Уул уурхай дагасан салбарын өсөлтөө уул уурхайн бус салбарын өсөлт гэж өөрсдийгөө хуураад хэрэггүй шүү гэдэг ийм санал хэлж байна гэж ойлголоо. Бид яг энэ чиглэлээр дараа дараагийн тооцоололдоо

анхаараад, энэ чиглэлийн тайлангаа тусад нь рарег болгоод гаргаад явъя гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. Бид төсвийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлээ хэлэлцэж байгаа. Энд энэ улс орны эдийн засаг, нийгэм, төсвийн үндсэн үзүүлэлтүүд нь хоорондоо уягдаж орж ирдэг. Үүн дээрээ тулгуурлаж бид төсвөө боловсруулдаг. Тийм учраас энд зөвхөн хязгаар юм гэж ярих ч илүүц л дээ. Тийм учраас бид юмаа зөв харах тухай ойлголт байгаад байгаа юм. Бид хэд амаргүй л цаг хугацааг туулж байна үнэндээ. Эдийн засгийг бүрдүүлж байгаа салбарын маань гол эрдсүүдийн үнэ дэлхийн зах зээл дээр өмнөх жилээсээ 20-оос 30 хувиар буурчхаад одоогийн байдлаар байж байна. Олон улсын байгууллагууд энэ нөхцөл байдлыг ажиглаад энэ ер нь бараг тогтвортой хадгалагдах юм байна гэж дуугараад байна. Гэтэл бид эдийн засгийнхаа өсөлтийг тэр тусмаа өнөө гол эдийн засгийг бүрдүүлж байгаа салбарынхаа өсөлтийг бараг 10 орчим хувьтай тооцоод явж байгаа. Төсвийн орлогоо тэрүүнтэйгээ дүйцүүлээд тооцчихож байгаа явдал энэ тэр ер нь хэр бодитой байх бол? Энэ дээр би нэг тодорхой тооцооллын талаас нь, бас энд баримталсан зарчим талаас нь анхаармаар байна сонсмоор байна гэж нэг ийм.

2 дахь зүйл төсвийн хүрээний мэдэгдэлдээ хэдүүлээ татварын орчноо төсөөлж яалт ч байхгүй орлого тооцолт хийгдсэн. Тэгэхээр харин энэ өөрчлөлтийн ерөнхий зарчим эд нарын талаар энэ хүрээний мэдэгдлийг дагуулж танилцуулга нь ядаж, болж өгвөл бараг хуулийн төсөл нь орж ирмээр байгаа юм. Төсвөө дагаж орж ирдэг биш, хүрээний мэдэгдлээ дагаж орж ирдэг байж сая бодит байдал хангагдах ёстой. Энэ тал дээр ер нь ямархуу бодол санаатай, та хэд ямар байр суурьтай байгаад байгаа юм бэ гэж?

Дараагийн нэг зүйл худалдааны дайн. Эдийн засгийн хоригт авагдчихсан гол улс орнуудтай бид худалдааны бараг 100 хувийн хамааралтай байгаад байгаа юм. Энэ нь манай эдийн засагт, төсөвт сүүдрээ өгөөд байгаа, гол эрдсүүдийн үнэ унаж байгаатай холбоотой. Гэвч нөгөө талд энэ сорилтыг боломж болгох зүйл байхгүй юу гэдэг асуудал байна. Бид дэлхийн улс орнуудад худалдааны дайнаар дамжуулж том хэмжээний тариф авчхаагүй улс. Тэгвэл бид яагаад юм гаргаж болохгүй байна вэ энийг дагуулж, энэ тал дээр ер нь бодож байгаа, тооцож байгаа үзүүлэлтүүд байна уу?

Дараагийн нэг зүйл ер нь бид хаашаа яваад байна вэ? Энэ туурга тусдаа улс гэдэг чинь үйлдвэрлэгч байх ёстой юм шүү дээ. Баялаг бүтээдэг байх ёстой юм шүү дээ. Бүтээмж нь өсдөг байх ёстой юм шүү дээ. Өөрийнхөө зах зээлийг хамгаалдаг байх ёстой юм шүү дээ. Гаалийн албан татвар гээд ярина. Энэ яадаг татвар юм дотоодынхоо зах зээлийг хамгаалж, дотоодынхоо үйлдвэрлэлийг дэмжиж, эдийн засгаа өсгөдөг, ажлын байраа нэмэгдүүлдэг, амьдралын чанараа сайжруулдаг татвар. Үгүй ээ тэгээд энийгээ бид бүгдийг нь байхгүй болгож байна шүү дээ. Гурил дээрээ байхгүй болголоо, цементэн дээрээ байхгүй болголоо. Дээр нь наад нэг угаадаг баяжуулдаг салбарууд чинь бүгд тэг зогсолт хийчихсэн байж байна. Дээр нь томоохон бүтээн байгуулалтууд дээр дотоодын гүйцэтгэгчид шалгуур хангахгүй байна гээд гаднын гүйцэтгэгч ажиллах хүч оруулж ирэх тухай шийдэл хийцгээж байна. Үгүй ээ энэ тэгээд зөв үү? Бид ер нь хаашаа яваад байгаа

юм бэ? Тэгээд наад валютын чинь нөөц бүрдэх үү, дотогшлох уу? Тэгээд мөнгөний чинь худалдан авах.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гантөмөр сайд хариулт өгье.

Л.Гантөмөр: Бид яг энэ манай танилцуулгыг уншвал Батжаргал гишүүнтэй л адилхан төсөөлөлтэйгөөр урагшилж байгаа юм. Ер нь гадаад худалдаан дээр бид өнөөдөр олигтой амжилтад хүрэхгүй байгаа шалтгаан бол бид түүхий эдийг экспортолж байгаа. Түүхий эдийн экспорт бол замынхаа зардлыг дийлдэггүй юм байна. Замын зардал дийлдэггүй учраас бид нөгөө 2 хөршөөсөө цаашаагаа давуулж экспортоо хийж чадахгүй байна. Тэгэхээр бид яагаад энэ 6 хувийн өсөлтийг тооцоолж байгаа вэ гэвэл энэ үлдэж байгаа хагас жилийн хугацаанд бид энэ үйлдвэрлэл гэдэг дээр онцгой үр дүн гаргана. Үйлдвэрлэл дээр онцгой үр дүн гаргахын тулд юугаа эрчим хүчнийхээ асуудлыг бүрэн шийдэж байгаа гэдэг ийм итгэл бидэнд байна. Үйлдвэрлэл гэдэг нь нүүрс баяжуулах, нүүрс боловсруулах, баяжуулах гэхээр бид нэг угаагаад болчихож байна гэж бодож байна. Угаагаад өртөг сайн шингэхгүй байна. Бүрэн боловсруулж чадвал манайхаас өртөг шингэсэн замын зардлаа даах бүтээгдэхүүнүүд гарна, гарахаар байна. Тийм учраас энэ дээр бид нөгөө Аж үйлдвэрийн паркийн хуулиа баталчихсан. Энэ хуулийг амилуулах шаардлага байна.

Нөгөө талдаа гаалийн тарифыг өнөөдөр жишээ нь гурилан дээр ингээд тариф тавьж чадахгүй байгаа нь бидний эмгэнэл. Ер нь бид энэ 64-өөр хууль батлах уу, үгүй юү гэдгээ эргэж харах хэрэгтэй. Энэ олонх нь өнөөдөр жишээлбэл парламентын энд сууж байгаа гишүүдийн олонх нь татварыг тэглээ гээд тэглэхийн эсрэг, татвар тавья гэдэг саналтай байхад яагаад хуулиа баталж чадахгүй байгаа юм. Үндсэн хуулийн зөрчил байна. Тийм учраас энийгээ хэдүүлээ эргэж харахгүй бол болохгүй. Жишээлбэл цемент дээр ч гэсэн тэр гаалийн татварыг нь тавих хэрэгтэй шүү дээ. Бид татвартай байж цементийн энэ дотоодын үйлдвэрлэлийг дэмжинэ. Тэгэхээр бид улс төржих биш, хоорондоо сайн ярилцаад таны хэлж байгаа энэ дотоод үйлдвэрлэл гэдэг дээр онцгой анхаараад, тэр дундаа нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэл эцсийн бүтээгдэхүүн рүүгээ алхаад ингээд явах төлөвлөлтөөр 6 хувийн өсөлтийг бид гаргаад байгаа ухаантай юм гэдгийг эрхэм гишүүнд хэлмээр байна.

Таны хэлж байгаа санаа гурвуулаа уялдаатай байна. Экспорт чинь яагаад нэмэгддэггүй юм, хол яагаад гардаггүй юм, түүхий эд байна, боловсруулж чадахгүй байна. Боловсруулах тодорхой зүйл дээр бид алхах гэж байгаа учраас өсөлтөө бид ингэж харж байгаа юм. Нөгөө талдаа алдагдалтай төсөв батлаад явчхаасай гэж олон олуулаа бид ярьж байгаа юм. Тэгэхдээ эргээд харахад бид нарын өнөөдрийн хамгийн эмзэг цэг бол валютын нөөц хамгийн эмзэг цэг. Тийм учраас бид валютын нөөцөө баталгаажуулахын тулд үйлдвэрлэлээ эрс нэмэгдүүлэх, ялангуяа алт. Алт дээр тодорхой төсөл шүү. Бид гадуур ингээд буруу яриад байна лээ хавтгайруулах гэж байна.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гантөмөр сайд гүйцээж хариулъя.

Л.Гантөмөр: Бүх айлд зөвшөөрлийг нь нээх гэж байна гээд нэг алхахад ингээд хардалт нь дийлддэггүй юм байна. Тийм учраас таны хэлж байгаа энэ бэлэн байгаа хүмүүсээ ажиллуулах, ялангуяа энэ дотоодын төсвийн мөнгөөр хийж байгаа ажил дээр Монгол компаниуд орох гэдэг ерөөсөө л суурь зарчим. Энэ

мөнгийг дотроо эргэлдүүлэх гэдэг бол. Монгол төгрөг өөрөө 2-оос цаашаагаа дамжиж чадахгүй байгаа учраас манай эдийн засаг бэхжихгүй байна гэдэг ийм дүр зураг байгаа шүү. Тэгээд тантай санал нэг байна. Бид үйлдвэржсэн орон болох ёстой. Энэ хөдөлгөөнгүй манай энэ 14 мега төслийн гол зорилго бол ердөө энэ, үйлдвэржсэн орон руу л алхаж байгаа.

Д.Амарбаясгалан: Батжаргал гишүүн тодруулж асууя.

Ж.Батжаргал: Үгүй ээ бид гоё ярьж чадаж байгаа юм үнэндээ. Гэхдээ бид энэ дэлхий их өндөр хөгжчихсөн улс орнуудын эдийн засгийн загварыг дөнгөж босож ирэх гэж байгаа эдийн засаг дээрээ оруулж ирээд байгаа нь буруу болчихоод байгаа юм. Норвегийн баялгийн сан, Монголын баялгийн сан 2 тэс өөр байхгүй юу. Тэнд эхлэхдээ ямар бодлого барьж, ямар зарчим барьж байж өнөөдөрт энэ амжилтад хүрсэн юм гэдгийг харж байж, өөрсдийнхөө байх байж байгаа энэ бодит нөхцөлтэйгөө тэдний байсан цаг үед баригдсан зарчмыг харгалзаж хийх ёстой зүйл байхгүй юу. Ийм юмнууд хийхгүй дэндүү өндөр загваруудыг авч ашиглаад байгаа нь болж өгөхгүй байгаад байгаа юм. Ерөөсөө наад үйлдвэрлэл бүх юм чинь энэнтэйгээ холбоотой. Гайгүй нэг алхам хийгээд өөрсдөө хийж чадаад эхлэнгүүт буцаагаад татаад унагачихдаг. Үгүй ээ одоо бодлого баривал барьсан шиг барья, барихгүй бол больё. Наана чинь нэг хэсэг улсууд зайлуул өр зээл хийгээд.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гантөмөр сайд гүйцээж хариулъя.

Л.Гантөмөр: Бид ярихаас илүү хийж байгаа шүү. Тэрийг Батжаргал гишүүн маш тодорхой харж байгаа гэдэгт найдаж байна. Үнэндээ бид Эрдэнэбүрэнгийнхээ асуудлыг хэдүүлээ хамтраад шийдлээ шүү дээ. Уран олборлолтоо хамтраад шийдлээ. Мөн газрын тос боловсруулах үйлдвэрийнхээ санхүүжилтийг хэдүүлээ хамтдаа шийдчихсэн. Одоо бол бид нүүрс химийн үйлдвэрийн ажил энэ зундаа эхлэх гэж байна. Намар эхэлнэ. Тэгээд дээр нь хил холболтоо бид 30 жил, 20 жил зодолдсон хил холболтоо хийж чадлаа. Би танд бол баярлалаа гэж хэлмээр байгаа юм. Манай Их Хурлын гишүүд хийж байгаа ажил, хийсэн алхамдаа нэг тийм итгэлтэй байгаасай гэж хүсэж байна. Энэ бол Монголын эдийн засгийн өсөлтийн суурийг хэдүүлээ хийчихсэн шүү. Одоо дараагийнх нь Шивээхүрэн хийнэ хэдүүлээ. Тэгээд боловсруулах үйлдвэр, зэс боловсруулах үйлдвэрээ хийнэ. Гангийн үйлдвэрээ хийх хэрэгтэй, хийнэ, сэргээгдэх эрчим хүчээ явуулна. Тэгээд бид.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Жудагийн Баярмаа гишүүн асуулт асууя.

Ж.Баярмаа: Та бүгдийн өдрийн амрыг эрье. Төсвийн орлогын ДНБ-д эзлэх хувь хэмжээ жишээлбэл 2011-ээс 20 оны хооронд 29 хувьтай байсан байна. Гэтэл сүүлийн 4 жилийн хугацаанд 35,2 их наяд болсон, 35,2 хувьд хүрсэн. Тэгэхээр энэ төрөөс хамааралтай энэ эдийн засгийн хувь нь өсөөд байна гэдэг чинь нөгөө яг тэр утгаараа нөгөө ядуурал чинь буурахгүй байгаа юм биш үү, нөгөө хувийн хэвшил чинь хөгжиж дэвшихгүй байгаа юм биш үү, нөгөө авлига чинь буурахгүй байгаа юм биш үү гээд. Ялангуяа цар тахлын дараах үеийн эдийн засгийн сэргэлт байна. Түүхий эдийн бүтээгдэхүүний үнийн өсөлтийн тэр мөчлөг дээшээ явсан үе бол одоо огцом буурч байгаа. Тэгэхээр ийм буурч байгаа үеийг бүгд мэдэж байгаа. Эхний улирлаар тэнцвэржүүлсэн тэнцэл хэд гарсныг бүгд мэдэж байгаа -350 гаруй

тэрбум. Тэгэхээр ингээд бүх юм хасах руу орж байгаа нь илэрхий болчихсон энэ үед энэ төсвийн хүрээний мэдэгдэл яг энэ 25 оны хэмжээгээр ингэж орж ирж байна.

Гэтэл бид дахиад мэдэж байгаа. 1 судалгаа 24 онд гарсан байгаа шүү дээ. 65 хүртэлх насны иргэдийн 67 бараг, 70 хувь нь боломж олдвол гадагшаа гармаар байна гэж байгаа шүү дээ. Энэ юуг хэлж байна гэвэл амьдрал маш хүнд байгааг хэлж байгаа. Маш хүнд байна. Дээрээс нь ядуурал, ядуурлын шугам чинь 400 гаруй мянган төгрөг байгаа. 15 хувиар буюу 64 орчим мянгахан төгрөг нэмэхэд дахиад ядуурлын хувь чинь 10 хувиар нэмэгдэх гэж байна. Бараг 27-гоос 37, 40 рүү орох гэж байна. Тэгэхээр энэ төсвийн хүрээний мэдэгдэлд тусгагдсан энэ макро эдийн засгийн үзүүлэлтүүд чинь ядуурлын түвшинд яаж нөлөөлөх юм бэ?

2 дугаарт Татварын багц хуулиуд чинь уг нь өмнө нь орж ирэх ёстой байсан юм биш үү? Түүн дээр чинь тэр орлого яаж бий болгох, зарлагаа яах гэдэг чинь татварын хуультайгаа уялдаж орж ирэх байсан юм биш үү? Энэ иргэдийн, аж ахуйн нэгжийн нуруун дээр үүрсэн энэ татварын дарамт ачааллыг бууруулах ийм бодлого байхгүй юм болов уу? Энэ чинь бүүр ёстой үгээ барж, үсээ зулгааж байна шүү дээ гадуур, бид бүгдээрээ л мэдээд байгаа. Тэгэхээр энэ Татварын тухай хууль яагаад орж ирэхгүй байгаа юм бэ?

3 дугаарт бид нэг ажлын хэсэг гаргаж ажиллаад, 54 дүгээр тогтоол гэж гарсан байгаа. Түрүүн Жавхлан сайд өөрөө дурдаж байна. Нөгөө бараг 1024 заалт бүхий хуульчлагдсан ийм төсөвт ачаалал болдог энэ асуудал чинь юу болсон юм бол? Миний санаж байгаагаар эхний улиралд багтааж танилцуулах ёстой байсан тийм үү? Тэгэхээр тэрийгээ уг нь зүй нь урьдчилж хэлэлцээд, түүн дээр нэлээн их юм байх байсан байх. Тэгээд тэрнийхээ дагуу энэ төсвийн хүрээний мэдэгдэл чинь өөрчлөгдөх ёстой байсан юм биш үү? Яагаад ингээд дараалал нь жоохон буруу яваад байгаа юм бол? Татварын хууль байна.

Дахиад 3 дугаарт нөгөө зээлтэй холбоотой нэг асуудал байгаа. Зээлийн, зээлийг төсвөөс гадуур хийх тийм төсөл ингээд parliament-д байршуулчихсан байгаа юм. Тэгэхээр та бүгдийн ярианд гараад байна л даа. Ерөөсөө нөгөө таазнаасаа илүү гарахгүй гээд. Тийм бол яагаад түүнийг тусад нь бие даасан хууль болгож байгаа юм бол? Төсвийн тодотголоо хийгээд, төсөв дотроо оруулаад явж яагаад болохгүй байгаа юм бол? Түрүүн Ариунзаяа гишүүн бас дурдаж байх шиг байсан. Бид өмнө нэлээд олон жилийн өмнө нэлээд олон төсөвтэй болчихсон, бүр түүн дундаа төөрөөд явж байсан. Тэгээд ашгүй ингэж явсаар байгаад нэг төсөвтэй болж авсан чинь одоо дахиад тусдаа нөгөө зээлийнхээ ашиглалтыг тусад нь гаргах гээд байгаа юм уу? Эцсийн эцэст энэ зээлийг чинь татвар төлөгчид л төлнө. Тэнгэрээс хэн нэгэн бууж ирээд энэ тусдаа юм чинь би төлчихье гэхгүй нь тодорхой шүү дээ. Тэгэхээр яагаад, ямар шалтгаанаар ингэж тусад нь гаргах гээд байгаа юм бэ? Гэхдээ тэр хуулийн төслийг уншиж байхад нөгөө тэр хязгаар заалтууд хамаарахгүй гээд биччихсэн байгаад байгаа юм. Нөгөө 2 хувиас илүү гарахгүй гэдэг бол энэ хуулиар хамаарахгүй гээд биччихсэн. Тэгснээ бас нэг заалтыг нөгөө 30 билүү эсвэл өрийн таазыг ч билүү хамаарахгүй гэсэн тийм заалтууд орчихсон мөртөө.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гантөмөр сайд хариулт өгье.

Л.Гантөмөр: Төсвийн хүрээний мэдэгдэл дээр бид ДНБ-д эзэлж байгаа орлогын хэмжээ, ДНБ-д эзэлж байгаа зардлын хэмжээгээ бууруулж явж байгаа.

Тэрийг өөрөө тоо харвал сайн харах байх. Жишээлбэл нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ ДНБ-д эзлэх хувь нь 26 онд 28,7 хувь байна гэж байгаа юм. Ингээд 27 онд 28,4 хувьтай, 28 онд 27,6 хувьтай. Буурч байгаа трендийн энэ тоог харж байгаа юу? Харж байгаа. Тийм учраас төсвийн эзлэх ДНБ-д эзэлдэг хэмжээ цаашдаа багасаад явах юм шүү гишүүнээ. Энэ тоогоо хараад, дүгнэлтээ өгөөрэй.

Огцом бууруулах бололцоогүй тухай Жавхлан сайд түрүүн хэлсэн. Нийт төсвийн урсгал зардлын 60 хувь нь цалин, тэтгэвэр байгаа. Бид төрийн албаны бүтцийн өөрчлөлт хийж байж төрийн албаны зардлыг бууруулах төлөвлөлтийг маш нарийн хийж байгаа. Энийг 26 онд хийгээд явах тухайд бид төсөөлж байгаа юм. Ер нь ядуурал яриад байдаг. Нөгөө талдаа улсынхаа унаж байгааг гайхуулаад байдаг. Тэгээд улсаа босгох тухайд бүгд ажиллах хэрэгтэй шүү дээ. Улсаа босгох тухайд хууль барь л даа, ядуурлаас гарах тухайд санаачилга гарга л даа. Хэн ядуурлаас гаргах юм ард түмнийг энэ 126 гишүүн л гаргана шүү дээ. Тэгэх гэж энд тангараг өргөж орж ирсэн шүү дээ. Тийм учраас бид нарын энэ төлөвлөлт, төлөвлөөд байгаа, амьхандаа төлөвлөөд байгаа шалтгаан ерөөсөө ядуурлын бууруулах, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, ажлын байрыг хэрхэн бид төсвийн, татварын мөнгөөр цалинжиж байгаа бид хэрхэн ажил хийх юм бэ гэдэг тухайд л бичиг баримт оруулж ирж байгаа гэдгийг гишүүд минь ойлгоорой. Энэний тухайд бид тангараг өргөсөн хүмүүс шүү. Түүнээс Монголыг муу муухайгаар нь дуудаад, тэгээд улам дордуулаад, тэгээд зүгээр тэр улсууд түүгээрээ сайхан амьдарчих байх гэдэг байдлаар. Хэрвээ тэр улсууд хувийн хэвшил түүгээрээ сайхан амьдраад бүгд ажилтай болбол төрөөр яах юм, Их Хурлаар яах юм, ЗГ-аар яах юм. Бидэнд яагаад цалин өгч байгаа юм бид энэ улсыг босгох үүрэгтэй шүү.

2 санал яваад байна. Тойргоос сонгогдсон гишүүд зовлонтой байна гэж байна. Бүтээн байгуулалт хийж өгөөч, төсвийн хөрөнгийг шийд гэдэг ийм шахалт нэг талдаа байна. Жагсаалтаар орсон хүмүүс төсвийн үрэлгэн байдлаас зугтаагаад, аль болохоор хэмнэлт гарга гэдэг шахалт байна. Бид хөгжлийн төлөвлөлтөө хараад, хамгийн ухаалаг, зөв тооцоолол хийхийг оролдож байгаа шүү. Тэгээд гишүүд жишээлбэл тэр 40 гишүүн гэнэ үү, хэдэн гишүүн байна хууль өргөн барьж байгаа тухай ЗГ-аас асуугаад байх юм. Байнгын хороон дээрээ ярь, Их Хурал дээрээ ярь.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

Б.Жавхлан: Баярмаа гишүүний асуултад хариулъя. Та төсвийн орлого нэмэгдээд байгаа асуудлыг ярилаа сүүлийн жилүүдэд. Татварын хувь хэмжээ нэмэгдсэнээс болж орлого нэмэгдсэн зүйл огт байхгүй. Манай төсвийн орлогын 1/3 нь уул уурхайгаас орж ирдэг, 1/3 нь шүү. Үүнийх нь дахиад 50 хувь нь АМНАТ-аас орж ирдэг ийм орлогын бүтэцтэй. Өөрөөр хэлбэл уул уурхайн салбар дахь бүтээмж нэмэгдэж байна гэсэн үг. Хилийн нэвтрэн өнгөрүүлэх чадвар нэмэгдэж байна гэсэн үг. Нөгөө нүүрс дагасан далд эдийн засаг маань ил болж байна гэсэн үг. Ингэснээр татварын бааз сууриуд маань нэмэгдэж байна гэсэн үг. Ингээд орлого нэмэгдсэн байгаа юм. Тэрнээс биш төр, хувийн хэвшлийн үйл ажиллагааг булааж аваад хийгээд, тэрнээс нь орлого нэмэгдсэн зүйл огт биш шүү. Харин зардал тал дээрээ харин энэ асуултыг заавал бид ярих ёстой. Зардал тал дээр, зарлагын бүтэц, ялангуяа манай төрийн нийтлэг үйлчилгээний салбарууд гудамж цэвэрлэх, бусад үйлчилгээний маш олон салбарууд байдаг. Энэ дээр төр заавал оролцоод байх шаардлага байдаггүй. Уг нь бид өмнө нь.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Жавхлан сайд гүйцээж хариулъя.

Б.Жавхлан: Зардал тал дээрээ ийм, бага минут байгаа учраас би дараагийн асуудал руу шууд орчихъё. Тэр зээлийн ашиглалт байна. Энэ дээр Баярмаа гишүүн маш сайн дахиад нэг уншаадхаарай. Би ч гэсэн цаг гаргая, нэмэлт мэдээллүүдийг өгье гэж бодоод байгаа юм. Би гишүүдийнхээ өмнөөс орж яриад байгаа нь гишүүд маань зөв юм яриад байгаа учраас би хамгаалж ярих гээд байгаа ухаантай шүү. Хамгаалж ярих гээд байгаа ухаантай. Энэ дээр ийм байгаа юм одоо Их Хурлаар ингээд баталчихсан энэ зээлийг ашигла, ав, төслийг нь хийе гээд ингээд заачихсан 88 төсөл байгаа. 88 төслийн 14 их наяд төгрөгийн зээл ашиглагдаагүй гадна талдаа хүлээж байгаа. Үүний 8 их наяд нь буюу бараг 60 хувь нь энэ гуравхан төсөл дээр, энэ 3 төсөл дээр. Энэ 3 төслийн 8 их наядыг бид 28 он гэхэд зарж ашиглаж дуусаад, төслийг ашиглалтад оруулах ёстой. Бид үүнийг төсөв дээрээ багтаах ойрын 3 жилийн төсвийн багтаамж бидэнд байхгүй, хэмнээд, хэмнээд бид цалин, тэтгэвэр.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Жудагийн Баярмаа гишүүн тодруулж асууя.

Ж.Баярмаа: Энд ингэж заасан байгаа. Жишээлбэл энэ жилийн орлого 30 их наяд хүрэх үү? Хүрэхгүй бол дараа жилийн энэ та нарын тооцоолсон орлого ч хүрэхгүй гэсэн үг шүү дээ. Тэгэхээр чинь бүхэлдээ энэ төсвийн хүрээний мэдэгдэл чинь асуудалтай болж байна гэсэн үг.

2 дугаарт жишээлбэл та татварын орлогоор төсвийн орлого нэмэгдэж байгаа үгүй, нэмэгдэхгүй байгаа гэж хэллээ л дээ. Зүгээр миний санаж байгаагаар жишээлбэл хувь хүний орлогын албан татвар дээр гэхэд сүүлийн хэдэн жил 20 хувь болсон байгаа байхгүй юу. Тийм, тэгэхээр яах вэ бааз сууриа нэмэхийн тулд өөр ямар татварын бодлого баримталж байгаа юм бэ, тэрийгээ яагаад түрүүлж оруулж ирээд, тэндээс чинь энэ Төсвийн хүрээний мэдэгдэл чинь шал өөр болох ёстой юм бус уу? Шал өөр болох ёстой шүү дээ. 2-т та нөгөө энд оруулаагүй байгаа 5 их наяд байгаа гэж ярьдаг тийм үү, нөгөө хуульчлагдсан.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Жавхлан сайд хариулах уу? Баярмаа гишүүнд 1 минут.

Ж.Баярмаа: 5 их наяд гэж би нөгөө хуулиар зарлага болж орж ирэх ёстой мөнгө гээд байгаа юм. Тэрийгээ та яагаад учир начрыг нь олоод энэ төсвийн хүрээний мэдэгдэлдээ тодорхой байдлаар тусгаагүй юм бол? 2 дугаарт 14 их наяд 8 их наядыг нь зарах ёстой. Би энэ зээл дээр гайхаад байгаа байхгүй юу. Хэзээ, хэн, ямар зорилгоор, ямар зориулалтаар, ямар хүүтэй, хэзээ авсан юм бэ? Тэгээд авахдаа энэ чинь хугацаа, хүү юмаа тохирчихсон, тэгээд тэрнийхээ дагуу энэ төсөвтөө суугдаад явдаггүй байсан юм уу? Тэгээд тэрнийхээ дагуу шаардлагатай гэвэл тэр тааз юмаа өсгөхөд буруу юм байхгүй шүү дээ уг нь. Тэгээд ингээд бүх юм нь ингээд ямар ч уялдаагүй явж байгаа нь харагдаад байна л даа. Тэгээд л тийм ч учир араас нь хуулийн төсөл барьж орж ирж байна шүү дээ жишээлбэл. Тэгээд дараагийн 8 их наяд нь юунд зарцуулагдах ёстой мөнгө юм, биш ээ 6 нь. 8 нь саяын 3 төсөлд гэж байна. 6 нь юунд зарцуулагдах юм бэ?

3 дугаарт тэр Сэлбэ гээд. Та өөрөө сая хэлж байна шүү дээ. Хувийн хэвшил.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

Б.Жавхлан: Сүүлийн хэсгээс нь хариулъя. Сүүлийн 30 жилийн хугацаанд ЗГ, Улсын Их Хурал дээр оруулж танилцуулаад, Улсын Их Хурал санаачилсан ийм төслийн зээлүүд ч байгаа. Нийтдээ 88 ийм зээл хөтөлбөрүүд байгаа гэсэн үг байхгүй юу. Сүүлийн 30 жил шүү. 30 жилийн хугацаанд, сүүлийн 1 жил, 2 жил биш, сүүлийн 5 жил биш, сүүлийн 30 жил авч хэрэглэж байгаа ийм зээл, төслүүд юм байгаа юм. Сүүлийн үед жишээ нь нефть боловсруулах үйлдвэр маань Монгол Улсын хувьд бидний хамгийн том төсөл болж байгаа. Зээлээр, гадаад зээлээр санхүүжиж байгаа хамгийн том төсөл болж ирж байна. 1,6, 1,7 тэрбум доллар буюу 5,6 их наяд төгрөгийн ийм төсөл болж байна. Тийм учраас эдийн засгаа дагаад төслүүд маань ч өөрөө томорч ирж байгаа учраас энэ маань эргээд энэ өрийн, би түрүүн хариулж амжсангүй уучлаарай, өрийн хязгаар дотроо багтаж байгаа шүү. Бид өрийн хязгаарыг хэзээ ч хөндөж болохгүй. 2015 онд би нэр заахаа больё, 2015 онд.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Жавхлан сайд гүйцээж хариулъя.

Б.Жавхлан: 2015 онд өрийн хязгааруудыг нь авч байгаад энэ төслийнхөө хязгааруудыг авч байсан тийм тохиолдол байгаа. Энэ удаа гишүүдийн санаачилж байгаа, судалж байгаа зүйл дотор төсвийн зардлын хязгаар дотроо өөрчлөлт хийж байгаа. Тэрнээс биш өрийн хязгаарыг бол огт хөндөөгүй. Энэ 2 шал 2 өөр ойлголт шүү. Тийм учраас төсвөөс гадуур гэдэг ойлголт байхгүй. Өрийн хязгаар дотроо ороод, энэ төсвийнхөө менежмент дотроо 100 хувь багтаад явна. Төсвийн зардлын хязгаар гэдэг өөр ойлголт байгаа. Нэг нь юу гэлээ? Тэр татварын хувь хэмжээ эд нар ерөөсөө өөрчлөгдөөгүй. Энэ удаа чинь бид төсөв яриагүй, төсвийн хүрээ, дандаа хязгаар ярьж байгаа шүү. Хязгаар ярьж байгаа юм, энэ хязгаар дотроо бид амьдарна, хязгаар дотроо бид татварынхаа шинэчлэлийг хийнэ.

Д.Амарбаясгалан: Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асууя.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Төсвийн төсөөлөл, төсвийн хүрээний мэдэгдэл бол үндсэндээ энэ бүрэн эрхийн хугацаанд ирэх 2026, 27, 28 онуудад улс орон, айл өрхийн, аж ахуйн нэгжийн амьдрал ахуй ямар байх юм бэ гэдгийг төсөөлж тооцоолж гаргасан эдийн засгийн бодлогын баримт бичиг. Энийг харж аж ахуйн нэгжүүд, хувийн хэвшлийнхэн үйл ажиллагаагаа, бизнесээ төлөвлөх ёстой. Тэгээд энэ төсөөллийг харахаар ерөөсөө 9 үндсэн үзүүлэлт байгаа. Тэгээд ДНБ өсөж байгаа үнэн, улсын төсвийн орлого өсөж байгаа нь үнэн, орлогоо дагаад зарлага нь өсөж байгаа нь үнэн. Нэг үеэ бодоход өнгөрсөн парламент, ЗГ чинь харин өнгөрсөн 4 жилд ковидын үеийн 14, 5 хувийн дотоодын инфляцыг өсөлтийг бууруулж нэг оронтой тоо руу оруулж чадсан шүү. Өнөөдөр зүгээр бараг 9, 10 руу орж байгаа байх инфляц. 6, 7-гоос өсөөд эргээд энэ бүрэн эрхийн хугацаанд. Эргээд өсөж байгаа.

Та бүхний энэ тооцооллоос харахаар 3 дээр байгаа, 2 дээр байгаа хэрэглээний үнийн өсөлтийн түвшин энэ л ганц худлаа тоо байна гэж би харах гээд байгаа юм. 26 онд 7 хувьтай байна эдийн засгийн хэрэглээний үнийн өсөлт. 27 онд 6,4, 28 онд 6 хувь. Энэ тоо баримтуудыг юунд, ямар тооцоо судалгаанд үндэслэж гаргасан юм бэ? Өнөөдөр Монгол Улсад бараа, бүтээгдэхүүний үнэ буурч байгаа асуудал байгаа юу, үгүй юу? Өдөр өдрөөр бараа бүтээгдэхүүний үнэ 5, 10 цаасаар өсөж байгаа шүү дээ. Гэтэл бид бүхний энд ярьж байгаа тооцоо судалгаа, бодлогын баримт бичиг болохоор инфляцыг өргөн хэрэглээний бараа,

бүтээгдэхүүний үнийн өсөлтийг 7 хувьд хүргэнэ 26 онд, тэгээд 6,4-д хүргэнэ 27 онд, 28 онд 6 хувьд хүргэнэ гээд. Энэ чинь өөрөө амьдралтай нийцэж байна уу, үгүй юу? Монголд ер нь бараа, бүтээгдэхүүний үнэ буурч байсан тохиолдол байдаг уу? Гэтэл бодлогын баримт бичиг дээрээ бид хувь хувиар бууруулж байна шүү дээ. Тэгэхээр энэ юу нь ямар тооцоо судалгаанд үндэслэж ингэж хэрэглээний үнийн өсөлтийг тооцож гаргаж ирж байгаа юм бэ? Хэрэглээний үнийн өсөлт гэдэг ерөөсөө иргэн хүний дэлгүүр хоршоонд ороод худалдан авалтын тэр тор сагсаар л хэмжигдэнэ шүү дээ. Мянга дотоодын нийт бүтээгдэхүүн өсөөд, мянга төсвийн орлого өсөөд иргэн хүний амьжиргааны түвшин нэмэгдэхгүй бол тэр мянга өссөний хэрэг гэж юу байх юм бэ.

Гадаа гудамжинд гараад иргэдээс та бүхний амьдрал ахуй ямар байна вэ гэж асуувал сайн гэж хэлэх хүн хэр байгаа бол? Бараа, бүтээгдэхүүн нь буурч байгаа юу гэж асуувал юу гэж хариулах бол? Тэгэхээр бид нарын энэ ярьж байгаа бодлогын баримт бичиг чинь ер нь амьдралтай хэр нийцэж байгаа юм бэ? Ямар тооцоо, судалгаанд тулгуурлаж хийгээд байгаа юм бэ? Ядаж энэ хэрэглээний үнийн өсөлтийн түвшнээ зөв, бодитой тооцоолж оруулж ирж болдоггүй юм уу? Та бүхний гаргаснаар хэрэглээний үнийн өсөлтийг бууруулах нь л дээ 26 онд, 27 онд, 28 онд. Бараа, бүтээгдэхүүний үнэ дагаад буурна гэсэн үг шүү дээ энэ тооцооллоор чинь, ингэж чадах юм уу? Энэ дээр Төсвийн тогтвортой байдлын зөвлөл юу гэж үзэж байгаа юм, ямар санал өгсөн юм бэ? Төсвийн тогтвортой байдлын зөвлөл энэ төсөөлөлд хэрхэн саналаа ирүүлсэн юм бэ?

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Эхлээд Эдийн засаг, хөгжлийн яамны дарга Энх-Амгалан 4 дүгээр индрээс хариулт өгнө.

Л.Энх-Амгалан: Гишүүний асуултад хариулъя. Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамнаас. Одоо инфляцын түвшин 8,6 хувьтай байна улсын дунджаар. 26 онд инфляцыг бид хэд 7 хувь, 27, 8 онд 6 хувь руу ороод буурчихна гэсэн ийм төсөөлөл хийж байгаа юм. Инфляц буурахад инфляцыг тооцохдоо нийт 430 бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлтийн дунджаар тооцдог. Яг өрхийн хэрэглээнд ямар жинтэй хэрэглэгддэг вэ тэр жингээр нь. Тэгээд инфляц яагаад буурна гэж байгаа вэ гэхээр Монголбанкны зорилт 5 хувь байгаа дараа жилээс. Дээр нь Засгийн зүгээс хүнсний нийлүүлэлтийг нэмэгдүүлэхтэй холбоотой хөтөлбөрүүд хэрэгжүүлж байгаа. Энэ хүрээнд илүү нийлүүлэлтийн гаралтай инфляц буурна, саарна 7, 6 хувь руу очно гэж үзэж байгаа. Дээр нь нэмээд хил гааль дээр саатал үүсгэхгүй байх чиглэлд Замын-Үүд, Алтанбулаг дээр хил гаалийн шинэчлэл, ялангуяа давхар төмөр замын асуудлууд шийдэгдэж байгаа. Тэгэхээр хил гаалийн гаралтай инфляц дээр ирдэг тэр нэмэлт гайгүй болно гэж үзэж байгаа юм. Дээр нь нэмээд экспорт цаашаа 26, 7 ондоо тогтвортой байна. Валютын нөөц харьцангуй тогтвортой байх учраас ханшаас ирэх дарамт гайгүй байна гэсэн ийм төсөөллүүд, суурь төсөөллүүдийн хүрээнд инфляцыг одоогийн түвшнээс буураад 7 хувь, 6 хувь руу очно гэж ингэж тооцоолсон байгаа.

Д.Амарбаясгалан: Гантөмөр сайд нэмж хариулъя.

Л.Гантөмөр: Бид юмны үнэ буулгана гэдэг тоо биш шүү дээ. Харин 7 хувь өсөх юм байна л гэж байгаа юм. 27 онд дахиад 6 хувь өсөх юм байна гэж байгаа юм. Тэгэхээр өсөлтийг нь 7 хувь дотор хязгаарлах боломжийн тухайд л бид ажиллая гэж байгаа юм. 7 хувь дотор хязгаарлахын тулд бид яах вэ гэвэл мөнгөний элбэг тараалт, нийлүүлэлт дээр таталттай явна. Төгрөг чинь гадуур их

элбэг, элбэгдэхээр л, 24 онд жишээлбэл сонгууль боллоо. Мангар их мөнгө гадагшаа зах руу нийлүүлээ, мангар их зардал гаргалаа үр дүнд юу болсон бараа өссөн, импорт нэмэгдсэн, бид валютаа алдсан. Тийм учраас энэ үзэгдэл нь өөрөө манайд байгаа үзэгдэл өөрөө ямар нэгэн техникийн саатлаас болоод үнэ өсөөд байгаа юм алга байна. Үзэгдэл нь 2 шалтгаан байна үндсэн. Нэг нь хүмүүс мөнгөтэй болохоор дагаад манай худалдаачид бараагаа үнээ нэмээд 1. 2 дахь нь.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Болдын Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Гантөмөр гишүүн, сайд сая бараг хариулчихлаа даа. Энэ төсвийн хүрээн дээр орж ирж байгаа бидний зорилтот түвшин шүү. Тэрнээс бодит гүйцэтгэл биш. Мөнгөний бодлого жишээ нь орж ирэхдээ 5 дээр +, -2 гэдэг инфляцын зорилтот бидний онилох түвшин маань тэр юм. Тэр лүү бид бүх бодлогын хэрэгслүүдээ чиглүүлнэ гэдгийгээ олон нийтэд, хувийн хэвшилд, хөрөнгө оруулагч нарт зарлаж байгаа юм. Өөрөөр хэлбэл хүлээлтийг энүүгээр дамжуулж удирдана гэсэн үг. Хэрвээ бид 10 +, -2 гээд л оруулчихвал хүлээлт тэр лүүгээ яваад, бүх юм тэр лүүгээ явчихна. Тийм учраас бид аль болох нам дор ийм зорилтот түвшин рүүгээ мөнгөний бодлогоо ч тэр, төсвийн бодлогоо ч тэр, хөрөнгө оруулалтын бодлогоо ч тэр ингээд чиглүүлнэ. Энийгээ олон нийтэд, ялангуяа хувийн хэвшил, хөрөнгө оруулагч нарт ил тодорхой бодлогоо танилцуулж байгаа ийм түвшин юм л даа. Тэрнээс биш бид 7-д хүрчих байх, 6,4-д хүрчих байх, 6-д хүрчих байх гэдэг тийм зүйл биш.

Д.Амарбаясгалан: Цэндийн Сандаг-Очир гишүүн тодруулж асууя.

Ц.Сандаг-Очир: Та нар маань ч асуусан асуултад сайхан хариулах юм. Албан тушаалтнууд, сайдууд зүгээр аргалаад өнгөрөх юм. Үгүй ээ тэгээд ийм хүрэх зорилтот түвшинд ингэж хүрэхгүй юм бол ямар юмны ингэж баталж, ингэж батлах ёстой юм энэ хуулийг. Бууруулах биш зүгээр 7 хувиар өсгөх юм гэж хариулж байж ийм утгагүй хариулт өгч болохгүй шүү дээ. Одоо байгаа 8,6 хувийг инфляцын өсөлтийг 7 хувьд хүргэнэ гэж ингэж 2 хувиар бууруулах юм байна гэж ойлгосон шүү дээ. Гэтэл нөгөө талаас нь ингээд л аргалаад тайлбарладгаа боль л доо та бүхэн. Ямар цэцэрлэг, сургуулийн хүүхдүүд маллаж байгаа биш. Та бүхэн гудамжинд гараад хар л даа, дэлгүүр хоршоогоор яв л даа. Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ чинь буурч байгаа юм уу. Тэр 2, 3 мянган бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлтийг дунджаар авдаг гээд тэр яамныхан чинь хэлээд байна шүү дээ. Тэгээд үнэ буурсан бараа.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ганбатын Очирбат гишүүн асуулт асууя.

Г.Очирбат: Өдрийн мэнд хүргэе. Нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-гоос 28 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл энэ удаа нэлээн сайн боловсруулагдаж орж ирсэн байна гэж харж байгаа. Яагаад гэхээр бид тодорхой төсвийн алдагдалгүй байя гэсэн 26, 27, 28 онууд дээр алдагдалгүй төсөвтэй байна гэж оруулж ирж байгаа. Үүнтэй холбоотой Төсвийн тогтвортой байдлын зөвлөл 26, 27, 28 онд алдагдалтай байна гэж байгаа юм. Тэгэхээр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс асуух гэсэн юм. Энэ тоог ямар бодлогоор оруулж ирсэн юм бэ нэгд?

2-т нь 3Г-аас авч хэрэгжүүлэх албан татварын бодлогын шинэчлэлийг ингээд хэрэгжээд явна. Өчигдөр Жавхлан сайдаас асуусан энэ жил, дараа жил, тэрний дараа жил гээд 4 жилийн дотор бид хийнэ гэж байгаа юм. Яг энэ жил орж ирэхэд нь нэмүү өртгийн албан татвар юм уу, хувь хүний орлогын албан татвар юм уу, АМНАТ юм уу аль татвар нь, яаж, яг тодорхой ийм түвшнээр ингэж бууна гэж эхний ээлжид ингэж үзэж байна, дараа жил ингэнэ гэдэг энэ дээр нэг тодорхой хариулт авчихъя?

2-т нь эдийн засгийн бодит салбаруудыг татааснаас чөлөөлөх бодлого баримтална гэсэн. 2026-аас 28 онд яг ямар бодлого хэрэгжүүлээд аль, аль татааснуудыг байхгүй болгох гэж байгаа юм. Тэрийг нь 25 оны, 26 онд яг энэ, 27 онд энэ, 28 онд энэ, энэ татааснууд байхгүй болох юм гээд ийм хариултыг авчихъя? Тэгээд тодруулъя. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Сангийн сайд Болдын Жавхлан.

Б.Жавхлан: Очирбат гишүүний асуултад хариулъя. Татварынхаа багц хуулийг бид ямар ч байсан энэ хаврынхаа чуулганд багтааж өргөн барина, ингээд хичээж ажиллаж байгаа шүү. Нэлээн хүлээлт үүсчихсэн, бид хэлэлцүүлгийг энэ жил маш сайн хийсэн. Хэлэлцүүлгийг өмнө нь Татварын багц хуулийн шинэчлэлүүдээр ийм хүрээнд хийж байгаагүй. Тийм учраас бид ямар ч байсан энэ хавартаа багтаагаад өргөн барьчихъя. Харин ер нь 3, 3-аас 4 багц шинэчлэл болно гэж ойлгоорой. Тэгэхээр 26, 27, 28 онууд дээрээ бид ингэж тарааж шат дараатай явахаас өөр аргагүй. Энэ нь өөрөө багагүй өртөгтэй ийм шинэчлэл болно. Дор хаяж 4 их наядын орлогод сөрөг дарамт ирэхээр ийм татварын шинэчлэл болно гэсэн үг. Тэгэхээр нэг төсөв дээр яагаад ч дийлэхгүй.

Тэгэхээр ирэх оны эдийн засгийн төсөөллүүд маань ямар байх нь вэ, 26 онд яаж тусах нь вэ, энэ төсвийн хүрээ маань өөрөө яаж өргөн баригдаж, яаж батлагдах нь вэ энэнээс харж байж бид аль бага ачаалал өгөхөөс нь л эхэлнэ дээ. Бага ачаалал өгөхөөс нь эхэлнэ. Тийм учраас энэ удаагийн Татварын багц хууль ХХОАТ, ААНОАТ, НӨАТ болон бусад татварын харилцаа, татварын харилцаа гэдэг нь татвараа тайлагнахаас эхлүүлээд л энэ бүгд дээр шат дараатай, маш өргөн хүрээтэй ийм шинэчлэлүүдийг хийж байгаа. Ер нь нэлээн либералчилж байгаа, хувийн хэвшлээ нэлээн дэмжсэн, нэлээн эдийн засгийн өчигдрөөс эхэлж бид нарын ярилцаж байгаа төлөвлөгөөнд туссан үзэл баримтлал буюу эдийн засгийн эрх чөлөө, энэ бол эдийн засагт оролцогч бүх талуудыг хамруулж яригдаж байгаа асуудал шүү. Тийм учраас татвар дээр ч гэсэн мөн шинэчлэл тэр өргөн хүрээнд явна гэж ойлгож болно.

Яг аль хэсэг нь 26 онд хэрэгжиж эхлэх вэ гэдгийг яг өнөөдөр хэлэхэд арай эрт байна Очирбат гишүүнээ. Бид ямар ч байсан хавартаа, хаврынхаа чуулганд багтаад өргөн бариад, хэдүүлээ эхний хэлэлцүүлгээ амжвал хийчихнэ гэсэн ийм төлөвлөгөөтэй байгаа. Тийм. Ер нь гишүүдийг энэ татварын багц хууль, татварын асуудал нэлээд ачаалал өгдөг юм шиг байгаа юм, нийгмээс нэлээн тийм захиалга дарамт ийм юмнууд ирдэг байх. Тийм учраас бид ойлгож байгаа. Гишүүдийн өргөн барьсан татварын хуулиуд дээр өөрчлөлт оруулах зүйлүүдийг ч тодорхой хэмжээнд хамруулж тусгасан байгаа. Тэр татварын асуудлуудаар хууль хөндөж өргөн барьсан гишүүдтэй ч мөн уулзаж их, бага хэмжээгээр энэний ойлголтуудаа өгч, тайлбарлаж ингэж явж байгаа шүү. Тийм. Тэрийг манай ажлын хэсгээс хариулаадхаач, тэндээс хариулчихъя.

Д.Амарбаясгалан: Санжаадорж 4 дүгээр индрээс нэмэлт хариулт өгье.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя. Ер нь төрийн бүх чиг үүргийн бүрэн хэмжээний шинжилгээг хийх шаардлагатай байгаа гэж ЗГ-ын зүгээс үзэж байгаа. Тусгайлан яг таны асуусан татаасны хувьд зарим татааснууд хэрэгжиж эхэлснээс хойш 10-аад жил болчихсон татаас байна. Зарим нь 15 жил, зарим нь хэрэгжиж эхлээд 2, 3-хан жил болж байгаа татааснууд байна. Гэтэл эдгээр татааснуудын маань анх ингээд татаас бий болсон зорилго, зорилтууд маань юу байсан юм бэ, тухайн зорилтдоо хүрсэн юм уу, хүрээгүй юм уу, одоо тухайн үеийн тэр дэвшүүлж байсан тэр триггер буюу тэр тавьсан зорилт маань биелсэн юм уу, одоо бид ЗГ-ын хувьд ямар бодлого цаашид авч явах ёстой юм бэ гэдэг дээр бүрэн хэмжээний үнэлэлт дүгнэлт өгөх шаардлагатай байгаа. Энэ судалгааг Сангийн яамнаас зохион байгуулаад хийж байгаа. Намрын төсөв дээр энэ талаар санал оруулна. Ажлын хэсэг дээр мөн.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Очирбат гишүүн тодруулж асууя.

Г.Очирбат: Харин ингэхээр л эргэлзээтэй байдал үүсчхээд байгаа юм л даа. Энд байгаа Их Хурлын гишүүд гараад иргэдтэй уулзана. Уулзаад яг Засаг дээр ийм бодлого, хууль ингэж батлагдсан. Тийм болохоор энэ төрлийн татаас бол байхгүй болох гэж байгаа гэхээр тэр татаас авч байгаа салбарынхан бэлтгэл ажлаа хийх ёстой шүү дээ. Тэгээд бид ингээд цаасан дээрээ болохоор ингээд бичээд оруулаад ирдэг, татаасыг чөлөөлөх бодлого баримтална гэхихсэн мөртөө яг аль, аль татааснуудаа чөлөөлөх гээд байгаа юм гэхээр хэлж чадахгүй.

Татварын шинэчилсэн реформ хийнэ гэххээд байгаа юм. Яг аль, аль татваруудаа яаж буулгах гээд, хэзээнээс юм гэхээр хэлж чадахгүй. Тэгэхээр энэ чинь л ийм эргэлзээтэй байдлыг үүсгээд яваад байгаа юм. Тэгээд л иргэд, энэ Их Хурлын гишүүд ч хэлж байна шүү дээ нэг тунхгийн чанартай ингээд бүх юм явдаг. Тоотой, төлөвлөлттэй, үр дүн нь тодорхой ингээд явчихвал уг нь юм их нээлттэй, их амар болох гээд байгаа юм л даа. Тэгээд асуулт асуухаар ер нь ингээд дандаа ийм нэг тойрсон маягтай хариулаад, тодорхой тоон дээр биш, тодорхой нэр томьёо.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Жавхлан сайд хариулт өгье.

Б.Жавхлан: Хэдхэн хоног тэсчих дээ. Хаврын чуулгандаа багтаад Татварын багц хуулийн шинэчлэлийг өргөн барина. Тэр үед илүү их тодорхой ярих боломж гарах байх тийм. Одоо яг өргөн баригдчихаагүй байгаа учраас дэлгэрэнгүй ярих боломжгүй байгаад байна. Ер нь төсөл нээлттэй байгаа шүү дээ. Та ч хардсан болов уу гэж найдаж байна. Төсөл бол маш ойлгомжтой, олон нийтэд нээлттэй санал аваад явж байгаа, маш тодорхой байгаа. Харин аль алийг нь, хэзээнээс, яаж хэрэгжүүлж эхлэх вэ гэдэг дээрээ судалгаа хийх, шинжилгээ хийх шаардлагатай байна. Энэ чинь гадна талд тодорхойгүй байдлууд жилээр биш, улирлаар биш, сараар биш энэ чинь өдөр өдрөөр өөрчлөгдөөд байгаа ийм үед бид шинжилгээ хийх шаардлагууд гарч ирээд байна. Тийм.

Д.Амарбаясгалан: Тодруулах юм уу? Тогтвортой байдлын зөвлөлөөс 3 дугаар индрээс хариулт өгье.

А.Энхбат: Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Энхбат. Бид хуулиараа 3 дугаар сарын 15-ны дотор дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн таамаглалыг боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөллийг Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн. Мэдээж энэ дээр бид тодорхой загварууд дээр үндэслэж тооцоо судалгаануудыг гаргаж ирсэн байгаа. DIGNAR гэж загвар байдаг ОУВС-ийн, мөн түүнчлэн КЭМ гэж загвар байгаа. Эдийн засаг, хөгжлийн яам энэ жил эдийн засгийн энэ дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулахдаа энэ ОУВС-ийн санхүүгийн хөтөлбөр Файнаншиал программ гэдэг загвар дээр суурилж тооцоогоо гаргасан байгаа.

Зөрөө юу байгаа вэ, алдагдал яагаад ингээд гарсан бэ гэдэг асуудал. Тэгэхлээр бид түрүүн ч гишүүдийн яриан дээр гаргаж байсан. Төсвийн орлогоо зөв тооцоод, зарлагаа түүнд нийцүүлэх зарчмыг баримтлахыг Төсвийн тогтвортой байдлын зөвлөл удаа дараа анхааруулж байгаа. Энэ дээр гол асуудал юу вэ гэхлээр одоогийн энэ тэнцвэржүүлсэн үнээр тооцсон орлого бодитой төлөвлөгдөх магадлал бага байгаа. Үүнийгээ дагаад төлөвлөсөн зардал, нийт зарлага, цэвэр зээл макро эдийн засгийн өнөөгийн болон дунд хугацааны нөхцөл байдалтай нийцтэй бус, цаашид тэнцвэржүүлсэн үнийн тооцооллын алдагдлыг, аргачлалыг өөрчлөх шаардлагатай гэсэн ийм дүгнэлтүүдийг өгсөн. Энэ дээр бүүр тодорхой би зүгээр яг энэ эрдэс баялаг уул уурхайн салбараас орж ирэх энэ үнийн, түүхий эдийн үнэ, энэ дээр нүүрс, алт, зэс, төмрийн хүдэр дээр бид нарын тооцоо Эдийн засаг, хөгжлийн яамны тооцоо зарим талаараа зөрөөтэй байгаад байгаа. Энэнээсээ шалтгаалаад нийт дүнгээрээ жишээлбэл Эдийн засаг, хөгжлийн яамны дунд хугацаанд төсвийн хүрээний мэдэгдэлд оруулж ирсэн 26 оны төсвийн төсөөллөөр түүнээс орж ирэх орлого 15,1 тэрбум доллароор тооцсон байж байгаа. Бидний тооцоогоор болохлоор 14 тэрбум доллароор тооцсон. Энэ дээр биет хэмжээ болон үнийн тооцооллууд 26 он, 27, 28 онуудад.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

А.Энхбат: Тухайлбал нүүрснээс бусад төмрийн хүдэр гэдэг юм уу, зэсийн баяжмал, алтны хувьд Эдийн засгийн хөгжлийн яам нийтдээ төмрийн хүдрийн үнийг 69 ам.доллар тонн тутмыг, зэсийн баяжмалыг тонн дотор 2699 ам.доллароор тооцсон байсан. Бид арай багаар төмрийн хүдрийн үнийг 64 ам.доллар, зэсийн баяжмалын үнийг 2028 ам.доллароор тооцсон. Биет хэмжээ дээрээ мөн ялгаагүй зөрүүнүүд жишээлбэл төмрийн хүдэр дээр 822 ам.долларын зөрөө гарч ирж байна. Зэсийн баяжмал дээр бидний тооцоо арай өөдрөг 252 ам.доллароор илүү тооцсон. Алтны хувьд Эдийн засаг, хөгжлийн яам 26 онд 19,8 тонныг бид экспортолно гэсэн ийм тооцоо хийчихсэн. Бид 12,8 тонныг тооцож гэж тооцоод 7 тонны зөрөөтэй ийм тооцоонууд гарч ирснээсээ шалтгаалаад энэ чинь нийт нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг тооцож байгаа уул уурхайн салбараас орж ирэх орлогод шууд нөлөөлөөд тооцоо гарч ирж байгаа юм. Ийм зөрөөнүүд гарч ирж байгаа юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулъя.

Б.Жавхлан: Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхөн маань тоонуудаа цаг хугацаанд нь өгсөн. Тэгэхдээ одоо энэ өргөн баригдаж байгаа ЗГ-ын тооноос зөрөөтэй байгаа шүү. Зөрөөтэй байгаа. Энэ аягүй чухал асуудал яригдаж байхад

манай гишүүд маань энэ идэвхтэй зааландаа энэ тоонуудыг сонсчихвол их зүгээр байгаа юм. Юун дээр зөрж байсан бэ гэхээр 3 тоон дээрээ зөрж байгаа. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс орж ирсэн тэнцэл маань алдагдалтай байна гэж орж ирж байгаа. ЗГ-аас өргөн барьж байгаа төсвийн хүрээ алдагдалгүй өргөн барьсан. Зарлага талдаа Төсвийн тогтвортой байдлын зөвлөл 2,3 их наядаар өндөр байгаа, орлого талдаа 1 их наядаар өндөр байгаа. Тэгэхээр ЗГ-аас оруулж ирсэн төлөвлөлтийн тоонууд нь арай нэлээн багасгаж, нэлээн татаж, тэгээд алдагдалгүй төсөв байхаар төсвийн хүрээний тоонуудыг өргөн барьсан байгаа гэдгийг тодруулж хэлье.

Д.Амарбаясгалан: Жанчивын Галбадрах гишүүн асуулт асууя.

Ж.Галбадрах: Өдрийн мэнд хүргэе. Төсвийн маань мэдэгдэлд үндсэн 9 үзүүлэлт байна. Би энд өнгөрсөн 25 оны төсвийн мэдэгдэлтэй энэ 26 оныхыг ингээд харьцуулаад хараад сууж байна. Бид дөнгөж сонгогдоод 9 сард яг энэ төсвийн 25 оны төсвийн мэдэгдэл орж ирж байсан. Тэр тоон дээр 26, 27 оны төсвийн төсөөлөл бичигдсэн нь энэ жилийн 26 он дээр ингээд орж ирэхэд их нэлээн зөрөөтэй байна. Тэгэхээр энэ зөрөөнүүдийг бид их бодож, энэ дээрээ дүгнэлт хийж, аль болохоор жишээлбэл сая хэрэглээний үнийн өсөлтийн түвшин 25 оны төсвийн төсөөлөл дээр 26 оныг 5 хувьд байна гэсэн бол одоо бид 7 хувь болчихсон. 7 байтугай 8, 9 хувь руу орчихсон байна гээд ингээд ярьж байна. Тэгэхээр энэ бол ингээд 40 хувь, тэрнээс дээшээ 50, 60 хувиар ингээд зөрөөтэй болж орж ирж байна. Тэгэхээр энэ үндэслэлээ бид яг барихын тулд цааш нь 6,4, 6 хувь багасгаад явна гэж байгаа. Энэ үндэслэлүүдийг л сайн сонсмоор байна.

ДНБ мөн л зөрөөтэй байж байна. Бид 8, 6,5 хувьд барина гэж байсан бол одоо 6 хувьд барина гэсэн ийм төлөвлөлт орж ирж байна. Тэр нь ч багасах ч юм уу тийм ээ, илүү -7,7 хувиар ингээд багасаж байна. Тэрнээс гадна орлого ерөнхийдөө 3,7 хувиар би ингээд харьцуулж харсныгаа хэлж байна 26 онтой, 27 оны, 25, 26 оны төсвийн төсөөллөө харьцуулахад 3,7 байгаа бол. Харин энэ дээр сайшаалтай нь зарлагаа багасгаж гаргаж ирсэн нь зөв байна гэж харж байна. Нэлээн ажиллаад гаргасан төсөөлөл байна гэдгийг ингэж харж байна. Ингээд үүнтэй холбогдуулаад 3 асуулт байж байна.

1 дүгээрт эдийн засгийн хүндэрч байгаа энэ үед ДНБ-ийг дээшлүүлэх, инфляцаа тогтворжуулахын тулд хөрөнгө оруулалт, ялангуяа экспортын төслүүдийг хамтад нь танилцуулбал зөв байсан юм болов уу? Ийм төслүүд байна уу? Ийм юм байвал танилцуулж өгөөч. Ийм төслүүдийн орчнуудыг хэрхэн бүрдүүлж байгаа вэ гэдэг 1 дүгээр асуулт байна.

2 дугаар асуулт нь Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс хуваарилах зардлын хэмжээг нэмэгдүүлэхээр жил болгон нэмэгдэхээр ирж, өмнөх жилтэй харьцуулахад багассан байна. Гэхдээ л бид чинь халамжаас татгалзана, халамжийг аль болохоор танана гээд байгаа юм. Гэтэл танасан зүйл юу байна вэ гэдгийг нийгмийн халамжийн тал дээр асуумаар байна.

3 дугаарт нь яалт ч үгүй л ядуурал бодитой нүүрлэсэн. Тэгээд ядуурлын энэ ард түмэн маань, иргэд маань бүгдээрээ л энэ ядуурлын тойрогт орчхоод байна. Тэгээд энэ ядуурлын тойргоос гаргах түрүүн Гантөмөр сайд ярьж байсан. Ядуурлаас гарах аргаа л бүгдээрээ гарц гаргалгаагаа гаргая гэсэн. Энэ бол ерөөсөө олон улсын ч туршлага байна, ерөөсөө энэ бол боловсролоо л

чанаржуулах зүйл байгаа. Тэгэхээр ерөөсөө ганц гарц нь боловсрол. Тэгэхээр энэ боловсролоос гаргахын тулд бид hard буюу хүртээмж дээшлүүлэх тал дээр Сангийн яамтайгаа харин нэлээн нэгдсэн ойлголцолд хүрээд, Боловсролын яам маань ороод явж байгаад их таатай байгаа. Улам ч бид нарт нягтлах зүйлүүд их байгаа. Гэхдээ энэ боловсролын чанарыг дээшлүүлэхэд хамгийн гол нь багшлах боловсон хүчний асуудал байгаа. Тэгээд багшлах боловсон хүчин дээр дорвитой, ирэх жилийг бид боловсролыг дэмжих жил болгосон бол дорвитой алхмууд хийх шаардлагатай байна. Энэ дээр багш нарын бодит орлогыг, цалинг нэмье гэхээр цалин нэмэх боломжгүй гэдэг. Тэгвэл бодит орлогыг ямар нэмэх гарц гаргалгаануудыг бодлого бодож байна вэ? Боловсролын яаман дээр нэлээн саналууд гарсан. Энийг нэгтгээд хүргүүлэх болно.

Д.Амарбаясгалан: Гантөмөр сайд хариулт өгье. Хэн хариулт өгөх вэ? Эдийн засаг, хөгжлийн яам Энх-Амгалан 4 дүгээр индэр.

Л.Энх-Амгалан: Өмнө нь, гишүүний асуултад хариулъя. Эдийн засаг, хөгжлийн яам Энх-Амгалан. Өмнө нь өнгөрсөн намар батлагдсан төсвийн хүрээний мэдэгдэл дээрээс эдийн засгийн өсөлтийг бууруулсан байгаа. Өмнө нь 26 оны эдийн засгийн өсөлтийг 6,5 гэж байсан бол 6 болгож бууруулсан. Инфляцыг мөн нэмэгдүүлсэн байгаа. Энэний цаад шалтгаан нь яг энэ гадаад зах зээл дээр бий болсон тодорхой бус байдалтай холбоотой. Энэнтэй холбоотой нүүрсний үнэ унасан, манай экспортын орлого багассантай холбоотой эрсдэлүүдийг илүү тусгаж өгсөн байгаа гэж тэгж ойлгож болно.

Халамжийг бууруулахтай холбоотой бодит тоонууд юу байна гэж асуулаа. Халамж дээр 24 онд нийт халамж нь өөрөө ДНБ-ийхээ 3 орчим хувьтай тэнцүү байсан юм. Энийг 24 онд 2 аравны, 26 онд 2,5 хувь, 27 онд нийт эдийн засгийн ДНБ-ий 2,4 хувьтай тэнцэхээр, 28 онд 2,2 хувьтай тэнцэхээр хэмжээтэй болгож бууруулна гэсэн ийм тоонуудыг төсвийн хүрээний мэдэгдэлд тусгасан байгаа.

Д.Амарбаясгалан: Болсон уу Галбадрах гишүүн? Тодруулъя, Галбадрах гишүүн тодруулж асууя.

Ж.Галбадрах: Тэр гадаадын экспортын төслүүдийн талаар танилцуулга юу байна вэ? Мөн боловсролын жилд бодлогын, багш нарын багшлах боловсон хүчнийг нэмэгдүүлэх талаар ямар бодлого, юу оруулсан бэ гэдгийг 1 дүгээрт асууя. Бид Боловсролын яаман дээр ажлын хэсэг ажиллаад, тэндээс нэлээн саналуудыг багш, өөрөөр хэлбэл нөөц багш нарыг татаж оролцуулж ирэх, шилдэг төгсөгчдийг багш болгох талаар нэлээн саналууд гаргаж байгаа. Энэ саналуудыг тусгасан тийм тусгаад Сангийн яам, цааш нь Эдийн засаг, хөгжлийн яаманд оруулах ийм саналууд байгаа. Энийг хүлээж авах тал дээр санал оруулна.

Д.Амарбаясгалан: Энх-Амгалан 4 дүгээр индрээс гүйцэд хариулъя.

Л.Энх-Амгалан: Экспортыг нэмэгдүүлэх төслүүд гэдэгт дөнгөж сая зурагдсан нөгөө хил холболтын төмөр замын төсөл. Энэ хүрээнд бүтээн байгуулалтын ажил нь 2 жилийн хугацаанд хийгдэнэ. Бүтээн байгуулалтаа хийгдэж байх явцад жил болгон 5 сая тонн нүүрсийг экспортод нэмэлтээр гаргах тийм гэрээ хэлцэл хийгдсэн байгаа. Дээр нь нэмээд энэ хил холболт хийгдсэний дараа Шивээхүрэн-Ханги хил холболтыг хийх нөхцөл бүрдсэн. Тэгэхээр энэ нь экспортыг нэмэгдүүлэх гол төслүүд болж байгаа. Ураны төслийн хувьд одоо

бүтээн байгуулалт нь хийж байгаа, 28 оноос анхны бүтээгдэхүүнээ экспортод гаргаж эхэлнэ. Тэгээд газрын тосны төсөл үргэлжлээд явна. Ийм төслүүд гол нь экспортыг нэмэгдүүлэх дээр байна.

Энэ боловсролтой холбоотой асуудал энэ төсвийн хүрээний мэдэгдэлтэй яг зэрэгцээд 26 онд улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө гэдэг баримт бичиг өргөн баригдсан. Өчигдөр хэлэлцэгдсэн. Энэ жилийн төлөвлөгөө.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Батын Батбаатар гишүүн асуулт асууна.

Б.Батбаатар: Энэ зууван танхимд ард түмний төлөөлөл болоод ирээд суусан Их Хурлын гишүүд ямар ч асуудлыг авч хэлэлцэж, тодорхой шийдэл гаргаж, шийдвэр гаргаж, хууль тогтоох энэ эрх мэдлийг хэрэгжүүлэхээр тангараг өргөж суусан. Аль ч асуудлыг авч хэлэлцэхдээ бүгдээрээ нэгэн үзүүрт л хандах ёстой. 3,5 сая Монголчууд амьдралын чанартай, ирээдүйдээ итгэлтэй энэ улс орон, газар нутаг шороон дээрээ итгэл дүүрэн амьдрах эсэх тухай л асуудал. ЗГ байна уу, Их Хурал байна уу, аль ч шатны ямар ч байгууллага байна уу түүнд л зорих ёстой. Өөр бусад зүйлд биш. Тэгэхээр хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор гишүүдийн болоод зарим хүмүүс, дээрээс нь ер нь иргэд, олон нийт тэр чигээрээ хэлээд байгаа зүйл нь юу вэ гэхлээр амьдралын чанар болохгүй байна л гэж үзээд байгаа шүү дээ. Маш хүнд нөхцөлд амьдрахын тулд амьдарч байна л гэж байгаа.

ДНБ өсөөд, нэг хүнд ноогдох хувь хэмжээ өсөөд байна гэж байна, 8 мянга болгоно, одоо 6 мянга хэдэн зуу байна. 28 онд 10 мянган доллар хүргэнэ л гээд байна. Дэлхий нийтээр тойргийн эдийн засаг буюу хүртээмжтэй эдийн засгийн тухай яриад эхэлчихсэн. ДНБ нь өсөөд баян, ядуугийн ялгаа нь хэт холдож тасраад, дундаж чинээлэг давхарга хоргодоод байгаа ийм нөхцөл байдал үүсэж байна гэдэг утгаар ярьж байгаа. Тэгэхээр хүртээмжтэй эдийн засаг буюу энэ төсөв гэдэг чинь иргэдэд, нэг хүнд ноогдох тэр хүртээмж нь иргэдийн амьдралд 3 сая, 4 сая болох гэж байгаа энэ ард түмний амьдралд хүртээмжтэй байх нь яаж нөлөөлж байгаа юм бэ?

Улсын Их Хурал бий болсон цагаасаа хойш олон л тогтоол, үүрэг даалгавар, хууль тогтоомж, чиглэл Засгийн газарт өгсөн. Хэрэгжиж байгаа нь хэд юм, хэрэгжээгүй нь хэд юм гэдгийг дөнгөж саяхан бүгдээрээ хэлэлцээд л байсан. Маш бага хувьтай. Дээрээс нь төсөв маань өөрөө 9 жилийн өмнө Ардын нам дангаар засаглах тэр эрхийг иргэд, сонгогчдоос олж аваад, 4 төсөвтэй болчихсон байна, энийг 1 болгоно гээд явж байна. Одоо болохоор орлого нь 1, зарлага талдаа төсөв чинь 2 салаад, тэр төсөв дотроо бичигддэг, бичигддэггүй ийм байдал руу орчихлоо гэдэг шүүмжлэлүүд гараад байна. Энэ тохиолдолд бид нөгөө төсвийг хянах, удирдах тухай ойлголт, хуульчлах тухай ойлголт их өөр зөрөөтэй болно. Улсын Их Хурал өөрөө энэ төсөв мөнгөний бодлого, мөнгөний бодлого, энэ гүйцэтгэл 1,7 тэрбум долларын зээл яагаад төсөв дээр бичигдэхгүй байгаа юм, бусад нь яагаад бичигдэхгүй байгаа юм энэ эд нар дээрээ нэг хууль зүйн дүгнэлтүүд гаргах чиглэл рүү ажиллаад, хяналт шалгалтын үүргээ биелүүлэх ёстой юм байна. Өрийн удирдлагын тухайд Маркс хэдэн зуун жилийн өмнө хэлсэн байдаг. Хүн төрөлхтний түүх бол ангийн тэмцлийн түүх биш, өрийг үгүй болгох тухай, өртэй хийж өртэй хийж байгаа түүх юм гэж. Тэгэхээр манай өрийн удирдлага 2009 онд 3 тэрбум доллар байсан өнөөдөр 37 тэрбум.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гантөмөр сайд хариулт өгье.

Л.Гантөмөр: Тийм. Ер нь эдийн засаг өсөхөө өсгөж, тодорхой түвшинд хүргэхгүй бол энэ баялгийн хараалаас бид гарахгүй юм байна лээ. Тийм учраас тэр 10 мянган долларын зорилтынхоо ард хэдүүлээ зоригтой гарна, гарах хэрэгтэй. Ингэж байж нэг зураг харагдана. 10 мянган долларт хүрээд эхлэхээр ерөнхийдөө бүтээмж их өндөр болдог, нэмүү өртөг шингэж эхэлдэг. Нэмүү өртөг шингээд эхлэхээрээ ажлын байр дээр байгаа хүний орлого нэмэгддэг. Ер нь эдийн засгийн хүртээмжийг хэдүүлээ нэг зүйл дээр л ойлгох хэрэгтэй. Ажил хийж байгаа хүн, ажил эрхэлж байгаа хүн тэр хүртээмжийг хүртэнэ. Ажил хийхгүй зүгээр байгаа хүмүүст эдийн засгийн хүртээмж гэдэг ойлголт угаасаа байхгүй. Тийм учраас энэ хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх бодлого нь өөрөө боловсролтой холбоотой Галбадрах гишүүн хэлсэнтэй би санал нэг байна.

Батбаатар даргын хэлж байгаа энэ ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх хүний нөөцийн бодлогын шинэчлэлээ явуулах гэдэгтэй санал нэг байна. Ингэж байж бид хүртээмжийг, хүртээмжийг одоо хэдүүлээ нэг ийм буруу яриад байгаа нь зүгээр байгаа хүн болгонд ингээд нэг мөнгө хуваагдаж очих юм шигээр төсөөлж байгаа төсөөлөл нийгэмд, олон нийтээс харагдаад байна. Үгүй. Ажил хийж байгаа хүмүүс хамгийн их шимийг хүртэх ёстой. Гол нь тэр улсуудын цалин нь амьдралд нь хүрдэг байх, орлого нь нэмэгдэх гэдэг тал дээр бодлого гаргахад үнэлгээ, нэмүү өртөг, үнэлэмж сайжрах. Үнэлэмж сайжрахын тулд боловсрол, нарийн мэргэшил, мэргэжил нь мэргэшил, тэгээд өндөр технологи. Ийм л уялдаа холбоотой явах юм гэдгийг хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Батбаатар гишүүн тодруулж асууя.

Б.Батбаатар: Хүртээмжийг, эдийн засгийн хүртээмжийг иргэд нь ажил хөдөлмөр эрхлэх, тэр хөдөлмөр эрхэлж байгаагийнхаа хүчинд тэр эдийн засгаас өөрийнхөө санхүүгийн эрх чөлөөгөө олж авч чаддаг байх энэ байр суурь бол зүй ёсны байр суурь. Түүнээс биш ажил хийхгүй байгаа хүмүүст тараагаад цацаад хуваагаад өгчих гэдэг асуудал огт яриагүй. Ийм адилхан байр суурьтай байгаад талархаж байна. Тэгэхдээ өнөөдөр татвар төлөгчдийн мөнгө ЗГ байдаг юм уу, улс орны нэр байдаг юм уу, Чингис хааныхаа нэрийг бариад л босгож ирж байгаа энэ бонд, үнэт цаас энэ зүйлээр хийж байгаа хөрөнгө оруулалтыг яагаад өөр улсын компаниудад өгөөд байдаг юм бэ? Энийг олон л хүн ярьж байгаа шүү дээ. Энэ дээрээ нэг тогтоол шийдвэр гаргах цаг нь болоогүй юм уу? ЗГ нь гаргадаг юм уу, Их Хурал нь гаргадаг юм уу? Засаг асуудлаа барьж авах нь.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Отгоны Саранчулуун гишүүн асуулт асууя.

О.Саранчулуун: Би нэг юм хэлэх гэсэн юм. Эрүүл байна гэдэг нь бие, сэтгэл санаа, нийгэм орчны хувьд сайн сайхан байдлыг хэлнэ гээд ДЭМБ-ын тодорхойлолтыг бид бүгдээрээ мэдэж байгаа. Тэгээд би ингээд 2 дахь удаагаа энэ төсвийн хүрээний мэдэгдлийн материалуудыг ингээд харахлаар Эрүүл Монгол хүн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ гээд 2.2 дээр заасан байгаа. Тэгэхдээ энэ доторх тусгасан 6 заалт нь дандаа өвдчихсөн байгаа насанд хүрсэн хүмүүсийн эмнэлэг, хавдар, зүрх судлалын өвчлөлийн эмчилгээний технологи гээд ийшээ чиглэхээд байгаа. Эрүүл Монгол хүн чинь эрүүл хүүхдүүдээсээ эхлэх юм байгаа юм. Тэгээд боловсролын байгууллагын хувьд боловсролын талаасаа боловсролд нь анхаарна гээд, эрүүл мэндийн байгууллагын эрүүл мэндийн зорилтыг нь харахаар дандаа эмнэлэг буюу эмчилгээнд суурилсан зорилтуудаа оруулаад, дунд нь

хүүхдүүдээ орхичхоод байгаа. Эрүүл Монгол хүнийг хөгжүүлнэ гэдэг чинь эрүүл хүүхдээс эхэлнэ шүү дээ. Тэгэхээр энэ дээр би нэг ийм зарчмын хувьд энийг сайжруулж, өөрчилж хүүхэд рүү чиглэсэн энэ салбар дундын асуудлыг анхаармаар байна. Хүүхдийн эрүүл мэнд, хүүхдийн сэтгэл санаа, хүүхдийн орчин. Энэ дотор хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд ч гэсэн орно. Өнөөдөр яах вэ энд ингээд сайд нар нь өөрсдөө миний асуултад хариулахаар байхгүй байх шиг байна. Би тусад нь тайлбар авмаар байна.

2 дугаар асуулт нь Төсвийн хүрээний мэдэгдэл дээр 2026, 27, 28 оных харахлаар Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс хуваарилах зардлын дээд хэмжээг өсөхөөр харагдаж байна 2.6, 7, 9 гээд, өсөж байгаа юм байна. Гэхдээ 2 дээр нь болохлоор төсвийн сахилга батыг сайжруулна, төсвийн төрөөс үзүүлж буй нийгмийн халамж, тусламж үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлнэ гээд тусгасан байгаа сахилга бат гэдэг дээр. Тэгэхээр энэ зорилтот бүлэгт чиглүүлж байгаа энэ нь яг зөв байгаа юм уу, энэ хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа энэ бодлого, хөтөлбөр чинь эргээд хэр оновчтой вэ гэдгийг үнэлдэг энэ тогтолцоо нь энэ төсвийн хүрээний энэ материал дотор би энийгээ яаж үнэлэх юм бэ гэдэг зүйл олж харсангүй. Энийг нь хаанаас харах вэ гэдгийг мэдмээр байна.

Яагаад ингэж асуугаад байгаа гэхлээр өнгөрсөн удаа бараг жил, 2 жилийн өмнө хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст анхаараад өгөөч, энэ хүмүүст холбоотой зардлыг төсөв дээр ингээд тусад нь нэг багана үүсгээд оруулаад өгөөч гэдэг бичгийг би Сангийн сайд, бүх л хүмүүс рүү явуулсан даа. Тэгээд яагаад гэхлээр тодорхойгүй болохоор чинь хүмүүс уурлаад байгаа байхгүй юу даа. Тодорхойгүй болохоор хүмүүс өнөөдөр жагсаж байна шүү дээ мэдэхгүй байгаа болохоор. Нэг зүйл тодорхойгүй байхад л хүмүүс ямар их дургүйцэж, бухимдаж байна. Тэгвэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өдөр болгон тийм мэдрэмжтэй байдаг байхгүй юу. Бид нартай холбоотой зардал яасан юм бол гэдгийг нь мэдэхгүй байгаа болохлоор л асуугаад байгаа юм. Тэгэхээр эхний ээлжид энийгээ энэ төсвийн энэ зардал яам болгонд төсвөө өгдөг баганад нь тусгаад өгөөч гэхээр бид хүний хөгжлийн хэсэгт нь оруулчихсан байгаад байгаа. Энэ дээр би тусгайлан асуумаар байна. Тусгайлан хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахтай холбоотой төсвөө яаж гаргаж байгаа вэ, яаж тодорхойлж байгаа вэ? Яагаад гэвэл 3 жилийн дараа Монгол Улс энүүгээр олон улсын тайланд мэдээллээ өгнө. Хөгжлийн төлөө зорилт төслийнхөө 15 хувийг хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй холбоотой зардалд тусгана гээд нэгдчихсэн шүү дээ тэр тунхаглал энэ тэрд. Тэрийгээ ярих ёстой.

Хамгийн сүүлд нь энэ иргэдээс дахин, дахин асууж байгаа нэг асуултыг асууя. Энэ асаргааны мөнгө нь хэзээ орох юм бэ? Энэ яагаад ингээд удаад байдаг юм бэ? Хамгийн хэцүү байгаа бүлэгт өгөх энэ төрийн үйлчилгээнийхээ мэдээллийг нэг ойлгомжтой тэдэнд өгнө, эдэнд өгнө гээд мэдээллээ ил тод байлгаж болдоггүй юм уу? Энэ дээр нэг энэ холбогдох хүмүүс нь ирчихсэн байгаа дээр хариу авмаар байна.

Д.Амарбаясгалан: Гантөмөр сайд хариулт өгье.

Л.Гантөмөр: Саранчулуун гишүүний хөндөж байгаа асуудлыг ирэх долоо хоногт хэдүүлээ хөгжлийн төлөвлөгөөгөө ярина. Тэр үеэр Нийгмийн бодлогын байнгын хороон дээр Нийгмийн хамгааллын сайдтайгаа ярилцаад, асуудлуудаа зөв томьёолоод оруулаасай гэж бодож байна. Бид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг

дэмжих бодлого маш тууштай хэрэгжүүлэх үүрэгтэй. Яг энэ халамжийн асуудал дотор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс яг гол нөгөө очих ёстой хүмүүстээ мөнгө нь очих тал дээр шинэчлэлийг Энх-Амгалан сайд өөрөө хийж байгаа гэж бидэнд тайлагнаж байгаа. Удахгүй яг энэний төлөвлөлтийг гаргаж өгнө гэдгийг хэлье.

Өнөөдөр бид төсвийн хүрээгээ ярьж байгаа учраас бүх сайд суугаад, ингэж задалж ярьдаг боломж байхгүй. Ерөнхий энэ тоонууд, ерөнхий прогноз дээрээ бид ярилцаж байгаа шүү гишүүнээ. Яг тодорхой асуултыг нь хэрвээ Нийгмийн хамгааллын яамнаас хүн байвал, хүн байна уу? Нийгмийн хамгааллын яамнаас хүн байвал яг тэр саяын мөнгө төгрөгтэй холбоотой асуудлыг нь, эсхүл Сангийн яам мэдэж байгаа юу тэрийг нь? Сүүлд Саранчулуун гишүүний хөнддөг юуны зардал гэххэв? Асаргааны зардал дээр ямар нэгэн тийм коммент байна уу та бүхэнд.

Д.Амарбаясгалан: Тодруулж асууя Саранчулуун гишүүн.

О.Саранчулуун: Одоо ийм л байдалтай байна шүү дээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудал гэхээр та нар зөвхөн Гэр бүл, нийгмийн хамгааллын яамны асуудал гэж харахаа эхлээд болимоор байна. Төсвийн ерөнхийлөн захирагчдын 39 захирагч гэсэн ийм байгууллагуудын 23 нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудалтай холбоотой шүү дээ. Энэ чинь салбар дундын асуудал шүү дээ. Тэгэхээр энэ 23 байгууллага бүрээс л тодорхой мэдээлэл авмаар байгаа байхгүй юу. Тэгвэл энэ чинь хүмүүст ойлгомжтой болох байхгүй юу. Ийм юм хийж байгаа юм байна гээд. Бид өнөөдөр Барилгын сайдаас ирсэн 379 хуудас материалыг үзэж байна. Тийм их зүйл байсан юм бол тэрийгээ тусад нь гаргаад тавьчих л даа. Ийм л юм хүсээд байгаа байхгүй юу. Тэгэхээр би бүгд энэ асуудлаараа, энэ 3 асуудлаараа заавал мэдээлэл өгөх үүрэгтэй. Өчнөөн олон хүмүүс энэ хариултыг хүлээж байгаа. Ялангуяа асаргааны мөнгөний мэдээллийг албан ёсоор хүмүүст нь хүргэх. Хамгийн их мэдээлэлгүй, ингээд хамгийн их бухимдал төрүүлээд байгаа чинь энэ байхгүй юу. Нүд, чихгүйгээсээ болж стресстэж байна шүү дээ хүмүүс.

Д.Амарбаясгалан: Ер нь энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг энэ ганц яам ч биш, ерөөсөө төрийн бүх шатны байгууллагууд анхаарч үзэж, үйл ажиллагаандаа тусгадаг байх ёстой. Ганц Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны эрхлэх асуудлын хүрээнд байдаг мэтээр ойлгоод, тэгээд орхигдуулаад явдаг ийм төрийн бодлого гэж ерөөсөө байж болохгүй. Тийм учраас Саранчулуун гишүүний хэлж байгаа энэ санал дээр Их Хурлын зүгээс анхаарал тавьж ажиллана. Ирэх долоо хоногт анхны хэлэлцүүлэг болох процесс дунд, цаашлаад шийдвэр гаргах нөхцөл дээр энэ Саранчулуун гишүүний хэлээд байгаа санал, шаардлагыг хангаж ажиллаарай гэдгийг Байнгын хороодын удирдлагууд, төсөл өргөн барьсан Засгийн газрын нөхдөд анхааруулаад хэлчихье.

Улаанбаатар хотод 13 цаг болсон тул Улсын Их Хурлын үдээс өмнөх чуулган завсарлалаа. 15 цагаас үдээс хойших чуулган эхэлнэ. Даргын зөвлөлийн хурал чуулганы завсарлагааны хугацаанд болно.

13.00 цаг

2025 оны 05 дугаар сарын 16, Баасан гараг,
Төрийн ордон “Их хуралдай” танхим

13 цаг 10 минут.

ҮДЭЭС ХОЙШИХ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа 13 цаг 10 минутаас хуралдааныг даргалав.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы 5 дугаар сарын 16-ны өдрийн үдээс хойших нэгдсэн хуралдаан эхэллээ. Үдээс өмнө хэлэлцэж байсан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-гоос 28 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын өрийн удирдлагын 2026-аас 28 оны Стратегийн баримт бичиг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үргэлжлүүлэн хэлэлцье. Дараагийн асуулт асуух гишүүн Чулуунбилэгийн Лодойсамбуу.

Ч.Лодойсамбуу: Гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Энэ хуралд өглөөнөөс хойш суусан, тэгээд асуултууд нэлээн давхцаж байна. Тэгээд үндсэндээ товчхон нэг санал үг хэлэх гэсэн юм. Өнөөдөр 2026-аас 2028 оны төсвийн төсөөлөл, төсвийн хүрээний мэдэгдлээ бид хэлэлцэж байгаа. Тэгээд энд ирэх оны 26 оны төсөв нийт зардлын хэмжээг өсгөхгүй, хэмжээндээ барих, нийт зардлыг ДНБ-ий хувь хэмжээг, эзлэх хувь хэмжээг нь бууруулах гэх мэт ийм сайшаалтай зүйлүүд орж ирсэн байна. Тэгээд түрүүн үдээс өмнөх хуралдаан дээр гишүүдийн хэлсэн нөгөө гадаад зээлийг үр ашигтайгаар ашиглах тухай 40 орчим гишүүдийн гарын үсэг зурсан энэ хуулийн төсөл өргөн барихаар бэлдчихсэн байгаа талаар зарим гишүүд саналуудаа хэлсэн. Тэгээд энэ дээр Гантөмөр сайд түрүүн энийгээ тэр орж ирвэл Байнгын хороон дээр хэлэлцэнэ биз дээ гэдгийг дэмжиж байна. Тэгээд энэ дээр нэг тодорхой зүгээр Сангийн сайд энэ тэр сууж байгаа учраас нэг саналуудаа хэлэх гэсэн юм.

Ер нь тэр саналыг дэмжихгүй байгаа. Тэр төсвөөс гадуур дахиад Их Хурлаараа бид нэг сав гаргаж ирчхээд тэрийгээ алдагдалгүй төсөв гэж тэр саваа таглачхаад, дахиад ЗГ нь дэргэдээ хажуудаа өөр нэг сав дүүргээд ингээд явж бид ерөөсөө болохгүй. Энэ цаашлаад явбал төсвийн асуудал сүүлдээ Үндсэн хуулийн асуудал ч болчих ийм эрсдэлтэй ийм зүйл байгаад байгаа юм. Тэгээд гол асуудал нь мэдээжийн хэрэг энэ гадаад зээлээ нэгэнт авсан зээлээ ашиглаад эхлүүлсэн төслөө дуусгах хэрэгтэй. Энэ бол зөв. Энэний санаа нь зөв. Гэтэл бид нарын яг анхаарах ёстой гол асуудал нь юу юм бэ гэхээр энэ төр өөрөө заавал гардаж хийх шаардлагагүй төслүүдийг өөрийнхөө нуруун дээр овоолчихоод, тэгээд бид мөнгө хэрэгтэй байна, мөнгө хүрэхгүй байна гээд явдгийг л болимоор байгаа юм.

Жишээлбэл манай 14 мега төсөл дотор орон сууцын хороолол хүртэл байж байгаа шүү дээ. Хотын дэргэд жишээлбэл барилгын компани байгуулчхаад хотын орлогчийг захирлаар нь томилчихоод л сууж байгаа шүү дээ. Ингээд төр өөрөө хувийн хэвшилтэйгээ зэрэгцээд хийх шаардлагагүй, төр үндсэндээ юу хийх хэрэгтэй вэ гэхээр нийгмийн шинж чанартай дэд бүтцийн голдуу төслүүдээ л барьж аваад, бусдад нь боломжийг нь олгоод ингээд явдаг л уг нь онолтой номтой юм байна лээ. Тэгээд манайх болохоор бид бүгдийг нь хийнэ гээд ингээд явдаг. Энэ дээрээ л гарц гаргалгаа асуудлаа шийдэж явмаар юм байна лээ. Тийм учраас энэ Сангийн сайд, тэгээд дараа дараагийн Сангийн сайд, Ерөнхий сайд нар нь ч гэсэн сонсож байгаа байлгүй. Тэгээд ирэх намар энэ төсөв оруулж ирэхдээ дараа дараагийнх нь танхимынх нь энэ өөрчлөлтүүдээ хийгээд орж ирэх байлгүй дээ

гэсэн нэг ийм саналтай л байна. Хамгийн гол нь бид энэ нэг тодорхой дүрэм журам, тодорхой энэ нэг газрын зургаа зөв харахгүй бол хажуугаар нь энэ алсын хараагаа харангаа хажуугаар нь ойрын хараагаа сайжруулаад, гарсан энэ алдаануудаа дор дор нь засаад явахгүй бол цаг хугацаа их богинохон байна гэж санал хэлье.

Х.Булгантуяа: Лодойсамбуу гишүүн санал хэллээ. Нямтайширын Номтойбаяр гишүүн.

Н.Номтойбаяр: Надад нэг асуулт байгаа. Энэ оны эхэнд ЗГ-ын тэргүүн Оюун-Эрдэнэ Ерөнхий сайд 26 оны 1 сарын 1-нээс өмнө татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ буурна гэж албан ёсоор мэдэгдсэн. Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлийн хурал дээр ч гэсэн танилцуулгаа хийсэн. Тэгээд энэ өөрчлөлт шинэчлэлтийг хийх татвар бууруулах, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг бууруулах хууль, эрх зүйн орчин маань Их Хуралд өргөн баригдаагүй байхад 26 оны төсвийн төсөөллийг одоо хэлэлцэж, 6 сарын 1-ний дотор Дэгийн хуульд зааснаараа баталснаар 26 оны 1 сарын 1-нээс эхлээд татвар буурах, нийгмийн даатгалын шимтгэл буурах боломжгүй болчихоод байгаа юм.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7.1 дээр маш тодорхой заачихсан байгаад байгаа юм. Тэгэхээр ЗГ энэ дээр ямар байр суурьтай байна вэ? 26 оны 1 сарын 1-нээс татвар буурах уу, нийгмийн даатгалын шимтгэл буурах уу? Нийгмийн даатгалын хууль дээр салбарт нь ажиллаж байсан хэд хэдэн гишүүд нэг албан бусаар нэг ажлын хэсэг жишгээр уулзаж нэлээн шинэчилсэн найруулгын хэмжээнд өөрчлөлт оруулах асуудлыг яриад явж байгаа. Тэгээд татвар маань яах вэ маш том хүлээлт байгаад байгаа. Тэгээд Төсвийн хүрээний мэдэгдэл Татварын хууль баригдаагүй байхад батлагдсанаараа 26 оны 1 сарын 1-нээс хэрэгжиж эхлэх ямар ч боломжгүй болчихоод байгаа юм. Хуулийг нь харахаар. Тэгэхээр ямар гаргалгаа харж байгаа юм бэ? Төсвөө өргөн барихдаа энэ төсвийн хүрээний Их Хурлаас батлах мэдэгдлээ өөрчлөлт оруулах гээд байгаа юм уу? Энэ дээр нэг тодорхой байр сууриа илэрхийлээч.

Х.Булгантуяа: Жавхлан сайд та хариулсан нь дээр байх. Татварын реформтой холбоотой, шаардлагатай Гантөмөр сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Номтойбаяр гишүүний асуултад хариулъя. Зарчмын хувьд логиктой асуудал л даа. Татварын реформ маань өөрөө нэлээн өртөгтэй хийгдэнэ. Тийм амар нэг удаагийн төсвөөр хийгдэх зүйл биш. Яагаад вэ гэхээр бид ер нь татварын багц хууль гэхээр энэ чинь өөрөө дор хаяж 4 том хууль дээр суурь өөрчлөлтүүд орно. Мэдээж шууд ажиллаж эхлэх төсвийнхөө жилд орлого талд нэлээн нөлөө үзүүлнэ. Тэгэхдээ ямар ч байсан 26, 27, 28, 29 гээд, 30 он хүртэл ч магадгүй энд реформууд ингээд шат дараатай хийгдээд явах юм байгаа юм. Тийм учраас бид 26 оны төсвийн хүрээний мэдэгдлийг хамгийн байж болох бага орлогын түвшинд өргөн барьсан байгаа. Бага орлогын түвшинд. Энэ нь юугаар харагдаж байна вэ гэхээр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ирүүлсэн санал төсвийн тэр ирүүлсэн орлогын саналаас бага байгаа, зардал нь ч бага байгаа. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ирүүлсэн санал бол төсвийг бүр алдагдалтай ирүүлсэн байгаа тоо нь. Тийм учраас ямар ч байсан орлогыг бид байж болох хамгийн багаар ингээд төлөвлөөд, ирэх жилийн эдийн засгийн тэлэлт, ялангуяа нүүрсний болон бусад манай гол экспортын түүхий эдүүдийн бид үнэ ямар байхыг одоо хэлж мэдэхгүй. Гэхдээ ямар ч байсан биет хэмжээгээр энэ жилийнхээсээ буурахгүй байхаар ингэж төлөвлөж оруулж ирсэн байгаа.

Тийм учраас аль болох дахиж төсвийн хүрээн дээр тодотгол хийхгүйгээр, өөрчлөлт оруулахгүйгээр, тэгээд ч хууль дээрээ нэлээн том түгжээтэй болчихсон шүү дээ. Бид чинь 3 сар үүнээс хойш ямар ч өөрчлөлт оруулж болохгүй. Тэгэхээр 6 сарын 1-нээс хойш бид бараг өөрчлөлтгүйгээр ингээд, өөрчлөх боломж ч байхгүй цаг хугацааны хувьд ингэж өргөн барина. Тэгэхээр ямар ч байсан нийт багц реформ 4 их наяд орчим ийм өртөгтэй байгаа. 3 жилдээ, 4 жилдээ ингээд бид тараагаад тавивал нэг жилдээ нэг их наяд орчим ийм төсвийн орлогын ачаалал авах хэмжээний ийм өөрчлөлтүүдийг хийгээд явах юм байгаа юм. Тэгэхээр ямар ч байсан одоо өргөн барьсан хүрээндээ багтаагаад шинэчлэлээ эхэлнэ гэсэн ийм төлөвлөгөөтэй байгаа даа.

Х.Булгантуяа: Номтойбаяр гишүүн нэмж тодруулъя.

Н.Номтойбаяр: Тодорхой л асуулт шүү дээ. 26 оны 1 сарын 1-нээс эхэлж татвар, нийгмийн даатгалын буурах юм уу, буурах бол одоо боловсруулж байгаа хуулийн чинь төслийн хүрээнд яг хэдэн хувиар, яаж буурах юм бэ? Энийг л асуугаад байна шүү дээ, аягүй тайван асууж байгаа шүү.

Х.Булгантуяа: Аягүй тайван асуусан юм чинь аягүй тайван, сайхан хариулчхаарай. Жавхлан сайд.

Б.Жавхлан: Би их л тайван хариулаад байгаа юм. Хичээгээд л тайван хариулаад байна. Нийгмийн даатгалтай холбоотой эсэхийг нь сайд нь орж ирээд хариулчихвал уг нь зүгээр байгаа юм. Татвар дээр би мэдэж байгаа хэмжээндээ, төлөвлөж байгаа хэмжээнд маш тодорхой хэллээ. 1 их наяд орчим төсвийн орлого дээрээ ачаалал авах хэмжээний татварынхаа реформыг 26 онд эхлүүлнэ.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Буланы Бейсен, Бейсен гишүүн байхгүй байна. Асуулт асуух гишүүд дууссан тул нэрийг нь өгье үг хэлэх гишүүдийнхээ. Хэлэлцэх асуудалтай холбоотой үг хэлэх гишүүдийн нэрсийг түрүүлж авсан байгаа. Дэлгэц дээр өгсөн нэрснүүдийг гаргаадхаарай. Улсын Их Хурлын гишүүн Номтойбаяр. Үг хэлэхэд юуны микрофоноос, индрийн микрофон дээрээс үг хэлэхээр байгаа. 1 номерын индрийн микрофон дээрээс. Тийм энэ голын микрофон шүү. 1 номерын микрофон нь.

Н.Номтойбаяр: Мэдээж энэ 26 оны төсвийн төсөөллийг хуулийн дагуу дэмжиж таараа. Сангийн сайдын хэлснээр ирэх жил 1 их наяд төгрөгийн хэмнэлт бүхий түүнтэй дүйцэхүйц татварын хэмнэлт хийгдэнэ гэж ойлголоо. Тэгээд нийгмийн даатгал хариуцсан сайд нь одоогоор байхгүй байна. Тэгээд нийгмийн даатгалын шимтгэлийг бууруулах, ялангуяа ажил олгогчийн төлж байгаа нийгмийн даатгалын шимтгэл бууруулах саналыг Их Хурлын нэлээд олон гишүүд гаргаад байгаа юм. Тэгээд энэний тооцоолол өнөөдрийг хүртэл танилцуулагдаагүй.

Тэгээд сүүлд нэг зүйлийг хэлэхэд ЗГ энэ амлалтаа өгөхдөө ЗГ-ын зүгээс ард иргэддээ, аж ахуйн нэгж, компаниуддаа бэлэг барьж байгаа шүү гэж томьёолж хэлсэн. Тэгээд энийг нь эргээд бодоод байхаар нэг л тавласан үг санагдаад байх юм. Энэ бэлэг ердөөсөө биш, хамгийн том бэлэг бол бид энэ татвар төлөгчдийн мөнгөнд хэмнэлттэй, үр дүн эрэлхийлсэн, зөв оновчтой зарцуулах нь чухал. Дэндүү их тансаглал байгаа, төрийн алба дэндүү их томорч байгаа. Энэ бүгдийгээ танах л их чухал байгаад байгаа юм. Тэгээд Гантөмөр сайд тун ойрын хугацаанд

төрийн албыг 30 хувь багасгах ийм бодлого, шийдвэр барина гэсэн. Саяхан Засгийн газар төрийн албаны зарим чиг үүргийг хувьд шилжүүлснээр 10 их наядын хэмнэлт хийх юм байна гэдэг тооцоог гаргасан. Тэгээд энэ бүгдийгээ л хиймээр байгаа юм. Ингэж байж татвар буурна, ингэж байж нийгмийн даатгалын шимтгэл буурна. Тэгээд энийгээ л хийгээч гэж хүсээд байна. Тэгэхгүй бол ингээд ЗГ-ын зүгээс нэг тавлаад байгаа юм шиг нэг бэлэг барьж байна эд нар гээд. Тэгээд жинхэнэ бэлэг чинь утга агуулга нь их өөр шүү. Энэ татвар төлөгчдийн мөнгөнд хэмнэлттэй, үр дүн эрэлхийлсэн байгаасай л гэж хүсэж байна.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Жаргалсайхан, Жаргалсайхан гишүүн байхгүй байна. Жаргалсайхан гишүүн байхгүй байна. Ингээд асуулт асуух гишүүдийн урьдчилан өгсөн нэрс дуусчхаж байгаа. Нэрсээ өгсөн гишүүд Бүлгээсээ цөөхөн хүний цагт баригдаад нэрсээ өгчхөөд, чуулгандаа суугаад, үгээ хэлээд, асуултаа асуугаад хэлмээр байна. Намын бүлэг болон бүлэгт харьяалаагүй гишүүдээс урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу үг хэлж дууслаа. Байнгын хорооны саналаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-гоос 28 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын өрийн удирдлагын 2026-аас 28 оны стратегийн баримт бичиг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна. Таны, асуулттай та цаг дээр байсан, аль хэдийн асуулт дуусаад, сая үг хэлэх нь дуусаад, одоо дараагийн асуудал руугаа орох гэж байна. Дараагийн асуудалтай хамтатгаад санал хураалтыг явуулъя.

15.26 цаг

Гурав.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.05.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Дараагийн асуудал Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгад өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд, Засгийн газраас 2025 оны 5 сарын 9-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулах гэж байна. Хууль санаачилгын илтгэлийг ЗГ-ын гишүүн, Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга Равжихын Эрдэнэбүрэн танилцуулна.

Р.Эрдэнэбүрэн: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улс 1992 онд ардчилсан Үндсэн хуулийг батлан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгоны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно гэж заасны дагуу Монгол Улсын Их Хурлаас 1993 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг батлан хэрэгжүүлж ирсэн. Монгол Улсын Их Хурлаас 1919 оны, 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд уг хуулийн 57 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын, түүнчлэн тосгоны өөрийн удирдлага зохион байгуулалтын эрх зүйн үндсийг хуулиар тогтооно. Хот, тосгонд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарчим, чиг үүргийг шилжүүлэх асуудлыг ЗГ-ын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ гэж өөрчлөн найруулсан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 1 сарын 9-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт, хууль тогтоомжийг, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 02 дугаар тогтоолыг баталсан бөгөөд тогтоолын хавсралтад заасны дагуу улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, түүнчлэн хот, тосгоны эрх зүйн үндэс, тэдгээрийн өөрийн удирдлагын болон засаг захиргааны зохион байгуулалтын зарчмыг хуулиар тогтоож, хот, тосгоны өөрийн удирдлагыг оршин суугчид нь сонгож, хот, тосгоны удирдлага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын болон төсөв санхүүгийн зарим эрх мэдлийг шилжүүлэх, эдийн засгийн хувьд хот, тосгон харьцангуй бие даан хөгжих боломжийг бүрдүүлэх зохицуулалтыг тусган, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг шинэчлэн батлуулахыг ЗГ-т үүрэг болгосон.

Монгол Улсын Үндсэн хуулийн энэ үзэл баримтлалын хүрээнд Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Улсын Их Хурал 2024 оны 6 сарын 5-ны өдөр баталсан. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга нь 8 бүлэг, 54 зүйлтэй бөгөөд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгоны удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээрийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах нийтлэг журам, хотын зэрэглэл тогтоох шалгуур, хот, тосгоны удирдлагаас засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага болон аж ахуйн нэгж байгууллага, оршин суугчтай харилцан харилцах харилцааг зохицуулж, 2025 оны 6 сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөхөөр баталсан юм.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 6 сарын 5-ны өдөр Хот байгуулах тухай 72 дугаар тогтоолыг баталсан бөгөөд уг тогтоолоор Дархан, Эрдэнэт, Зуунмод, Хархорин, Багануур, Налайх гэсэн улсын зэрэглэлтэй 6 хот, орон нутгийн зэрэглэлтэй 43 хот, үүнээс 14 нь нийслэлд, дагуул, 4 хот, үүнээс 3 нь нийслэлд байхаар хотуудыг байгуулсан болно. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль болон Хот байгуулах тухай Улсын Их Хурлын 2024 оны 6 сарын 5-ны өдрийн 72 дугаар тогтоолд заасны дагуу дээр дурдсан 52 хотын Хархорумаас бусад эдэлбэр газрын хэмжээ, заагийг тогтоох асуудлаар Улсын Их Хурлын шийдвэрийн төсөл боловсруулж, өргөн мэдүүлэх, харьяалах засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өмч хөрөнгө, төсөв, байгууллагын бүтэц, орон тоог шилжүүлэх зэрэг ажлыг орон нутагтай зөвшилцөн зохион байгуулахад багагүй цаг хугацаа хэрэгтэй байгаа тул Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх хугацааг хойшлуулах шаардлагатай гэж үзлээ.

Тухайлбал нийслэл Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэг, 189 хороонд нийт 3341 төрийн албан хаагч ажиллаж байгаа бөгөөд 14 хот, 42 хорооллоор дамжуулан төрийн үйлчилгээг үзүүлэхэд урьдчилсан байдлаар 2380 төрийн албан хаагч ажиллах тооцоолол гараад байгаа юм. Өөрөөр хэлбэл, ажлын байрны давхардал, орон тооны цомхотгол, шинэ бүтэц, зохион байгуулалт гэх мэт олон асуудлыг шийдвэрлэхээр болж байгаа юм. Түүнчлэн Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд орсон зарчмын өөрчлөлт бол хот, тосгоны өөрийн удирдлагын байгууллага нь Хот, тосгоны зөвлөл байх зохицуулалт юм. Хот нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 69.1, 69.2-т заасны дагуу шилжүүлсэн чиг үүргийг хэрэгжүүлэх бөгөөд энэ хүрээнд 31 нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэхээр хуульд заасан. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн дагаж мөрдөх журмын тухай хуульд аймаг, нийслэл,

сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч, тэдгээрээс нэр дэвшүүлж томилогдсон Засаг дарга нь 2026 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн Хотын зөвлөл, захирагч хуулийн дагуу сонгогдох хүртэл харьяалах Хотын зөвлөл Захирагчийн хуулиар хүлээсэн үүрэг, чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасан хэдий ч уг зохицуулалтыг хэрэгжүүлэхэд тодорхой бэлтгэл хангах шаардлагатай байна гэж үзлээ.

Иймд Улсын Их Хурлаас 2024 оны 6 сарын 5-ны өдөр баталж, 2025 оны 6 сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон үүнтэй холбогдуулан Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хот байгуулах тухай Улсын Их Хурлын 24 оны 72 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай тогтоолын төслийг тус тус боловсрууллаа. Хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Х.Булгантуяа: Төслүүдийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Сархадын Зулпхар танилцуулна.

С.Зулпхар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас 2025 оны 5 дугаар сарын 9-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг ТББХ 2025 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ. Хууль санаачлагч Улсын Их Хурлаас 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдөр баталсан Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль, Хот байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоол болон хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд туссан зохицуулалтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахад тодорхой хугацаа шаардлагатай гэж үзэн хууль, тогтоолыг дагаж мөрдөх хугацааг хойшлуулахаар уг төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар улсын төсвөөс нэмэлт зардал шаардагдахгүй гэж хууль санаачлагчид үзсэн бөгөөд хуулийн төслийг dparliament.mn цахим системд байршуулж, иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно. Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын даргын 2024 оны 77 дугаар захирамжаар байгуулагдсан Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах, шаардлагатай хууль тогтоомжийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Д.Батлут Байнгын хорооны хуралдаанд танилцуулсан.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд ЗГ-аас авч хэрэгжүүлсэн ажил, Үндсэн хууль болон хууль хоорондын зөрчил байгаа эсэх, дагаж мөрдөх хугацааг нэг жилээр хойшлуулснаар хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажил бүрэн хангагдах эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Батбаатар хуулийн дагаж мөрдөх хугацааг хойшлуулах болсон үндэслэл, шалтгааны талаар, Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижир Төслийн үзэл баримтлалын талаар, хуулийг хэрэгжүүлэх хүрээнд ЗГ, орон нутаг хоорондын ажлын уялдаа холбоо, эдэлбэр газрын хэмжээ, зааг, эргэлтийн цэгийг тогтооход хүндрэлтэй асуудал байгаа эсэх талаар асуулт асууж, хариулт авсан байна.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж төвлөрлийг сааруулах хүрээнд бүсчилсэн байдлаар таталцлын хот, сумдыг байгуулж, хөгжүүлэх нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир хуулийг хэрэгжүүлэх боломжтой хилийн цэсийн маргаангүй дүүрэг, орон нутаг байгаа бөгөөд газар нутгийн маргаантай аймаг, орон нутгаас болж дагаж мөрдөх хугацааг хойшлуулах шаардлагагүй талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатар Улсын Их Хурлаас баталсан хуулийн хэрэгжилтийг хугацаанд нь хангахад анхаарах, хэрэгжүүлэх боломжгүй гэж үзсэн бол хуульд шаардлагатай өөрчлөлтийг оруулах талаар, Улсын Их Хурлын гишүүн Н.Номтойбаяр, Ж.Бат-Эрдэнэ нар хуулийн дагаж мөрдөх хугацааг хойшлуулж, хэрэгжилтийг хангахад бусад хууль тогтоомж, төсөв, эдийн засгийн болон хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдааг хангах нь зүйтэй зэрэг саналуудыг тус тус хэлсэн болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11 дэх хэсэгт Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төсөл, түүнтэй хамт өргөн мэдүүлсэн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар ил санал хураалт явуулсан, явуулна гэж заасны дагуу санал хураалт явагдахад Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгад өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Тогтоолд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Х.Булгантуяа: Ажлын хэсгийн гишүүдийн нэрийг танилцуулъя. Равжихын Эрдэнэбүрэн Монгол Улсын сайд, 20 минут хот Үндэсний хорооны дарга, Хишгээгийн Нямбаатар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Пүрэвийн Зоригтбаатар ЗГХЭГ-ын Бүс, орон нутгийн удирдлага, зохицуулалтын газрын дарга, Доржсүрэнхорлоогийн Саруул ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын дарга, Анандын Энхманлай Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга, Энхманлай байхгүй байна уу? Маамын Үнэнбат НЗДТГ-ын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга гэсэн ийм ажлын хэсгийн бүрэлдэхүүнтэй байна.

Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууж, хариулт авна. Улсын Их Хурлын гишүүн Бат-Өлзийн Бат-Эрдэнэ.

Б.Бат-Эрдэнэ: Энэ нэг эрх зүйн орчны өөрчлөлтөөр нэлээн зөв голдирол руу нь оруулах юмаа хэдүүлээ хийж амжихгүй бол. Би Нямбаатар даргын явуулж

байгаа бодлогуудыг дэмжиж байгаа. Яг өнөөдөр хот, суурин төвлөрсөн газрууд нь бараг бүх бохирдол, хог хаягдал, гарц шийдэлгүй болчихсон. Тэгээд нэг л их бүгдээрээ хил зааг, манай дүүргийн, манай аймгийн, манай сумын нутаг дэвсгэр гээд тэр нь чухал. Яаж сум, орон нутаг, нийслэл, дүүрэг нь хөгжих вэ гэдэг ийм хөгжилгүй болчихсон. Тэгээд ингээд хуулиараа нэг, нэг юмыгаа татаад унагаадаг зөрчилтэй болгочихсон ийм харилцаа. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль гээд батлагдаад ингээд явж байна өнгөрсөн жил билүү, батлагдсан билүү. Одоо бид энэ Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль болон бусад энэ хууль тогтоомжтой холбоотой асуудлуудаар энэ хийдэл зөрчил, давхардлын асуудлуудаа их сайн ялгаж хараад, яаж энэ хот, тосгонуудаа хөгжүүлэх вэ гэдэгтэй холбоотой асуудлуудаа л сайн шийдмээр юм шиг харагдаад байгаа юм.

Тэгэхгүй болохоор яах вэ би Байгаль орчин, аялал, жуулчлалын сайдаар ажиллаж байсан хүн. Байгаль орчных нь хуулиуд дээр суурьшмал газар буюу хот, тосгонтой холбоотой асуудлууд дээр нь хориглолтуудыг нь хийгээд өгчихсөн. Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөлтэй холбоотой асуудал дээр. Тэгэнгүүт өөр нэг хуулиар дахиад нэг юмыг нь нээгээд өгчихсөн, дараагийн хуулиар нь дараагийнхыг нь хаагаад өгчихсөн гэдэг ч юм уу ингээд хийдэл зөрчил, давхардалтай холбоотой асуудлууд нь яг ний нуугүй хэлэхэд маш өндөр байгаа. Тэгээд бид энэ хот, тосгонд, ялангуяа энэ суурьшмал газрын холбоотой асуудлууд дээр хүн амын дийлэнх хувь маань амьдраад байдаг, нөгөө Үндсэн хуулиар олгогдсон эрүүл, аюулгүй амьдрах орчин нь өөрөө зөрчигдөөд байдаг. Тэрийгээ шийдвэрлэе гэхээр нөгөө хууль тогтоомжууд нь саад болоод байдаг.

Ийм л хуулийн гацаа дотор бид өөрсдөө Үндсэн хууль, Үндсэн хууль, хүн амын эрүүл, аюулгүй байдал гэдэг зүйлийг л ярьсаар өнөөдрийг хүрч байгаа юм. Нэгэнт л хотод амьдарч байгаа бол, суурин газарт амьдарч байгаа бол бусдын эрхээ хүндэлдэг, тодорхой нийтийн эрх ашгийн төлөө нэг хүний эрх ашгийг хөндсөн шийдвэрүүдийг гаргаж явахаас өөр аргагүй байдалтай л байгаа. Тэгээд Хууль зүйн сайдаар ажиллаж байсан хүн, Улсын Их Хурлын гишүүнээр ажиллаж байсан хүн Нямбаатар дарга. Тэгээд энэ дээр тодорхой хэмжээний хууль, эрх зүйн үндэслэлтэй шийдвэрүүдийг гаргаад явж байгаа гэж найдаж байгаа. Тэгээд бид энэ ялангуяа Улсын Их Хурал дээр хэлэлцэгдэж байгаа энэ хууль тогтоомжийн хүрээнд бид энэ асуудал дээр онцгойлон анхаарч, боломжтой бүх чөлөөлөлтүүдийг нь хийж өгөх нь зөв болов уу гэдэг ийм байр суурьтай байгаа. Тэгээд асуух асуулт бол алга. Баярлалаа.

Х.Булгантуяа: Бат-Эрдэнэ гишүүн санал хэллээ. Пүрэвжавын Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Баярлалаа. Монгол Улс яах вэ зүгээр суурин газруудаа бид хэд нэршлээс нь эхлээд, тэрийг удирдаж байгаа хүмүүс ямар чиг үүрэгтэй, энийгээ дагасан төсөв санхүүгийн хуваарилалтаас эхлээд их л жоохон ойлгомжгүй явж ирж байгаа юм. Сая тэгээд 19 онд Монгол Улсын Үндсэн хуульд өөрчлөлт орсон байгаа. Энэ өөрчлөлтийн асуудлаар буюу Үндсэн хуулийн 57 дугаар зүйлийн 4 дэх хэсэг дээр хотод Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн зарим чиг үүргийг шилжүүлж болно гэдэг заалт орсон. Энэ нь ямар агуулгатай заалт байна вэ гэхээр бид хэд хуучин ерөөсөө энэ засаг захиргааны нэгжийг дандаа татан буулгаж байгаад, хот байгуулах гэдэг юм уу давхцалгүйгээр ярьдаг байсан бол одоо засаг захиргааны нэгж дээр нэгжүүдийг дамнуулан хот байгуулах эрх

зүйн үндсийг 19 оны Үндсэн хуулийн өөрчлөлт дээр өгсөн. Энэ ч гэсэн Монгол Улсад цаашдаа засаг захиргааны 330 сумуудыг хооронд нь нэгтгэх энэ уур амьсгалыг бүрдүүлэх хандлагын өөрчлөлтийг авчрах байсан.

2 дугаарт өнөөдөр Улаанбаатар хот гэдэг л ганцхан нийслэл хот нь хотын статустай, бусдууд нь бүгд сумын статустай байгаа. Маш ойлгомжгүй. Хилийн боомтуудын суурин газрууд нь бүгд ойлгомжгүй. Гэтэл өнөөдөр бидэнтэй хиллэж байгаа жишээ нь БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орны Эрээн хот шүү дээ. Тэгээд өнөөдөр Замын-Үүдтэй ингээд харилцъя гэхээр ямар ч статус нь ойлгомжгүй байгаа учраас хамтын ажиллагаа өрнүүлж болдоггүй ийм л зүйлүүд ингээд байгаад байгаа юм.

2 дугаарт энэ суурин газар дээр амьдралын чанар улам дордсоор л байна. Улаанбаатарын алдааг бусад аймгийн төвүүдийн сумууд давтах гээд байгаа байхгүй юу. Өнөөдөр энэ суурин газрууд дээр чинь нэг газрын даамал, газар зохион байгуулагч л ажиллаад байна. Уг нь тэнд чинь хот төлөвлөгч ажиллах ёстой, хот төлөвлөгч тэр хотын стандарт, хүний амьдралын чанарыг дээшлүүлэх тэр хотыг төлөвлөж, ногоон байгууламжтай, ажлын байртай, эдийн засаг таталцлыг бий болгох тэр төлөвлөлтүүдийг хийж байх ёстой юм. Энэ сургууль, цэцэрлэг нь хаанаа байх ёстой юм энийг ярьж байх ёстой байдаг. Тэгэхээр бид хэд ийм зүйлүүдээ ингээд мартаж ирээд, үндсэндээ Улаанбаатар луугаа бүгд тэмүүлдэг болсон, бусад газруудаа бид хөдөө гэж үздэг болсон. Уг нь тэнд чинь хот байхгүй юу, хүний суурин газар амьдрах гэж байгаа.

Тэгэхээр энэ Хот, тосгоны эрх зүйн байдлын хуулийн шинэчилсэн найруулгаар уг нь энэ хандлагыг л өөрчлөхийг зорьж тэмүүлсэн юм. Тэгээд Монгол Улсын Үндсэн хуульд энэ боломжийг нь олгосон гэж үзэж байгаа. Тэгээд яах вэ зүгээр харамсалтай нь нөгөө хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хаана хаанаа анхаарах зүйлүүд байгаа учраас хэрэгжих хугацааг түр хойшлуулъя гэж байгаа дээр зарчмын хувьд ойлгож, дэмжиж байгаа. Тэгээд энийгээ хийхдээ ЗГ-ын түвшиндээ маш ойлголцлуудыг яагаад, зөвхөн энэ Улаанбаатар хотын асуудал биш юм байгаа юм. Эрдэнэбүрэн сайд энийг, Хэрэг эрхлэх газрын дарга Учрал сайд энэ тэр анхаараасай л гэж бодож байгаа юм. Энэ орон нутаг буюу 21 аймгийн төвийн сумууд байгаа. Дээрээс нь баруун бүс дээр л гэхэд Булган сум байна, наашлаад Сэлэнгийн Мандал ч гэдэг юм уу ингээд маш олон ингээд суурин газрууд үүсчхээд байдаг энэ дээр ерөөсөө анхнаас нь тэр хот төлөвлөлтийг зөв хийж явахгүй бол ингээд үндсэндээ тэр хотод хүн өмчөө оруулаад байгаа байхгүй юу. Насан туршийн төлөх зээлээрээ авсан, авч тэр өмч бий болгоод байгаа юм. Насан туршийн хуримтлуулсан хөрөнгөөрөө тэнд үл хөдлөх хөрөнгө бий болгоод өнөөдөр явж байхад тэрийг нь үнэ цэнтэй байлгах асуудал чинь ерөөсөө энэ хот төлөвлөлтөөсөө л эхэлж байгаа юм.

Тэгэхээр бид энэ хандлагуудаа өөрчилж, зарим зүйлүүд гишүүд маань яаран сандран энэ Үндсэн хууль зөрчиж байгаа юм биш биз дээ энэ тэр гэж юм яриад байна лээ. Уг нь хараахан тийм зүйл байхгүй. Тэгэхээр энэ дээрээ анхаарах ёстой юм. Тэгээд гол асуудал ерөөсөө Улаанбаатар хотын асуудал биш. Ер нь зүгээр энэ аймаг, нийслэлийн Засаг дарга дээр төвлөрчхөөд байгаа энэ эрх мэдлийг задалъя гэж байгаа юм. Энэ эрх мэдэл задалбал сумд, дүүрэгт, хороонд маш олон юу гэдэг юм төсвийг дагаад чиг үүрэг нь очно, төсөв нь очно, хүний нөөц нь очоод иргэд анхан шатын нэгж дээрээ асуудлаа шийдүүлдэг.../минут дуусав/

Х.Булгантуяа: Сайнзориг гишүүн үргэлжлүүлэн 1 минут.

П.Сайнзориг: Пүрэвдорж дарга маань намайг 1 минут ярь гээд хэлж байгаа учраас ярина. Тэгээд гол асуудал ерөөсөө л энэ хандлагын өөрчлөлт байгаа юм. Тэгээд хэдүүлээ энийг нэг зөв өнцгөөс нь хаана хаанаа ойлголцоод явъя. Тэрнээс биш энэ ерөөсөө болохгүй зүйл гэдэг байдлаар битгий хандаасай гэж хүсэж байгаа юм. Тэгээд бүр болохгүй бол энэ Дархан, Эрдэнэд нь зориулаад тусдаа хуулийг нь баталъя гэж байгаа шүү дээ. Хот, тосгоны эрх зүйн байдлын хууль ерөөсөө Дархан, Эрдэнэтэд арай жижигдээд байгаа юм. Дархан, Эрдэнэтийн жишгээр нь энэ хуулийг жоохон босгыг нь өндөр болгочихъя гэхээр бусад хотуудад нь энэ хуулийн зохицуулалтууд нь томдоод байгаа юм. Тэгэхээр Дархан, Эрдэнэтэд нь тусдаа хуулийг нь гаргаад өгье. Тэгээд энийгээ иргэдийн хүсэж байгаа хотын захирагчаа өөрсдөө сонгодог больё энэ тэр гээд томоохон эрх зүйн өөрчлөлтүүд орчихсон юм шүү дээ. Тэгээд энийг Засгийн газар хэрэгжүүлэх талаас нь, иргэд, олон нийтдээ ойлгуулах талаас нь Эрдэнэбүрэн сайд анхаарч ажиллаасай гэж хүсэж байна. Тэгээд зарчмын хувьд дэмжиж байна.

Х.Булгантуяа: Сайнзориг гишүүн үг хэллээ. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Ноднин энэ Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль орж ирэхэд нь би эсэргүүцэж байсан. Ер нь Монгол Улс өргөн уудам нутагтай, хүн ам цөөхөн ийм улсад яг энэ төвийн бүсэд тойруулаад маш их олон хот байгуулна гэдэг төвлөрлийг хэт бий болгох ийм эрсдэлтэй. Тэгээд дүүрэг болгоныг хот болгочихно. Тэгээд эндээ хөрөнгө оруулалтаа илүү сайн тавиад явахаар эндхийн үйлчилгээ сайжраад, ийшээ хүмүүс бүх зүйлээ үзүүлэх гэж эмнэлэгт үзүүлэх гэж, сургууль сургах гэж бүгдээрээ ирцгээх байхгүй юу даа. Тэгээд өнгөрсөн жил жишээ нь 2024 онд хотын төсөв нийтдээ 3,3 их наяд төгрөгийн зардалтай байсан бол төсөвтэй байсан бол энэ жил 6 их наяд болж байгаа юм. Тэгээд энэ хэрээр энд хөрөнгө оруулалтууд бий болно, энэ хэрээр энд бүх төрлийн үйлчилгээ улам сайжирна гэсэн үг. Тэгэхээр энд, ийшээ хүмүүс бүгдээрээ хөдөө, орон нутагт байгаа тэр бүх хүмүүс бүгдээрээ энд ирж үйлчилгээ авах тоолонд тэр нөгөө нэг түгжрэл, утаа энэ тэр чинь бүгдээрээ л хэвээрээ байна. Ийшээ шилжиж ирэх шилжилт хөдөлгөөн улам ихэснэ. Ийм л нөхцөл байдал руу очиж байгаа.

Тэгэхээр энэ Монгол Улс шиг ийм өргөн уудам нутагтай газарт яадаг вэ гэх дээр таталцлын төвүүдийг хот болгож хөгжүүлж, тэрнийгээ улам сайжруулдаг ийм зүйл байгаа. Жишээ нь баруун бүсэд Ховд, наашаа эргээд Хархорин, тэгээд уламжлалт Дархан, Эрдэнэт байна, Даланзадгад байна, тэгээд Чойбалсан энэ тэрийг таталцлын төв болгож, түүнийгээ хот болгож хөгжүүлсний үр дүнд тэндээ хүмүүс сайн үйлчилгээ авч, илүү сайн эдийн засгийн болон нийгмийн харилцаанд орох ийм боломжийг бий болгосны үр дүнд энэ хот руу төвлөрдөг төвлөрөл чинь багасах байхгүй юу даа. Тэгэхээр энэ жишээ нь таталцлын төвүүд дээр хамгийн эхний ээлжид юу хийх ёстой юм бэ гэхээр тэнд сургуулиудыг, их сургуулиудыг байгуулах ёстой. Улаанбаатар хотоос энэ их сургуулиудыг бүгдээрээ ийшээ ирж байгааг бүгдийг нь багасгах ёстой. Дээрээс нь эмнэлгийн үйлчилгээ маш их авч байгаа. Тэгэхээр Улаанбаатар хотод тэр их том хавдрын эмнэлэг барьж байхын оронд бүсийн төвүүдээр сайн хавдрын эмнэлгүүдийг барьсны үр дүнд тэндээ үйлчилгээ авдаг, эмнэлгийн үйлчилгээ авдаг, наашаа явдаггүй болох ийм л бүх зүйлийг хийх байхгүй юу даа.

Тэгэхээр энэ асар их хурдтай нэмэгдэж байгаа энэ хотын хөрөнгө оруулалт чинь улам хотыг хамгийн сайн хөгжилтэй болгоно. Гэтэл бусад 21 аймаг чинь нийтдээ 2 их наяд төгрөгийн л зардалтай байгаа шүү дээ. Гэтэл Улаанбаатар хотод 6 их наяд төгрөгийн зардалтай байж байгаа. Хүн амын тал нь амьдардаг хөдөө орон, талаас илүү нь амьдардаг хөдөө орон нутагт 2 их наяд байхад Улаанбаатар хотод 6 их наяд байгаа. Энэ чинь өөрөөр хэлбэл хот маш хурдтай хөгжинө гэсэн үг байхгүй юу. Энэ хэрээрээ тэнд, энд ирж амьдрах тэр иргэдийн сонирхол чинь улам нэмэгдэнэ гэсэн үг. Тэгээд энэ хөдөө орон нутгийнхаа хөрөнгө оруулалтыг хаячхаад, таталцлын төвүүдийг хаячхаад, тэгээд ингээд Улаанбаатар хотын бүх дүүргийг хот болгоод ингээд явбал энэ чинь та нарын тэр утаатай тэмцээд байгаа, түгжрэлтэй тэмцээд байгаа тэр ажлууд чинь бүгдээрээ салхинд хийсэх мэт алга болно. Яагаад гэвэл хүн ам нь ихсэх тусам л нөгөө түгжрэл чинь хэвээрээ л байна. Хүн ам ихсэх тусам л тэр дэд бүтцийн чинь ажлыг шийдээгүй учраас утаа чинь ихэссэн хэвээрээ л байна. Энэ их хөрөнгө оруулалтууд чинь усанд асгасан, элсэнд асгасан ус шиг л болно гэсэн үг. Тийм учраас би энэ хуулийг анхнаасаа дэмжээгүй. Тэгэхээр энэ хууль нэг жилээр хойшилж байгаа юм байна. Тэгээд маш их асуудалтай, энэ чинь тэгээд газар нутгийн асуудлыг баг, иргэдийн хурлаар шийднэ, зөндөө асуудалтай. Тэгээд энэ хууль бүүр тэр чигээрээ алга болоосой гэж би бодож байна. Баярлалаа.

Х.Булгантуяа: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн, 4 номерын манай ажлын хэсгийнхэн бүгдээрээ индэр дээрээс хариулахаар байгаа шүү. 4 номерын индэр. 4 номерын индрийн микрофон өгье.

Х.Нямбаатар: Пүрэвдорж гишүүний саяын би хэлсэн үгэн дээр нэг тайлбар хийхгүй бол болохгүй нь. 1 дүгээрт нийслэлийн төсөв 2023, 2024 онд төсвийн урсгал болон хөрөнгө оруулалтын зардал яг адил тэнцүү хэмжээтэй 3,2 их наядаараа явж байгаа. Энэ олон нийтэд нэг ийм ташаа мэдээлэл буюу 6 их наядын төсөвтэй болчихлоо гэдэг тоо хаанаас гарч ирсэн бэ гэхээр 20 минутын хот буюу Сэлбэ дэд төвийг хэрэгжүүлэхтэй холбоотой гадаад бондыг босгосон тэр өртгийг төсөв дээр дурдаж явж байгаа. Энэ төсөл 2027 оны 10 сар гэхэд дуусахаар төсөл байгаа. Энэ төслийн санхүүжилтийн эргэн төлөлт 2027 оны 10 дугаар сард төлөгдөж дуусна гэдгийг 1 дүгээрт хэлье.

2 дугаарт Улаанбаатар хот хөгжих гээд байна, хөгжих нь дэмий, хөдөө орон нутгуудын таталцлын асуудал орхигдоно гэдэгтэй би санал нэгдэхгүй байгаа. Энэ Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг боловсруулсан хүмүүсийн нэг нь миний бие байгаа. Өнөөдрийн 21 аймгийн төвүүд нь дандаа сумын статустай байгаа. Хилийн дагуух бүх боомтууд нь мөн багийн статустай байгаа. Тэгэхээр бид засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, хот суурин газар гэдэг хоёрынхоо зааг ялгааг гаргаж, хот суурины хөгжлийг бий болгохын тулд Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг 2019 оны Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн зарим чиг үүргийг хот, тосгонд шилжүүлэх замаар хот суурины хөгжлийг дэмжих ийм бодлогыг гаргаж ирсэн юм.

Энэ хууль өнөөдөр яагаад хэрэгжих боломжгүй болсон нэг шалтгаан Улсын Их Хурал дээр байгуулагдсан ажлын хэсэг Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг хэрэгжүүлэхдээ, хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тогтоолын төслийг боловсруулах ажлын хэсэг хуралдаж амжаагүй. Өөрөөр хэлбэл шинээр байгуулагдсан хот тосгодын хилийн заагийг тогтоох Улсын Их Хурлын тогтоолын

төсөл боловсруулагдаж орж ирээгүй учраас энэ хууль хэрэгжих боломжгүй болчихоод байгаа юм. Өөрөөр хэлбэл бид энэ хууль хэрвээ Их Хурал ингээд хойшлуулж чадсан тохиолдолд энэ нэг жилийн хугацаанд бид яаралтай хамгийн түрүүнд шинээр байгуулагдаж байгаа бүх хот тосгодын хилийн заагийг тогтоосон Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах шаардлагатай байгаа.

2 дугаарт Хот, тосгоны хуулийг хэрэгжүүлэхдээ авах холбогдуулан авах зарим арга хэмжээний тогтоолыг давхар баталж өгөөд, тэгээд бид нэгэнт энэ Үндсэн хуулийн реформ шинэчлэлийн дагуу суурин газрын соёл иргэншлийг дэмжих гэж байгаа энэ эрх зүйн шинэчлэлээ цаашид үргэлжлүүлэх нь зөв байх гэж бодож байна.

Х.Булгантуяа: Бөхчулууны Пүрэвдорж дарга үг хэлнэ.

Б.Пүрэвдорж: Би ер нь хот хөгжих ёсгүй гэдэг утгаар яриагүй шүү дээ. Хот хөгжих гээд байна. Өөрөөр хэлбэл хөрөнгө оруулалт асар их нэмэгдэж байна, хот хөгжих гээд байна. Тийм учраас энд эдийн засаг болон нийгмийн маш их олон сайн үйлчилгээ үзүүлэх юм байна, тэр хэрээр хотоос хөдөөгөөс хүмүүс шилжиж ирэх гээд байна, тэр шилжилтийг багасгахын тулд таталцлын хотуудыг хөгжүүлэх замаар энэ хотдоо ирэх тэр шилжилт хөдөлгөөнөө багасгаж аваач л гэж зөвлөгөө өгч байгаа юм. Өөр юм байхгүй. Бусдаар юу гэдэг юм яг урсгал зардал 3,3 их наяд байж байгаад 4,3 их наяд болсон байх. Нэг жилийн дотор л 1 их наядаар нэмэгдэж байгаа. Тэгэхээр энэ юуг илэрхийлж байна вэ гэвэл урсгал зардал чинь шүү дээ. Тэгэхээр энэ юуг илэрхийлж байна вэ гэвэл танай янз янзын бүтээн байгуулалтын ажлууд чинь илүү сайжрах юм байна, хөрөнгө оруулалт нь сайжрах юм байна, үүний үр дүнд хот сайхан болох юм байна л гэдгийг би хэлж байгаа юм. Энэ хот хөгжих, битгий хөгжөөсэй гэж агуулгаар явах.../минут дуусав/

Х.Булгантуяа: Үг хэллээ. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн.

С.Эрдэнэболд: Хуулийн хэрэгжилтийг хойшлуулахыг дэмжиж байгаа. Шалтгаанууд эндээс үндэслээд асуулт асууна. Сая бид ингээд энэ Хархорум хотын хууль Улсын Их Хурлаар баталсан, Хүннү хот гээд ингээд баталсан. Өмнө нь бид Аэро сити гээд ярьж байсан, Майдар хот гээд ярьж байсан, их олон хотууд босох нь. Энэ хотууд босохтой зэрэгцээд ер нь одоо байгаа Улаанбаатар хотын хөгжил 2040 он хүртэлх боломж бололцоо, чадавх, эрсдэл гээд бид ярилцсан. Тэгэхээр нэгэнт энэ хууль нэг жилээр хэрэгжилт нь хойшилж байгаа юм бол энэ хууль батлагдсанаас хойш дахиад энэ олон том сорилтууд, зорилтууд, хотуудын энэ хуулиуд гараад ирчихсэн учраас энийг хооронд нь уялдуулах зайлшгүй шаардлага гарч ирж байгаа юм. Ингээд Хархорум гэнгүүт чинь зөвхөн дэд бүтэц нь гэхэд л ойролцоогоор 5 тэрбум ам.доллараар үнэлэгдэнэ гэсэн ийм ерөнхий төлөвлөгөө гараад байгаа байхгүй юу.

Тэгэхээр одоо байгаа энэ нөгөө томоохон сууринуудтай ер нь хүн ам олноороо оршин суудаг газрыг хот гэж үзэх үү? Концепцын хувьд тэнд нийгэм, эдийн засгийн, инженерийн дэд бүтцийг цогцоор нь харсан ийм бүтээн байгуулалтуудыг хот гэж үзэх үү гэдэг ийм концепцын ялгаа харагдаад байгаа юм. Ихэнх хүмүүс хот гэнгүүт жишээлбэл Улаанбаатар хот ч гэдэг юм уу энэ хүрээндээ бодоод байгаа бол бид дараагийн 20, 30, 40, 50 жилийн алсын хараатайгаар энэ хуулийг хэрэгжилтийг нь хойшлуулж байгаа бол дахиад авч үзэх шаардлагатай юм байна гэж үзэж байгаа. Тухайлбал Алсын хараа 2050 хөтөлбөрт Хархориныг 2050

он гэхэд нийслэлийн чиг баримжаатай хот болгон хөгжүүлнэ гээд заачихсан байхгүй юу. Энэ нь юу гэсэн үг вэ гэхлээр 2050 онд, 50 он гэхэд буюу 25 жилийн дараа гэхэд Хархорин Монгол Улсын нийслэл л байх юм байна гэсэн сэдэл ойлголтыг өгч байгаа юм. Өөрөөр хэлбэл чиг баримжаатай гэхсэн.

Тэгэнгүүтээ одоо хуульдаа болохлоороо энийгээ сая баталсан хуульдаа тусгаагүй байх жишээтэй. 2040 он хүртэлх нийслэлийн бодлогын бичиг баримт дээр нэмэх нь дахиад 10, нийт 11 бодлогын бичиг баримтад тулгуурлаж Улсын Их Хурал шийдвэр гаргаж байгаа юм. Тэгэхээр одоо байгаа эрсдэл, зовлон жаргал, ирээдүйд учирч болох зовлон, жаргал энэ бүх зүйлийгээ ингээд харилцан динамиктай судалж, оруулах зайлшгүй шаардлагатай байна гэж хараад байгаа юм. Энэ утгаараа энэ хуулийн хэрэгжилтийг хойшлуулж байгаа бол дахиад 26 оны 1 сарын 1-нд энэ хууль маань шууд автоматаар хэрэгжээд эхлэхэд саяын энэ намрын чуулганаар болон хаврын чуулганаар орж ирж батлагдсан энэ шинэ хуулиудтай маань уялдаа нь хэр хангагдах вэ гэдэг дээр хариулт өгөөч. Зайлшгүй уялдаа нь хангагдана гэж үзэж байна уу, эсхүл энэ уялдаа хангагдахгүй. Өөрөөр хэлбэл зохицуулалтын хувьд бид дахиад сайжруулах шаардлагатай гэж үзэж байна уу?

Хэрвээ тэгж үзэж байгаа бол бид энэ хуулиа дахиад задлаад энэ одоо байгаа болон ирээдүйд бий болох тулгамдах асуудал бэрхшээлүүдийг нь цогцоор нь хараад, 26 оны 1 сарын юу, 6 сарын 1-нээсээ өмнө бид энэ дээр дахиад авч үзэх зайлшгүй шаардлага байна. Тэгэхээр ажлын хэсгээс асуухад 2 асуулт 1 дүгээрт нь бид энэ хууль, эрх зүйн хувьд сая баахан нэмээд хотын хуулиуд гаргачихсан, энэнтэйгээ ингээд уялдуулах, уялдуулах яг тэр боломж нь яг ямар байгаа юм бэ? Эндээ болохлоороо мэдээж энэ инженерийн дэд бүтэц, нийгэм, эдийн засгийн дэд бүтэц, дээрээс нь тэр эрүүл мэнд, боловсрол гээд цогцоор нь харах шаардлагатай болчихоод байгаа юм. Одоо бол прагматик яаж яваад байна гэхлээрээ Бүсүүдийн чуулган гээд ЗГ хуралдаад байна. Улаанбаатараас гадна 6 бүс гээд байна. Тэгээд энэ бүсийн хурал чуулганаар дамжуулж тэнд хөрөнгө оруулалтын шийдвэрүүд гараад байгаа. Энэ эрүүл биш тогтолцоо байхгүй юу. Заавал нэг тэнд бүс дээр хурал очиж байж, Засаг очиж хуралдаж байж асуудал шийддэг биш. Тэгээд тэр бүсүүд дотор жишээлбэл яг энэ нийгэм, эдийн засаг, инженерийн дэд бүтцийг энэ хуулиар яаж хийх боломж байна вэ гэдэг асуулт байна.

Х.Булгантуяа: 4 номерын индэр дээрээс хотын дарга Нийслэлийн Засаг дарга буюу Улаанбаатар хотын захирагч Хишигээгийн Нямбаатар.

Х.Нямбаатар: Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулиар 2 мянгаас доошгүй хүн амтай суурьшил бүхий газрыг тосгон гэж нэрлэж байгаа. 30 мянгаас дээш, 100 мянгаас доош хүн амтай хот суурин газрыг орон нутгийн зэрэглэлтэй хот гэж томьёолсон. 100 мянгаас дээш хүн амтай байхаар төлөвлөсөн хот суурин газрыг улсын зэрэглэлтэй хот байна гэж томьёолж байгаа. Тэгэхээр бид дахиад л би нөгөө яриа руугаа орно. Энэ засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн чиг үүрэг, хот суурины чиг үүрэг 2-ыг бид энэ Хот, тосгоны эрх зүйн байдлын хуулиар зааглаж өгч байгаа юм. Таны саяын асуусан асуултад хот, тосгон болсноороо ямар давуу талтай юм бэ гээд. Тэгэхээр бид хот суурин болсноороо 1 дүгээрт хотын татвартай болно, 2 дугаарт хот суурин болсноороо хотын дэд бүтцийн сантай болно, инженер хангамж, төлөвлөлтүүдтэй болно гэсэн ийм том зорилт тавьж байгаа.

Хархорум хотын эрх зүйн байдлын тухай хууль, Хүннү хотын эрх зүйн байдлын тухай хууль бол одоо хэдийн үйлчлээд эхэлчихсэн явж байгаа. Бид Хүннү хотыг анх удаагаа 19 оны Үндсэн хуульд тулгуурлаж хийж байгаа нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн зарим чиг үүргийг хотод шилжүүлж байгаа. Өөрөөр хэлбэл Төв аймгийн Сэргэлэн сум, Төв аймгийн Аргалант сум 2 дээр байгаа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн чиг үүргийг хот, Улаанбаатар хот, Төв аймаг 2 дундаа корпорац байгуулаад, корпорацын зарчим дээр байгуулагдсан хотдоо тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид байгаа чиг үүргүүдийг шилжүүлж өгч байгаа юм. Газраа олгодог, татвараа төвлөрүүлж хураадаг, хот сууринаа төлөвлөдөг, инженер хангамжийнхаа дэд бүтцийг татдаг ийм байдлаар томьёолол үүсгэж ингэж анхны ийм хотуудыг байгуулах төлөвлөлт хийж байгаа гэдгийг хэлье.

Дээр нь ер нь бид энэ сумын төвүүд ч тэр, аймгийн төвүүд ч тэр, хуучин суурьшил бүхий байсан энэ газруудыг хот, тосгоных нь зохион байгуулалт руу шилжүүлэхгүй бол хот, тосгоны асуудал орхигдсон. Инженер хангамжийн сүлжээтэй сум маш цөөхөн. Усны нэгдсэн шугам сүлжээтэй, ариутгах татуургын нэгдсэн шугам сүлжээтэй сумын төв гэж ер нь маш цөөхөн байгаа. Дээр нь төвлөрсөн халаалт, хэсэгчилсэн халаалт, инженер хангамжийн төвүүд байхгүй байгаа. Тэгэхээр энэ уг нь Хот, тосгоны хууль хэрэгжсэнээр эдгээр асуудлыг цогцоор нь хэрэгжүүлбэ гэж байгаа юм.

Таны 2 дахь асуултад би товчхон хариулахад одоо энэ хууль хэрэгжсэнээс хойш та хэд юу хийх гэж байна вэ гээд. Их Хурал яаралтай Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд заасан энэ хот, тосгодын хилийн заагийг тогтоож өгмөөр байна. Тухайлбал Улаанбаатар хот 2040 гэдэг ерөнхий төлөвлөгөөгөө батлуулсны араас хилийн зааг нь тогтсон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөгөө баталж авах гээд байгаа юм. Өөрөөр хэлбэл нөгөө 14 хотын аль хот нь хэдэн өндөр давхартай, хэдэн хороололтой байх юм, хэчнээн зогсоол паркинг байх юм, хэчнээн нийтийн эзэмшлийн парктай байх юм энэ болгоноо бид нэгдсэн байдлаар 2040-ийнхөө дагуу.../минут дуусав/

Х.Булгантуяа: 4 номерын микрофоныг нэмж өгье.

Х.Нямбаатар: Тийм энэ хилийн зааг тогтсон, Батлут гишүүн бид хоёр 2 ч удаа ажлын хэсэг хуралдуулах гээд тухайн үед ирц бүрдээгүй. Одоо энэ хилийн цэсийг гялс яаралтай тогтчихвол тухайлбал би бусад аймгуудыг мэдэхгүй байна. Улаанбаатар хотын хувьд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөгөө яаралтай олон улсын нээлттэй тендерээр зуруулж, төлөвлөлтөө хийж, үүнийхээ дагуу нөгөө 14 хоттой байх, эмнэлгийн хүртээмж, хууль сахиулах байгууллагын хүртээмж, соёлын хүртээмж, нийтийн эзэмшлийн тэр паркуудаа төлөвлөх, боловсролын хүртээмж энэ тэрээ яаралтай төлөвлөж, Хот, тосгоны хуулийн хэрэгжих хэрэгжилтийг хангах ажил хийх шаардлагатай байгаа гэдгийг хэлье.

Х.Булгантуяа: Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль бол хотын эдэлбэр газрын хэмжээ, заагийг тогтоох, өөрчлөх асуудлыг түрүүн яригдаж байсан ЗГ-ын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал, тосгоны эдэлбэр газрын хэмжээ, заагийг тогтоох, өөрчлөх асуудлыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, эсхүл Хотын зөвлөлийн саналыг үндэслэн ЗГ шийдвэрлэнэ гэж байгаа. Мөн

үүнтэй холбоотойгоор Улсын Их Хурлаас 2024 оны 72 дугаар тогтоолыг баталсан. Эрдэнэбүрэн сайд нэмж хариулъя.

Р.Эрдэнэбүрэн: Эрдэнэболд гишүүн тэр Хархорумын, Хархорум хотын асуудлаар илүү тодруулж асууж байна. Үнэндээ энэ хэд хэдэн хуулиуд, олон хуулиудад өөрчлөлт оруулах шаардлагатай болчихоод байгаа учраас энэ дахиад цаг авч байгаа. Тухайлбал энэ нийт Их Хурлын 24 оны 72 дугаар тогтоолоор заасан тэр 52 хотоос 8 хот нь ерөнхий төлөвлөгөөгүй байж байгаа одоогийн байдлаар. Тэгээд тэрний нэг нь Хархорум хот байгаа. Хархорум хотын ерөнхий төлөвлөгөөг эхлүүлэх, ерөнхий төлөвлөгөөний ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлыг Барилгын яаман дээр хангагдаад явж байгаа. Тэгэхлээр энэ ерөнхий төлөвлөгөө гарсны дараа нөгөө Хархорум хотын эрх зүйн байдлын тухай хууль дээр өөрчлөлт оруулах уу, үгүй юү гээд ийм асуудлууд үүсэхээр ингэж харагдаж байгаа. Тийм учраас таныг ингэж ойлгож байгаад их баярлаж байна. Цаг авах шаардлагатай байна гэдгийг хэлмээр байна.

Х.Булгантуяа: Эрдэнэбүрэн, асуулт болчихсон тийм ээ, хариулт. Пүрэвжавын Ганзориг гишүүн.

П.Ганзориг: Энэ Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль үзэл баримтлалын хувьд нутгийн өөрөө удирдах ёс буюу энэ аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үндсэн эрх, үүргийг үгүйсгэсэн агуулгатай, дээр нь нэмээд ойлгомжгүй тодорхойгүй олон асуудлууд байна. Тийм болохоор энийг хойшлуулахаас гадна Улсын Их Хурлын даргаас ажлын хэсэг гаргаад шаардлагатай өөрчлөлтүүдийг даруй хийгээд явах нь зөв болов уу гэсэн саналтай байна. Тэгээд үүнтэй холбоотой 3 зүйлийг тодруулж асууя.

1 дүгээрт Үндсэн хуулийн 13 дугаар зүйлийн нэгд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот мөн гээд заачихсан. Тэгэхээр Улаанбаатар хотыг 14 хотод хувааж байгаа. 14 хот маань өөрөө зөвлөлтэй, захирагчтай. Хотын захирагчид нь газрынхаа шийдвэрүүдийг гаргаад явж байгаа. Тэгэхээр Улаанбаатар хот маань өөрөө эдэлбэр газаргүй болж эндээс таарахаар харагдаад байгаа юм. Тэгэхээр эдэлбэр газаргүй болчих юм бол хот гэдэг статус нь байхгүй болно гэсэн үг. Тэгэхээр энэ маань энэ Үндсэн хууль дээр заасан нийслэл байж чадахаа байж болзошгүй ийм зүйл харагдаад байна. Тэгэхээр энэ дээр 1 дүгээрт хариулт өгөөч тодорхой.

2 дугаарт Улаанбаатар хотыг 14 хотод хуваахдаа 2 дүүргийн газар нутаг дэвсгэрээс тухайлбал Хан-Уул, Баянгол дүүргийн нутаг дэвсгэрээс эдэлбэр газар аваад Хан-Уул гээд хот байгуулна шинээр. Тэгэхээр Хан-Уул дүүрэг, Баянгол дүүрэг чинь өөрөө Иргэдийн хуралтай. Шинээр байгуулагдаж байгаа Хан-Уул хот чинь өөрөө зөвлөлтэй, захирагчтай. Ингээд яг нэг тодорхой асуудал дээр буюу яг энэ тухайн нутаг дэвсгэрийнхээ нийгэм, эдийн засгийн асуудлаар энэ 3 субъект яг нэг асуудлаар 3 өөр шийдвэр гаргая гэж бодъё. Тэгэхэд энийг алийг нь хэрэгжүүлэх юм бэ? Магадгүй шүүх дээр очлоо гэхэд шүүх алийг нь хүлээж авах юм бэ? Аль нь хүчин төгөлдөр вэ? Энэ дээр нэг тодорхой хариулт авъя.

3-д энэ хот ингээд 14 хотуудад хуваагдаад ингээд явахаар Улаанбаатар хотод амьдарч байгаа нийт 1,6 сая хүн ам, Эрдэнэт, Дархан гээд бараг 2 сая хүний иргэдийн хаягжилт, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний хаяг гээд энэ хаяг address-н томоохон өөрчлөлтүүд хийгдэнэ. Энэ ямар хугацаанд хийгдэх вэ, ямар

хэмжээний зардал мөнгө гарна гэж төлөвлөгдөж байгаа вэ? 2021 онд Улаанбаатар хотын хороодыг 30 гаруйгаар нэмэгдүүлээд, 9 дүүргийн хороодыг 204 хороотой болгосон. Тэр үед яг энэ хороодын тоо нэмэгдүүлсэнтэй холбоотой иргэдэд нэлээн чирэгдлүүд гарна, ажлууд, төсвүүд гарна гээд ярьж байхад тийм өөрчлөлтүүд гарахгүй гээд тодорхой газрууд нь тайлбар өгөөд явж байсан хэдий ч хороо өөрчлөгдөнгүүт эргээд төрөөс үйлчилгээ авах гээд очих гэнгүүт та хаягийн шинэчлэлээ хийлгэж ир гээд, иргэний үнэмлэхээ шинэчлэх, гэрчилгээгээ шинэчлэх гээд асар их хүндрэлүүд үүссэн. Яг энэ шиг ийм хүндрэлүүд үүсэх үү? Энэ дээр ямар хэмжээний төсөв, хугацаа зарцуулна гэж тооцож байгаа вэ гээд ийм 3 асуулт асууя. Баярлалаа.

Х.Булгантуяа: Сайд хариулах уу? Эрдэнэбүрэн сайд.

Р.Эрдэнэбүрэн: 1 дүгээр асуултад хариулъя. Энэ Үндсэн хуультай холбоотой асуудал 2019 оны 11 сарын 14-ний өдөр Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр үндсэндээ шийдэгдсэн гэж үзэж байгаа. Энэ Үндсэн хуулийн энэ өөрчлөлтийн 57 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын, түүнчлэн тосгоны өөрийн удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг хуулиар тогтооно. Хот, тосгоны, хот, тосгонд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлэх асуудлыг ЗГ-ын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ гэж заасан учраас энэ Үндсэн хуультай холбоотой маргаан байхгүй болсон гэж үзэж байгаа. Тэгээд энэ хүрээнд энэ Үндсэн хуулийн энэ өөрчлөлтийн хүрээнд Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль батлагдсан.

2-т нь энэ яах вэ энэ хуулиар нийслэл, иргэд нөгөө хот, тухайн аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн Хурал, Хотын зөвлөл, Хотын захирагчийн хийх ажлуудыг маш нарийн ялгаж тогтоож өгсөн байгаа давхардуулахгүй байдлаар. Энэ хуулийн нэг хамгийн чухал зүйл бол Хотын захирагч бол хотын иргэдээс сонгогдоод илүү аж ахуйн асуудлууд руу орж байгаа хот дээрх. Одоо бол харьцангуй иргэдийн хурлаас сонгогдсон Засаг дарга нар аж ахуйн асуудлаасаа илүү улс төрийн асуудалтай зууралдаж явсаар байгаад энэ хотынхоо ажил руу орж чадахгүй байна гэж үзэж байгаа. Ингээд хот бол өөрийнхөө иргэдтэйгээ нийлээд хамтраад оролцуулаад, төлөвлөлтөө хийгээд ингээд явах ийм илүү сайн дүр зураг харагдаж байгаа гэж ингэж хариулмаар байна. Сүүлийн асуулт дээр хот дээр гарах хөрөнгө мөнгөтэй холбоотой асуудал дээр тооцоо байна уу гээд Нямбаатар дарга хариулчих.

Х.Булгантуяа: Нямбаатар дарга байхгүй бол хэн хариулах вэ ажлын хэсгээс, Үнэнбат хариулах уу? 4 номерын микрофон дээрээс иргэдийн үнэмлэх үл хөдлөхийн гэрчилгээтэй холбоотой.

М.Үнэнбат: Гишүүний асуултад хариулъя. Яг саяын энэ асууж байгаа асуултын хүрээнд энэ Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль дээр заасан зохицуулалт орсноор хот бол өөрийн гэсэн хороололд хуваагдах ийм зохицуулалт байгаа. Тэгээд дээрээс нь эдгээрийг оруулахын тулд бидний энэ хуулийн өөрчлөлт орж ирж байгаа нэг шалтгаан байгаа. Ер нь зүгээр иргэний үнэмлэхийн тухайд одоо сүүлд орсон Иргэний улсын бүртгэлийн хуулийн өөрчлөлтийн нэг зүйл бол иргэн иргэний үнэмлэх дээр өөрийн гэсэн дугаар олгодог, тэр дугаар нь нууцлалтай байдаг, түүн дээр цахим шилжилтийг нь нууцлалаар нь шийдээд ордог. Түүгээрээ иргэний цахим үнэмлэхээ уншуулангуут хаягийн бүртгэл нь

өөрчлөгддөг ийм өөрчлөлтийг 2, 3 жилийн өмнө энэ Иргэний бүртгэлийн хуульд оруулчихсан байж байгаа. Тэгэхээр энэ хүрээндээ цахимаар шилжилтийг нь хийгээд явахад ямар нэг иргэний үнэмлэх дээр хуучин шиг хаягийн бүртгэлийг нь төддүгээр хорооны тэр, тэр гэж бичихээ больсон. Тийм учраас энэ хүрээндээ шийдээд явахад цахимын хүрээнд шийдвэрлэх боломжтой байгаа. Тэгэхдээ энийг ажлын.../минут дуусав/

Х.Булгантуяа: 4 номерын микрофон нэмж өгье.

М.Үнэнбат: Тэгэхээр хуулийн хэрэгжилтийг хангах явцад энэ дахиад нэг жилээр хэрвээ сунгагдвал энэ хүрээндээ хүлээгдэж байгаа бас нэг ажил бол энэ ажил байгаа. Тэгэхээр энийг бид бүхэн ажлын хэсгийн хүрээнд шийдээд явчих боломжтой гэж үзэж байгаа.

Х.Булгантуяа: Нэмж хариулья 4 номерын микрофон.

М.Үнэнбат: Хуулийн этгээдийн улсын бүртгэл, аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн тухайд мөн цахимаар шийдвэрлэх боломжтой гэж үзэж байгаа. Хэрвээ шинээр дахиад сунгуулаад авах тохиолдолд тэрийг нь шинээр олгосон тэр хаяг дарааллаар нь өгөөд явах боломж нь үүссэн гэж үзэж байгаа.

Х.Булгантуяа: Ганзориг гишүүн нэмж тодруулья.

П.Ганзориг: Би уг нь яг маш тодорхой асуусан юм. Тэгээд уг нь тодорхой хариулт авчихмаар байгаад байгаа юм. Нэг дэх нь тэр Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот мөн гээд энэ статус тодорхойгүй байдалд ороод байна. Энэ яг орохгүй гэсэн баталгаа нь хаана байгаа юм бэ? Өөрөөр хэлбэл хот байх юм бол өөрөө эдэлбэр газартай байх ёстой. Тэр эдэлбэр газар нь 14 хотод хуваагдаад явчихаар байхгүй болчих гээд байна. Яг энэ дээр тодорхой хариулт өгөөч гээд.

2-т тэр 3 субъект буюу 2 дүүргийн иргэдийн Хурал, Зөвлөл яг нэг асуудлаар ялгаатай шийдвэр гаргавал алийг нь авах юм бэ? Энэ хаана тодорхой байгаа юм бэ?

3-д сая цахимаар шийдээд явчихна гэж байна. Яг хороодыг нэмэхэд яг ийм хариулт өгч байсан байхгүй юу. Тэгээд төрөөс очоод үйлчилгээ авах гээд очих гэнгүүт компанийг жишээлбэл улсын бүртгэлийн гэрчилгээ дээр хаягийн шинэчлэл хийлгэ ир, байна дахиж хийлгэ гээд бөөн явдал болно. Иргэдийг ч ялгаа байхгүй. Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээгээ хаягийн өөрчлөлт хийгээд ир, тэгж байж тухайлбал банкнаас зээл авах байдаг юм уу, эсвэл зарах, шилжүүлэх ийм асуудлууд тулгарна.

Х.Булгантуяа: 4 номерын микрофон. Энэ гишүүдийн асуугаад байгаа, 4 номерын микрофон. Үнэнбат дарга. Асуугаад байгаа асуултад маш тодорхой хариулаад өгөөч. Энэ яг иргэд үүн дээр эргэлзээд байгаа байхгүй юу.

М.Үнэнбат: Гишүүний асуултад хариулья. Үндсэн хууль дээр хот, тосгоны чиг үүргийг эрх шилжүүлэх байдлаар Улсын Их Хурал шийдвэрлэнэ гэсэн ийм заалттай. Энэ хүрээндээ хотын чиг үүрэгт тухайн Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хууль дээр байгаа иргэдийн Төлөөлөгчдийн Хурлынхан бол хурал чиг үүргээ шилжүүлнэ. Энэ тохиолдолд шилжүүлсэн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа

Хотын зөвлөлийн гаргаж байгаа шийдвэр нь хуулийн хүчин төгөлдөр болоод явна гэсэн үг. Тэгэхээр 1 асуудлаар 2 зэрэг шийдвэр гаргахгүй л гэдэг энэ дээр. Яагаад гэхээр өөрсдийнхөө чиг үүргийг хуульд заасны дагуу шилжүүлчхэж байгаа учраас шилжүүлсэн чиг үүргийг хэрэгжүүлээд явахад тэр хэрэгжүүлж байгаа шийдвэр нь хүчинтэй байна гэсэн үг.

2 дугаарт нь юу байна вэ гэхээр нийслэл Улаанбаатар хот дагуул хоттой байж болно гээд Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль дээр тодорхой заачихсан байгаа. Нийслэл Улаанбаатар хот байна, улсын зэрэглэлтэй хот байна, хот.../минут дуусав/

Х.Булгантуяа: Эрдэнэбүрэн сайд нэмж хариулъя.

Р.Эрдэнэбүрэн: Энэ нийслэл Улаанбаатар хот өөрөө эдэлбэр газаргүй болоод хотынхоо статусыг алдчихна гэсэн санаа зовох зүйл бол байхгүй. Үндсэн хууль дээр угаасаа нийслэл Улаанбаатар хот гээд байж байгаа. 2 дугаарт энэ 14 хот чинь, дээр нь 3 дагуул хот чинь нийслэлд, орон нутгийн чанартай хот байхгүй юу. Юу яачихсан байгаа шүү дээ, зааглачихсан байгаа шүү дээ. Улсын чанартай хот, юуны улсын зэрэглэлтэй хот, тэгээд орон нутгийн зэрэглэлтэй хот гээд. Тийм учраас энэ 14 хот чинь бол 14 хотын хил хязгаар тогтоод ирэнгүүт нийслэл өөрөө эдэлбэр газаргүй болно гэсэн тийм зүйл байхгүй гэж хэлмээр байна.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Мягмарсүрэнгийн Бадамсүрэн.

М.Бадамсүрэн: Энэ хуулийг уг нь бэлтгэл ажлаа сайн хангаад хэрэгжүүлээд явсан бол их сайн байсан. Дахиад нэг жилийн хугацаагаар хойшлуулъя гэж байгаа юм байна. Тэгээд энэнээс цааш хойшлуулахгүй байх нь зүйтэй. Тэгээд энэ хугацаанд ер нь 1 дүгээрт бэлтгэлээ яг дахиад хангаж чадах уу? Дахиад жилийн дараа дахиад бэлтгэл ажил болсонгүй гээд сууж байх юм биш биз дээ? Яагаад гэхээр энэ хуулийн төслийн үзэл баримтлал дээр хойшлуулж байгаа үндэслэл тийм тодорхойгүй байна лээ. Яг хууль, эрх зүйн хувьд ийм, ийм зүйлээс шалтгаалаад хойшлуулъя гэдэг зүйл тодорхойгүй байна лээ 1.

2 дугаарт нь энэ орон нутгийн шинж чанартай хотуудыг хөгжүүлэх дээр их онцгой анхаарахгүй бол үндсэндээ бид бүсчилсэн хөгжлийг дэмжих, төвлөрлийг сааруулах бодлого гээд маш олон бодлогын баримт бичиг гаргадаг хэдий ч яг энэ орон нутгийн төвлөрсөн хотуудыг хөгжүүлэх, дэмжих тал дээр ялангуяа орон нутагт төсвийн эрх мэдлийг нэмэгдүүлэх, томилгооны эрх мэдлийг нэмэгдүүлэх, өмчийн эрх мэдлийг нэмэгдүүлэх чиглэлээр энэ хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд тодорхой ийм бодлогыг энэ хугацаанд хийж хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байгаа. Тухайлбал энэ төрийн өмч гээд байна, тусдаа орон нутгийн өмч гээд байна. Ялангуяа орон нутгийн томилгоо гэхэд үндсэндээ ихэнх нь босоо томилгоотой болчихсон. Өмнө бол дийлэнх нь орон нутаг хэвтээ томилгоотой байсан бол одоо эсрэгээрээ болсон. Энэ ардчилсан нийгмийн үнэ цэнтэй хамгийн чухал зүйл энэ хэвтээ нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг бэхжүүлэх тогтолцоо.

Яагаад гэвэл Монгол Улс их өргөн уудам нутагтай, 21 аймагтай, нэг аймгийнх нь нутаг нэг улсын нутгаас том хэмжээтэй. Тэгэхээр энэ бол өөрөө хэдий нэгдмэл улс хэдий ч орон нутгийн засаг захиргааны нэгж тэр дундаа төвлөрсөн энэ суурин газруудыг дэмжих, төсвийн хувьд бие даалгах энэ бодлого бол хамгийн

чухал байгаа. Жишээлбэл Боловсролын хуульд өөрчлөлт ороод ингээд яамны сайд аймгийн Боловсролын газрын даргыг томилдог ийм тогтолцоог бүрдүүлсэн байна лээ. Яг үнэндээ яамны сайд хүн, Боловсролын яамны сайд хүн орон нутгийн боловсролын газрын даргатай энэ ажил хэргийн хувьд хэр уялдаа холбоотой байнгын хамтарч ажилладаг юм бол, би бол мэдэхгүй байна. Эсрэгээрээ сая Америкийн нэгдсэн улсад гэхэд энэ Боловсролын яамаа үндсэндээ татан буулгасан байна гэж ойлгож байгаа шүү дээ. Орон нутгийн мужуудад энэ боловсролын асуудлыг бие даан хэрэгжүүлэхийг даалгасан гээд. Бүгд Найрамдах Солонгос улсад ч гэсэн ингээд Боловсролын газрын дарга нь иргэдээсээ хотын даргынхаа дараа сонгогддог байх жишээтэй.

Тэгэхээр бид ингээд энэний энэ хөгжингүй орнуудын энэ жишгээс аль болох эсрэг болоод ингээд бүх зүйл нь босоо болоод байгаа юм. Төсвийн эрх мэдлийн хувьд босоо, өмчийн хувьд босоо, томилгооны хувьд бүгд босоо. Тэгээд энэ зүйлийг арилгахад уг нь энэ хотыг хөгжүүлэх, хотыг бие даалгах, энэ хотын захирагчийг сонгох бодлого хамгийн чухал байсан юм. Тэгээд энийг дахиад дараа жилээс хойш, үүнээс хойш газар үгүй гэдэг шиг битгий хойшлуулаарай, нэг жилийн хугацаанд бэлтгэл ажлаа бүрэн хангах хэрэгтэй. Ингэж байж орон нутгийн хотуудын бие даасан байдал хангагдаж, төвлөрөл саарна. Нийслэл Улаанбаатар хотод ч гэсэн асуудлаа шийддэг ийм хотуудын төсвийн болон бусад эрх мэдэлтэй ийм бүтэц зохион байгуулалтад орохыг бид цаг алдахгүй, яаралтай л хийх ёстой болно. Тэгээд энэ дээр тодорхой хариулт авъя.

Х.Булгантуяа: Эрдэнэбүрэн сайд хариулъя.

Р.Эрдэнэбүрэн: Энэ хуулийн хэрэгжилтийг хойшлуулах үндсэн шалтгаан шинээр байгуулагдах энэ хотуудын хил хязгаарыг тогтоох, эдэлбэр газрын хил хязгаарыг тогтоох ажил байгаа юм. Энэ дээр их цаг авахаар байгаа. Зарим хот байгуулагдаж байгаа хотын газар эдэлбэр газар нь 3 ч сумын газар нутаг дээр байгуулагдахаар ийм байдалтай байгаа. Тэгэхээр нөгөө орон нутагт иргэдийн Хурал, багийн хурлууд хуралдаж шийдвэр гаргах шаардлагатай болж байгаа. Энэ шууд ингээд автоматаар Хэрэг эрхлэх газраас яриад хил хязгаарыг нь тогтоочих тийм боломжгүй нөхцөл байдалтай байгаа. Энэ бол зөвхөн ЗГ-ын ч ажил биш, ялангуяа орон нутгаас сонгогдсон Их Хурлын гишүүдэд энэ хуулийн хэрэгжилт дээр оролцож өгвөл их иргэдэд ойлгуулахад сайн болох болов уу гэж ингэж бодож байгаа.

Дээр нь хэд хэдэн газар ерөнхий төлөвлөгөөний ажил хийгдэж явж байгаа. Зарим дээр нь бэлтгэл ажил нь хийгдэж явж байгаа. Тэгээд энэ ерөнхий төлөвлөгөөнүүд гарах нь нэг хил хязгааруудыг нь тохироход их ач холбогдолтой байгаа. Тийм учраас нэг жилээр сунгаж ажиллая гэж хуулийн төсөл оруулж ирж байгаа. Тэгээд үнэхээр та ч гэсэн хэлж байна. Маш чухал хууль. Зайлшгүй хэрэгжих шаардлагатай. Тийм учраас дахиж хойшлуулахгүйгээр хэрэгжүүлэхийн төлөө ажиллана. Дахиж хойшлуулахгүй гэж ингэж бодож байгаа.

Х.Булгантуяа: Энэ бол тухайн үед батлагдахад их чухал хууль гэж батлагдаж байсан. Ер нь олон улсын судалгаагаар ч гэсэн энэ олон улсын McKinsey гээд олон улсын байгууллагын судалгаагаар улс орнуудын хүн амын 2/3 нь хотуудад илүү их хуваагдаж амьдардаг, илүү их хот руу амьдардаг. Тийм болохоор хотынхоо тоог нэмэх, хотынхоо эрх зүйн байдлыг сайжруулах, төсөв, эдийн засаг, нийгэм, эдийн засгийн хувьд илүү их боломжтой болох үүднээс тухайн

үед энэ хуулийг батлуулж байсан. Тэгээд ирэх жилээс, сая гишүүдийн асууж байгаагаар асуулт ерөөсөө ирэх жилээс цаг алдахгүйгээр үүнийг хэрэгжүүлнэ биз дээ. Олон сайн зүйл, заалттай хууль баталсан шүү гэдэг дээр сая Бадамсүрэн гишүүн ач холбогдол өгч анхаарч хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Өлзийхүүгийн Шижир.

Ө.Шижир: Энэ хууль маш чухал хууль л даа. Тийм учраас тухайн үед энэ хууль өргөн баригдаж байх үедээ маш олон хот, тосгод, маш олон асуудлууд шийднэ гээд ингээд өргөн баригдаад батлагдсан. 2024 оны 6 сарын 5-ны өдөр буюу сонгуулиас өмнө Их Хурал нэг өдөр 28 хууль баталсан юм байна лээ 6 сарын 5-ны өдөр. Тэр 28 хуулийнх нь хамгийн өндөр ач холбогдлын хуулиудын нэг нь энэ байсан юм. Тэгээд харамсалтай нь ажил хариуцсан хүмүүс нь ингээд ажлаа хийгээгүйгээс шалтгаалаад хуулийн үйлчлэлийг хойшлуулах асуудал орж ирж байна. Энэ Их Хурлын түүхэнд энэ ингээд 2 дахь удаагаа орж ирлээ. Эхнийх нь Улс төрийн намын тухай хуулийг хойшлуулах байсан. Дараа нь ингээд энэ хуулийг хойшлуулах болгож орж ирж байна.

Ер нь батлагдсан, нэгэнт батлагдсан хууль тогтоомжийн хүрээнд ажиллах ёстой болохоос биш, амжихгүй байна, хуулиа хойшлуулаач гэж ингэж ажилладаг байж болохгүй. Энэ жишгийг олон удаа ингэж давтаж болохгүй. Хууль, хуулийн доор засаглаж ажилладаг болохоос хуулийг засаж, хойшлуулж ажиллаж болохгүй шүү дээ зарчмын хувьд. Тэгээд яах юм цаашдаа ингээд бүх хуулиудыг хэрэгжих хугацаа нь ингээд амжихгүй боллоо бид энэ ажлаа хийж амжсангүй та нар хойшлуулаад өгөөч гээд хууль батлаад байдаг болох юм уу? Тэгвэл энэ ЗГ гэж байгаа, ЗГ-ын харьяа түүний удирдлага доор байдаг аймаг, нийслэл, дүүрэг, сум, дүүрэг гээд ингээд байх ямар хэрэг байгаа юм? Энэ үндэслэлээс нь би Байнгын хороон дээр 2 юм асуусан, асуултаа авч чадаагүй юм. Тэгээд энэ үндэслэл хэсгээс нь үзэл баримтлал үндэслэл хэсгээс нь нэг асуучихъя. Энэ хуулийг хэрэгжүүлэхийг ЗГ-т үүрэг болгосон боловч эдгээр ажил нь орон нутагтай зөвшилцөх зэргээр тодорхой болоогүй учир гэж байгаа юм. Тэгээд ЗГ нь орон нутагтайгаа зөвшилцөх нь тийм хүнд асуудал болчихсон юм уу гэдгийг ЗГХЭГ-аас асуумаар байна?

Дараа нь энэ илтгэл дээр болон өчигдөр Байнгын хороон дээр хариулж байсан энэ ЗГХЭГ-аас дахиад асууя. Ингээд нэгэнт баталчихсан Улсын Их Хурлын тогтоолын 72 дугаар тогтоолыг энэ хуулийг хойшлуулбал Улсын Их Хурлын 72 дугаар тогтоолын уялдаа хангагдана гэж байгаа юм. Энэ үндэслэл хэсэг дээрээ шүү. Тэгээд хойшлуулж байж уялдаа хангагдана гэж яг юу ямар утга учиртай тайлбар юм бэ? ЗГХЭГ-ынхан би тэрнээс асууж байна. Тэгээд энийгээ бодит хэрэгцээ шаардлага үүссэн учраас гэж энэ 2 үндэслэлээ, тэгээд ийм үндэслэл байгаад хуулийн үйлчлэлүүдийг хойшлуулаад байж болохгүй ер нь. Тэгээд цаашдаа яах юм гээд бид энэ хуулийн хэрэгжих хугацаанд ажлаа хийж амжсангүй байна гэдэг үндэслэлээр тийм шалтаг, тайлбар тавиад энэ хуулийг хойшлуулаад өгөөч гээд хүсэлт тавиад, тэрийг нь Их Хурал хүлээж аваад байдаг болох юм уу? Ер нь би өмнө нь хэлж байсан ингээд нэг жилийн настай хуулиудыг маш ихээр баталчихлаа. Хэд хэдэн удаа. Тэгээд энэ өөрөө юу вэ гэхээр хуулийн төслийн судалгаа, тэр хуулийн төсөлд хандаж байгаа, ажилд цаг зарцуулж байгаа хувь нь хангалтгүй л байна гэсэн үг шүү дээ. Үндсэндээ судалгаагаа хангалтгүй байна л гэсэн үг. Тэгэхээр энэ нэг яг үндэслэл дээрээ бичсэн энэ 3 юман дээрээ асуулт өгөөч.

Цаашдаа дахиад яах юм бэ хурал даргалагчаа одоо бид бүр хурлаа ч хийж чадахаа болилоо шүү дээ. 3 долоо хоног дараалаад энэ чуулган дээр 5 дахийн үдээс хойшийн санал хураалтыг хийж чадсангүй шүү дээ. Дандаа хойшлуулж байна шүү дээ. Төрийн байгуулалтын байнгын хороо бүүр хуралдахаа больсон, ирц хүрэхээ больсон. Арай гэж 12, 13 хүрдэг, тэгээд хэд хэдэн удаа ч хойшлов, хурал нь хэдэн ч удаа, хэдэн цагаар хойшлов. Тэгээд ийм байдлаар энэ асуудалдаа хандаад байвал одоо энд танхим дотор байгаа 2 дахь удаагаа сонгогдсон гишүүн гэхэд ганцхан Сандаг-Очир гишүүн л байх шиг байна шүү дээ. Тэгээд 20-оод хүн сууж байна. Батлут гишүүн байна. Тийм. Иймэрхүү байдлаар бид хуулийн батлах юун дээр ингээд хандаад байх юм уу? Энэ чинь 3 долоо хоног дараалаад санал хураалт хойшиллоо шүү дээ. Булгантуяа даргаа энэ чинь 3 долоо хоног. Тэгээд ингээд суугаад, чуулганы танхимд идэвхтэй сууж байгаа нэг хэдхэн хүн байдаг болсон. Тэгээд тэд нар нь ингээд хохироод байгаа юм уу? Нөгөөдүүл нь ингээд орхиод гараад явчихдаг ирцдээ орчхоод, энэ юун дээр хэдүүлээ анхаармаар байна.

Х.Булгантуяа: Шижир гишүүн санал хэлсэн үү? Хэн хариулах юм бэ? Эхнийх нь Хэрэг эрхлэхээс.

А.Энхманлай: Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар Энхманлай. Шижир гишүүний асуултад хариулъя. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль шинээр хэрэгжихтэй холбоотой ЗГ-ын зүгээс энэ шинээр байгуулах хотуудын эдэлбэр газрыг тогтоох асуудлаар бид бүхэн орон нутгийн засаг захиргаа нартай хамтарч ажиллаж байгаа. Ингээд орон нутагт ЗГХЭГ-аас албан бичиг хүргэгдэж, эдгээр шинээр байгуулах улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны эдэлбэр газруудад ямар саналтайгаар байгуулах ийм хүсэлтэй байгаа талаар бичиг хүргүүлсэн. Ингээд мэдээж манай орон нутгуудаас холбогдох саналууд ирсэн байгаа. Аймгуудаас өнөөдрийн байдлаар 17 аймгаас саналууд ирсэн байна. 4 аймаг нь одоохондоо асуудлаа шийдэж амжаагүй ийм байдалтай байгаад байгаа юм. Тэгэхдээ ирүүлж байгаа санал маань өөрөө үндэслэл муутай ийм саналууд ирж байгаа юм.

Учир нь юу вэ гэхээр тухайн хот, тосгоны эдэлбэр газар өөрөө тухайн хот, тосгоны бүхий л төлөвлөлтийн шинж чанарыг агуулагдах эд зүйлүүдийг багтаасан ийм хэмжээнд төлөвлөгдөх ёстой, хязгаарлагдах ёстой. Ийм учраас бид бүхэн энэ хот, тосгоны эдэлбэр газрыг тогтоохдоо хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө дээр суурилж хийхгүй бол зарим нэг аймгуудын хотууд дээр хэд хэдэн сумуудыг дамжсан, өөрөөр хэлбэл Улсын Их Хурлын 72 дугаар тогтоолд ч өөрчлөлт оруулж байж асуудлыг шийдэхгүй бол болохооргүй хэмжээнд ийм зөрүүтэй саналууд ирж байгаа юм. Ийм учраас энэ аймгуудын ерөнхий төлөвлөгөөнүүдийг бүрэн заавал хийлгэж дуусгах ийм ажил байгаа. Тэгээд энэ дээр 7 аймаг одоогоор 7 хот дээр хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийгдээгүй байгаад байгаа. Тэгэхээр энэ ерөнхий төлөвлөгөөний ажлыг яаралтай зохион байгуулж хийж дуусгасны дараа ЗГ дээр Улсын Их Хурал руу эдэлбэр газар тогтоох ийм хүсэлтийг тогтоолын төслийг ингээд хүргүүлэхээр ямар ч байсан ажлын хэсгүүд ажиллаад, бэлтгэл ажлыг хангаж байгаа. Энэнээс болж удааширсан зүйл байгаа гэдгийг хэлэх нь зүйтэй.

Х.Булгантуяа: Шижир гишүүн тодруулъя.

Ө.Шижир: Тийм. Миний асуугаад байгаа асуулт аягүй тодорхой шүү дээ. ЗГ нь орон нутагтайгаа хил хязгаар тогтооход тийм хүндрэлтэй байгаа юм уу? Бид

ямар улс орны хил хязгаарыг өмнөд хөрштэй юм уу, хойд хөрштэйгөө хил хязгаараа дахиж тогтоох гээд байгаа биш. Тэгээд бичиг явуулаад араас нь ингээд уулзалт хийгдээд тийм юм явдаггүй юм уу? Энэ чинь жил гаруйн хугацаа болж байхад. Тэгээд 17 аймгийг, 17 аймагтаа ЗГ хугацаатай үүрэг даалгавар өгч болно шүү дээ. Яагаад тийм юм хийхгүй байгаа юм бэ? Тэгээд ингээд тайлбар тавиад ингээд суугаад байх бүгдээрээ? ЗГ-аас хугацаатай үүрэг даалгавар өгч болно шүү дээ ЗГХЭГ-аас. Яагаад тийм хугацаатай үүрэг даалгавар өгөөгүй юм бэ? Тэгээд аягүй тодорхой юм асуугаад, одоо энэ хуулиараа энэ 72 дугаар тогтоол чинь өөрөө огт уялдаа холбоо нь хангагдахгүй байгаа юм уу? Би та нарын бичиж өгсөн энэ үзэл баримтлал, үндэслэл дээр чинь яриад байгаа байхгүй юу. 72 дугаар тогтоолын уялдаад ингэж байж хангагдана гэж байгаа юм. Дараа нь, тэгээд энэ ЗГ нь орон нутагтайгаа зөвшилцөж чадахгүй байгаа гэж бичиж, энэ үндэслэл дээр чинь ингээд.../минут дуусав/

Х.Булгантуяа: Хэн хариулах вэ ажлын хэсэг? Эрдэнэбүрэн сайд, тэгээд араас нь Үнэнбат дарга хариулчхаарай.

Р.Эрдэнэбүрэн: Шижир гишүүний шүүмжлэлийг хүлээж авч байгаа. Гэхдээ энэ орон нутагт ялангуяа хил хязгаар тогтоох гэдэг зүйл ЗГХЭГ-аас хугацаатай үүрэг өгөнгүүт зөвшөөрчихдөг зүйл биш. Та мэдэж байгаа. Энэ орон нутгийн иргэд маань ялангуяа энэ хил хязгаартай холбоотой юман дээр сумууд дээр ч гэсэн маш айхтар маргаан гардаг. Жоохон маргаан гарангуутаа сонгогдсон Их Хурлын гишүүд рүүгээ бичдэг, ингээд л дахин, дахин асуудлууд үүсдэг. Тийм учраас энэ маргаанаас аль болохоор зайлсхийхийн тулд ерөнхий төлөвлөгөөний хил хязгаараар тогтоох гэж оролдож ингэж явж байгаа юм. Тэгээд хэд хэдэн, олон нэлээн 8 газар байгаа байх ерөнхий төлөвлөгөө батлагдаж дуусаагүй байгаа. Тэгээд энэ бол маш чухал хууль учраас маргаан гаргаж явбал.../минут дуусав/

Х.Булгантуяа: Микрофон нэмж өгье. Хариулт дээр эхлээд 3 минутаар өгчхөөч тэгэх үү? Тэгэхгүй бол 1 минутаар өгөхөөр ингээд дуусчхаад байгаа юм.

Р.Эрдэнэбүрэн: Маргаан гаргаж явбал ялангуяа Их Хурал дээр ингээд гишүүд маань янз бүрийн маргаан руу ороод ингээд явчихвал хуулийн хэрэгжилтийг хангаж байгаа хүмүүст их хүндрэлтэй байдал үүсээд, хэрэгжиж чадахгүй болох болчхов уу гэж бодож байгаа. Тийм учраас яаж хил хязгаараа тогтоох юм гэдэг дээрээ нэг ойлголттой болоод, тэгээд шаардлагатай тэр хуучин тогтоол эд нартаа өөрчлөлт оруулаад, ингээд нэг найдвартай л хэрэгжилтийг нь хангах юм руу л явах шаардлагатай болчхоод байна гэж бодож байгаа юм.

Х.Булгантуяа: Үнэнбат дарга нэмж хариулъя.

М.Үнэнбат: Шижир гишүүний асуултад хариулъя. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Улсын Их Хурлаас батлаад, энэ хуулийг хэрэгжүүлэх хэрэгжилтийг хангахын тулд 72 дугаар тогтоолыг баталсан байдаг. Тэгэхээр энэ уялдаагүй гэсэн үг биш. Энэ уялдааг нь хангахын тулд баталсан хууль 1-д.

2 дугаарт юу байна вэ гэхээр тухайн тогтоол дээр тодорхой чиг үүргүүдийг хэрэгжүүл, ороод ир гэдэг ийм үүрэг өгсөн байгаа. Тэгээд уялдаа гэдэг нь өөрөө бол нөгөө ерөнхий өргөн утгатай агуулгатай зүйл учраас саяын бид нарын яриад байгаа дагуул болон улсын зэрэглэлтэй хотуудын эдэлбэр газрын хэмжээг

тогтоох, мөн энэ хот, тосгоны эрх зүйн байдлын хуульд заасны дагуу хот, тосгоны өөрчлөн зохион байгуулахтай холбоотой байгууллагуудын бүтэц, орон тоо яаж өөрчлөгдөх юм, түүнийгээ дагаад энэ төсөв мөнгөний асуудал нь яаж шинэчлэгдэх юм эд нарыг бүгдийг нь тооцоолоод шийд гээд ингээд ийм үүргийг тодорхой 72 дугаар тогтоолоор өгсөн байгаа. Тэгэхээр энэ тогтоолыг хууль, энэ тогтоолоор өгсөн үүргийг биелүүлэхийн тулд тухайн энэ өнөөдрийн орж ирж байгаа хуулийн төсөл.../минут дуусав/

Х.Булгантуяа: Шижир гишүүн уг нь их чухал асуудал ярьж байна шүү. Энэ хуулийг хэрэгжүүлэх хугацаа та бүхэнд байсан шүү. Аймаг, орон нутагтай энэ хил хязгааруудаа тогтооход боломжтой шүү. Энэ чинь ямар бусад улс оронтой хил хязгаараа тогтоож байгаа биш. Аймаг, орон нутаг ч гэсэндээ Улсын Их Хурлаар баталсан хуулийг хэрэгжүүлэх үүрэгтэй. Улсын Их Хурлын гишүүн Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан. Шижир гишүүн нэмж тодруулах уу?

Ө.Шижир: Харин тийм. Би Булгантуяа даргаа яг наадхыг чинь хэлээд байгаа юм. Энэ чинь нэг хуульд захирагдаж, хуулийн доор ажиллах ёстой болохоос ингээд хуулийг үйлчлэлийг нь хойшлуулж ажиллаж болохгүй шүү дээ. Энэ чинь яг үндсэн зарчим нь байхгүй юу. Тэрнээс энэ хуулийн төслийг нь ерөөсөө эсэргүүцээд байгаа юм биш юм. Тэгээд дахиад асууж байгаа юм нь би энэ өөрсдийнх нь бичиж өгсөн үндэслэл, үзэл баримтлалаас л асуугаад байгаа шүү дээ. Тэгэхээр ингээд ерөөсөө хариулахгүй ингээд тодорхойгүй байгаад байгаа байхгүй юу. Тэгвэл хэдүүлээ бүх хуулийн үйлчлэл, ажлаа хийхгүй байж байгаад хуулийн заалтуудыг нь хойшлуулаад байя л даа үйлчлэхийг нь. Ийм жишиг тогтоож болохгүй шүү дээ. Энэ чинь 2 дахиа боллоо шүү дээ. Оны өмнө Улс төрийн намын тухай хуулийг хэрэгжиж эхлэхээс нь 14 хоногийн өмнө хойшлуулна гэж орж ирсэн. Тэгээд хүч түрээд л хойшлуулсан. Одоо дахиад энийг хийж байгаа байхгүй юу. Тэгээд энэ дахиад өөр ийм хуулиуд орж ирэх магадлал байгаа шүү дээ. Энэ чинь аль, аль нь ЗГ-аас орж ирж байгаа байхгүй юу. Тэгээд тэр хуулийн хугацаандаа ажлаа хийж чадаагүй хүмүүстээ хариуцлага тооцох асуудлыг ярих хэрэгтэй шүү дээ ЗГ-ын зүгээс. Тэгэхгүй тэгээд ингээд л за, за энийг ерөөсөө амжихгүй юм байна хойшлуулчихъя.

Х.Булгантуяа: Энэ хуулийг анх батлахдаа бид цаг хугацааг нь жоохон харах ёстой байсан юм шиг байгаа юм. Өнгөрсөн оны 2024 оны 6 сард батлагдаад, тэгээд Улсын Их Хурлын сонгууль гээд, орон нутгийн сонгууль гээд шинэ иргэдийн Хурал, Засаг дарга, энэ бүтэц бүрэлдэхүүн гээд. Ингээд энэний араас шууд бараг энэ хэрэгжээд батлагдаад явахаар хэтэрхий шахуу хийчихээр ингээд хуулийн хэрэгжилт хангагдаж чадахаа байчхаж байгаа юм. Тэгэхээр энэ хуулийг ер нь батлахдаа, ялангуяа энэ улс төрийн ялангуяа энэ сонгуультай жилийн цаглаврыг харж батлаагүйгээс үүдээд, хуулийн цаглаврыг оруулаагүйгээс гэвэл үүдээд ийм нөхцөл байдал үүсчих шиг боллоо. Энэ дээр нэмэлт Эрдэнэбүрэн сайд тайлбар өгөх үү? Ер нь ийм юм болсон юм шиг байна. Байнгын хороон дээр тэгж тайлбарлаж байсан. Улсын Их Хурлын гишүүн Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан.

Л.Мөнхбаясгалан: Булгантуяа гишүүн яг үнэнийг хэллээ. Монгол Ардын нам ялахын тулд энэ Хот, тосгодын эрх зүйн байдлын тухай хуулийг 24 оны 6 сард сонгуулийн өмнө уриа хашхиран баталсан. Та нөхөд баталж байхдаа он сараа харж болох байсан. Тэртээ тэргүй ЗГ шинэчлэгдэн эмхлэгдэж байгуулагдах нь тодорхой. Дараа нь орон нутгийн сонгууль. Ямар юмных нь 14 хот байгуулаад, нутгийнх нь заагийг тогтоогоод, ерөнхий төлөвлөгөөг нь хийгээд тийм юм байхгүй

шүү дээ. Хөдөө, орон нутаг очсон тойрогтоо очоод л хэдүүлээ ёстой хот болох гэж байна гоё уу гоё, намайг сонгоорой, биднийг сонгоорой, манай нам ална ингээд л сонгосон шүү дээ. Тэгээд одоо энийгээ хийж чадахгүй буцаагаад ороод ирж байгаа байхгүй юу. Тэгээд нөгөө олон долоон юм ярьж сонгож байсан гишүүд нь бүгдээрээ энэ танхимд байхгүй.

Тэгээд энэ Эрдэнэбүрэн сайд энийг танилцуулж байдаг бол дэмий шүү дээ. Энэ хүн чинь энэ удаа Их Хуралд орж ирсэн. Гэтэл өмнөх тэр хариуцаж байсан сайд нь хааччихсан юм бэ хариуцах ёстой, байхгүй байгаа байхгүй юу. Одоо дахиад худлаа болно. 26 оны 6 сарын 1 хүртэл хойшилно. Улсын Их Хурлын тогтоол нь хойшилно. 27 оны 1 сарын 1. Ерөнхийлөгчийн сонгуультай шүү дээ. Дахиад ялна гээд л хэдэн тийшээ гараад давхина, наана нь хийж барахгүй байх. Хөдөө байгаа тэр сумууд чинь хот болно гээд л, нутаг нөгөө хилийн зааг тогтооно гээд, тэгээд тэрийг нь барахгүй, тэрийг нь Их Хурал хийж өгөх юм уу? Тэгж ойлголоо би сая. Бид метр бариад явах уу эсвэл Засаг даргатай нь очиж тохиролцох юм уу?

Шижир гишүүний хэлдгээр яг үнэндээ хариуцлагын тогтолцоо огт байхгүй. Хэчнээн хуулийг сонгуульд зориулж баталчхаад одоо дахиад хойшилж байгаагаа тоолж гаргаж ирмээр л байна даа. Тухайн үед ялахын төлөө сонин, сонин юм сэдэж байсан нөхөд энэ хариуцлагаа хүлээх ёстой шүү дээ. Сая Булгантуяа дарга зөв хэлж байна шүү дээ. Бид батлахдаа он, сарыг нь харах ёстой байжээ гэж. Тэгээд энэ Их Хурлын гишүүд нэг ийм он, сар, өөрсдөөс үл шалтгаалан болдог зүйлээ харж хууль баталж баймаар байна. Нэг удаагийн сонгуульд зориулсан хуулийг дахиж энэ 126-тай парламентад баталмааргүй, босгыг нь давуулмаар ч үгүй байна. Би асуулт асуугаагүй үг хэлж байгаа шүү.

Х.Булгантуяа: Төрийн залгамж чанар гэж байх ёстой. Энэ асуудлыг одоо саяхнаас хариуцсан сайд юм чинь өмнөх асуудалд хариулт өгөхгүй гэж байж болохгүй л дээ. Тэгээд сайныг нь ч авч яваад л, саарыг нь засаад л явах чиг үүрэг бидэнд угаасаа төрийн ажил дээр бүгдээрээ байгаа. Одоо хэрэгжилтээ хангах дээр та бүхэн маань бид, ялангуяа шинэ сайд, хотын удирдлагууд өөрсдөө үүн дээр нь анхаараад явна биз дээ. Энэ тэгэхдээ улс орон даяар хэрэгжих учраас ганцхан ч хотын асуудал биш байх. Энэ чуулган дээр чинь Барилга, хот байгуулалтын сайд суух ёстой биз дээ. Улсын Их Хурлын Тамгын газраас. Энэ Барилга, хот байгуулалтын сайд баймаар байна Их Хурлын Тамгын газар. Мөнхбаясгалан гишүүн тодруулъя.

Л.Мөнхбаясгалан: 19-хөн гишүүн л хэлэлцэж байна шүү дээ энэ чухал хуулийг. Тэгээд санал хураах болохоор бүгдээрээ энд тэндээс үсэрч гарч ирээд л, хав хав гээд л кнопоо дарна. Иймэрхүү маягаар Их Хурал хуралддаг болоод удаж байна. Бид ингээд уучлаарай хуучин гишүүдийн энэ балиар юманд автмааргүй байна, зарчимтай баймаар байна. Улсын Их Хурлын гишүүдийн оролцоог хангамаар байна. Тэгээд энд 19-хөн хүн хэлэлцчихээд энийг нь сонссон, сонсоогүй орж ирж кнопдчихоод, дараа нь дахиад л хойшлуулъя барья гээд л олон долоон юм ярьж суумааргүй байна. Энэ ажил хийж байгаа хүмүүсийн чинь буруу биш л дээ, эд нар чинь хийх гээд л ядаад байдаг. 19 гишүүн хуралдаад, одоо тэгээд бусад нь орж ирж шууд кнопоо дарах юм уу, юу гэж дарах юм бол? Хойшлуулцгаая л гэнэ л дээ угаасаа. Ингэж төрийн ажил хиймээргүй байна.

Х.Булгантуяа: Мөнхбаясгалан гишүүн санал хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Дамдинсүрэнгийн Жаргалсайхан.

Д.Жаргалсайхан: Энэ Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг дэмжихгүй байгаа. Хэдүүлээ нэг тоолъё ингээд баг, сум, тосгон, ингээд аймгийн төвөө хот гэж үзэх юм уу, яах юм, тэгээд нийслэл, нийслэлийн дотор нь ингээд баахан хот, орон нутгийн чанартай хот, улсын чанартай хот, нийслэл гээд хэдүүлээ нэг баахан л юм нэмдэг. Тэгээд бүүр баахан Хотын дарга нэмсэн шинээр ингээд л хотын дарга нар, хот нь ч байгуулагдаагүй байхад ингээд баахан дарга нар. Гэтэл бидний хувьд энэ төсвөө хэмнээ, энэ сумаа ч цөөлбө гээд яриад байдаг. Яг хийж байгаа үйлдэл маань ингээд эсрэгээрээ байгаад байгаа юм. Ойлгомжтой Хот, тосгоны тухай эрх зүйн байдлын тухай хууль дээр асуудлууд ярьж байна. Аймгийн төвийн хот, хот нь ямар эрх зүйтэй байх юм. Татвараа авдаг өөрийн эрхтэй байя, бүүр ингээд цаашлаад ярьж байна л даа ингээд босоо томилгоонуудаа өөрсдөө томилдог байя гээд. Үгүй шүү дээ. Энэ чинь өөр хуультай шүү дээ гээд ингээд зөндөө асуудлууд ар араасаа гарч ирж байгаа юм.

Тэгээд өнөөдөр хэдүүлээ ингээд энэ хуулийн хэрэгжилтийг нэг жилээр хойшлуулъя гээд л ингээд яриад сууж байдаг. Энийг бол ерөөсөө хүчингүй болгох хэрэгтэй. Дүүрэг ажлаа хийж л байгаа шүү дээ, тамгаа бариад, эрх хэмжээнийхээ хүрээний бүх л асуудлаа шийдээд, шийдвэрлээд явж байгаа. Хот болгохоор сайхан болчихно гэж бодож болохгүй шүү дээ. Тэгэхээр энэ байдлаас салах ёстой. 30 хэдэн жил бид ингэж ярилаа шүү дээ. Тэгээд энийг дэмжихгүй байгаа.

Ингээд нэг татвартай холбоотой асуудал ярьж байгаа. Яг үнэн чанартаа татвар нийслэл тусдаа татвар аваад эхэлбэл бидний Татварын энэ хууль чинь яах вэ, энэ нэгдсэн төсөв чинь яах вэ гээд л бас зөндөө асуудлууд яригдаж эхэлнэ. Тэгж байтал иргэд маань юу ярьж байгаа билээ, энэ татвар чинь замбараагаа алдлаа, татвар хасна гэсэн яасан бэ, ингээд нэмээд бид сүүлдээ энэ улсынхаа нийслэлийг ч орж чадахаа байлаа гээд хөдөө, орон нутгийн иргэд маань маш их энд дургүйцэж байна шүү дээ. Тэгэхээр нэг юм өөрчилнө гээд ярихаараа татварын асуудал яригддаг. Тэгэхээр энэ хуулийг дэмжихгүй байгаа. Яг өнөөдрийн байдлаар ингээд 43 хот, 4 дагуул хот гэж хэдэн хүнтэй билээ бид. Тэгээд өнөөдөр энэ дарга, энэ хотоороо бид сайжирдаг бол сайжрахгаар л байна шүү дээ, тэгэхэд сайжрахгүй л байна шүү дээ. Тэгэхээр энэ хуулийн төслийг дэмжихгүй байгаа. Тэгээд энэ дээр та бүхэн минь хариулт өгөөч. Энэ яагаад ийм байдалд ингээд орчхов? Ийм юм болчихоор ингээд яг юу нь сайхан болчих гээд байгаа юм бэ? Тодруулна.

Х.Булгантуяа: Хотын дарга Хишгээгийн, хотын захирагч Хишгээгийн Нямбаатар дарга 4 номерын микрофон.

Х.Нямбаатар: Тийм, хэн Жаргалсайхан гишүүний асуултад хариулъя. Одоо бол зөвхөн нийслэл Улаанбаатар хот нийслэлийн иргэдийн үйлчилгээнээс 2 хүртэл хувийн татвар авч байгаа. Өөрөөр хэлбэл гаднын ирсэн жуулчид ресторан, зоогийн газраар үйлчлүүлсэн дээр нийслэл хотын татвар гэж өгч байгаа юм. Таны сонгогдсон Баянхонгор аймгийн төв хэрвээ энэ Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулиар аймгийн төв нь Баянхонгор хот болбол 1 дүгээрт хотын татвар гэдэг ийм үйлчилгээнийхээ татварыг хурааж авах эрх зүйн үндэс бүрдэнэ.

2 дугаарт та засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн чиг үүрэг, хот суурины чиг үүрэг хоёрын заагийг би түрүүн ярихад та байгаагүй байх. Юу вэ гэхээр

өнөөдөр бид 1992 оны шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойш хот суурин газрын зохион байгуулалтыг энэ 33 жилийн хугацаанд хийгээгүй. Дарга нарын хувьд давхардал үүсгэхгүй. Жишээлбэл нийслэл дээр 215 Засаг дарга байгаа хороодын Засаг дарга нар, дүүргийн Засаг дарга нар, Нийслэлийн Засаг дарга нар. Энэ бид 14 хоттой болсон тохиолдолд 204 хорооны Засаг даргыг хороог татан буулгана, нэмээд 9 дүүргийн Засаг дарга гэдэг энэ орон тоог 14 хот руу шилжүүлээд, өөрөөр хэлбэл нөгөө Засаг дарга гэдэг 210 хэдэн оронтой 14 хотын дарга болж өөрчлөгдөнө. Энэ зөвхөн нийслэлийн асуудал биш, энэ бүх сум, суурин газруудын асуудал. Суурин газрууд хот, тосгон болж шилжсэнээрээ инженер хангамжийн төв, инженер хангамжийн шугам сүлжээнд холбогдох дэд бүтцийн сангуудтай болно.

Өнөөдөр Монгол Улсын хувьд байгаа 330-аад сумаас яг төвлөрсөн инженер хангамжийн шугам сүлжээнд холбогдсон сум 30 хүрэхгүй байгаа гэж би харж байгаа. 21 аймгийн төв хагас холбогдсон байгаа. Цөөн хэдэн сумын төв ариутгах татуурга, усан хангамжтай байгаа. Бусдууд нь яг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээрээ сумын төв нь ямар нэгэн дэд бүтэц юманд холбогдоогүй байгаа. Тэгэхээр бид энийг өөрчилье. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн чиг үүргийг тэр суурин газарт нь зарим чиг үүргүүдийг нь шилжүүлье. Татвараа хурааж ав, түүнийгээ захиран зарцуул, дэд бүтцээ тат, иргэддээ хот суурин газрын үйлчилгээ үзүүл. Хог шатаах, хог цуглуулах төв хүртэл байхгүй байгаа. Энийг л шийдэх гэж энэ Хот, тосгоны хуулийн уг нь гол суурь концепц хийгдсэн юм.

Х.Булгантуяа: Жаргалсайхан гишүүн нэмж тодруулъя.

Д.Жаргалсайхан: Тийм. Та бол ингээд аж ахуйн ажил их голлож хийж байгаа байх яг тэр талаасаа ярьж байна. Миний хувьд ч гэсэн яг ийм ажил хийж байсан. Тэгээд энэ хууль хэрэгжсэнээрээ л сум инженерийн дэд бүтэцтэй болоод л, юу гэдэг юм аймгийн төв 2 хувийн татвар аваад ингээд хөгжөөд л ингээд явчихна гэж би бодохгүй байна л даа. Тийм. Үнэхээр бидний хувьд өөр өөрчлөлт шинэчлэлтүүдийг хийх бол үнэхээр шаардлагатай байгаа. Нэр өөрчлөхгүйгээр, нэр өөрчлөхгүйгээр, нэр нэмэхгүйгээр. Үнэхээр таны тэр ярьж байгаа бол тийм тэр хороодын 200 хорооны даргыг солино, байхгүй болгоно. Энэ бол өөрчлөлт байж магадгүй шүү. Үнэхээр яг ийм олон тооны төрийн албаныхан орон тоог цөөлж, тэрнээс гарч байгаа зардлаа энэ дэд бүтэц рүү оруулах бол харин зөв байх магадлалтай шүү. Тэгээд энэ тал дээр би дэмжиж байна. Тийм. Тэрнээс биш юу гэдэг юм би хөдөө орон нутаг сумд 2 хувийн татвар аваад ингээд л дэд бүтэц хөгжөөд л янзын сайхан.../минут дуусав/

Х.Булгантуяа: Жаргалсайхан гишүүн санал хэлэх шиг боллоо. Саяных бол Жаргалсайхан гишүүн. Жаргалсайхан гишүүн өөрөө аймгийн Засаг даргаар ажиллаж байсан хүний хувьд улсын төсвийн хөрөнгө оруулалтыг хүлээгээд л дэд бүтцээ татах гээд, орлогоо бүрдүүлэх гээд, иргэдийнхээ амьдралыг сайжруулах гээд ингээд хүлээгээд сууна гэдэг бол их цаг хугацаа ордог. Төдийгөөс өдий болтол яваад манай ихэнх аймгууд ямархуу байдалтай байгааг та сайн мэдэж байгаа байх. Тэгээд үүгээр дамжуулж түрүүн Нямбаатар дарга хэлэхдээ аймаг, орон нутаг өөрөө өөрсдөө орлогоо бүрдүүлдэг, түүгээрээ дамжуулаад тэр битгий хэл яваа яваандаа бонд хүртэл гаргаж, зарим шаардлагатай хөрөнгө оруулалт, дэд бүтцүүдээ шийддэг энэ эрх зүйн байдлыг нь үүгээр уг нь дамжуулж бий болгох гэж байгаа гэж л бид өнгөрсөн парламентад энэ хуулийг баталж, дэмжсэн юм байгаа юм. Манай Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир. Ашгүй Батсуурь сайд ороод ирлээ.

Ц.Сандаг-Очир: Яг энэ Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль батлагдсантай холбогдуулж энэ асуудлыг яг харьяалах салбар аль яаманд харьяалах юм бэ? Эрдэнэбүрэн сайд яг энэ асуудлыг хариулах асуудлыг хариуцаж байгаа сайд мөн үү, үгүй юу? Таныг би Улаанбаатар хотыг энэ 20 минутын дотор бүх үйлчилгээг авдаг байх энэ төлөвлөлтийг хийдэг сайд гэж ойлгосон шүү дээ. Тэгтэл энэ асуудал чинь өөрөө улсын хэмжээний хот, тосгоны эрх зүйн байдлын асуудлыг яриад, Дархан, Эрдэнэт, Сэлэнгэ, Булганы асуудлыг яриад ингээд яваад байх юм. Тэгээд яг ЗГ хариуцна гэхээр яг ЗГ-аас аль яам нь яг энэ асуудлыг хариуцаж явах юм бэ? Барилга, хот байгуулалтын яам хариуцах юм уу?

Өнгөрсөн хугацаанд хууль батлагдсанаас хойш та бүхэн үндсэндээ жил болох гэж байна сайд нар болоод. Яг энэ хуулийг хэрэгжүүлэх хүрээнд юу хийсэн юм бэ, ямар арга хэмжээ авсан юм бэ, хэдэн удаагийн уулзалт хийсэн юм бэ орон нутагт? Эрдэнэбүрэн дарга Дархан, Булган дээр, Сэлэнгэ дээр, Эрдэнэт дээр хэдэн удаа очиж уулзалт хийсэн юм бэ? Тэгээд хэн нь зөвшөөрөхгүй байгаа юм бэ, яагаад ойлголцохгүй байгаа юм бэ? Би юу гэх гээд байна гэхээр бэлтгэл ажил хангагдаагүй учраас нэг жил хойшлуулаад өгөөч гэх гээд байна гэж байгаа нь өөрөө шалтаг байна. ЗГ зүгээр энэ хуулийнхаа үндэслэл, шаардлагыг үнэнээр нь биччихээч ядаж. Ажил хийгээгүй юм гэдгээ. Сонгуулийн дараа бүгд сайхан, сайхан сайд болоод явсан, ялалтдаа бялуураад энэ хуулийг хэрэгжүүлэх талаар огт ч гар хөдөлгөөгүй гэдгээ л хүлээн зөвшөөрчих. Ажил хийгээгүй байхгүй юу. Үнэн шүү дээ.

Тэгчхээд өнөөдөр гэв гэнэтхэн хуулийн хугацаа болчихлоо хойшлуулж өг гээд. Тэр Шижир гишүүний шүүмжлээд байгаатай би санал 100 хувь байна. Өнөөдрөөс сэрсэн юм шиг гэв гэнэт хуулийн хугацаа тулчихаар хойшлуулаад өг гээд ийм жишиг тогтоож болохгүй шүү дээ. Тэгвэл энэ засаглал юу хийх ёстой юм бэ, Их Хурал тэгвэл хууль батлаад яах юм бэ? Баталсан хуулийг нь засаглал нь хэрэгжүүлэхгүй юм бол хугацаа тавьж яах юм бэ? Их Хурлын баталсан хуулийг буруу, зөвийг нь шийддэг газар ЗГ биш шүү дээ. Үг дуугүй хэрэгжүүлэх ёстой шүү дээ. Үндсэн хуулийн зөрчил байгаа бол тэр Үндсэн хуулийн цэцдээ л хандах ёстой шүү дээ. Өөр зөрчил байхгүй бол тэгээд ажлыг хийх л ёстой шүү дээ. Тэгчхээд өнөөдөр ингээд явж, явж яг энэ хууль чинь Булган, Эрдэнэт, Дархан, Сэлэнгээс л болж байгаа шүү дээ. Газар нутаггүй байдлаас болоод.

Гэтэл энэний цаана 90 оноос хойш 30 гаруй жил хот болж бие дааж хөгжихийг хүсэж байгаа Налайх, Багануур гээд дүүргүүд байж байгаа шүү дээ. Ямар ч газрын маргаангүй, асуудалгүй энэ хуулийг хэрэгжүүлээд явах бололцоотой орон нутгууд байж байгаа шүү дээ. Хот болоод явъя гэсэн аймгийн төвүүд байж байгаа шүү дээ. Ядаж та бүхэн ярьдаг биз дээ энд орон нутгийн томилгоонууд нь ядаж өөрөө өөртөө босоо болоод, өөрөө өөртөө орон нутгийнхаа томилгоог хийдэг больё гээд л бүгд ярьдаг биз дээ. Хэрвээ хот болж чадвал бид энэ томилгоонуудаа орон нутагтаа хийх хэрэгтэй. Өмчөө өөрсдөө захиран зарцуулах хэрэгтэй. Төсөв санхүүгээ өөрсдөө хариуцаад явах бололцоо боломжууд, үүд хаалганууд нээгдэх ёстой шүү дээ. Хот болоод хөгжихийн давуу тал нь.

Энийг чинь харчхаад энэ Налайх, Багануур дүүргүүд бушуухан энэ хуулийг хэрэгжүүлээсэй гээд хүсэн хүлээж байгаа 50 мянган сонгогч, 80 мянган иргэд хүлээж байгаа байхгүй юу. Гэтэл энэ 4 аймгийн ард иргэдийн газар маргаантай

асуудлаас болоод өнөөдөр энэ хуулийг хойшлуулж өгөөч гээд хуруу хумсаа ч хөдөлгөөгүй байж ингээд энэ хуулийг хэрэгжүүлэх хугацааг хойшлуулах гээд байна. Тэгээд 1 жил бэлтгэл ажлыг нь хангаж чадаагүй байж, дахиад нэг жил, нэг жилийн дараа хойшлуулаад орж ирж чадах юм уу, бэлтгэл ажлыг нь хангаж чадах юм уу? Энэ дээр нэг хариулт өгөөч.

Х.Булгантуяа: Хэн хариулах вэ? Эрдэнэбүрэн сайд хариулъя.

Р.Эрдэнэбүрэн: Энэ ажлын хэрэгжилтийг яг энэ хил хязгаарыг тогтоох, эдэлбэр газрыг нь тогтоох хотуудын энэ ажлыг ЗГ-ын Хэрэг эрхлэх дээр хариуцаж явж байгаа. Энэ хуулийг уг нь хэлэлцүүлэх ажлын хэсгийн ахлагч нь Хэрэг эрхлэхийн дарга байсан. Тэгээд өөрөө гадаадад эзгүй байгаа учраас би төлөөлөөд Байнгын хороо, Их Хурал дээр энэ төслийг танилцуулаад ингээд явж байгаа гэдгийг хэлмээр байна.

Ер нь яах вэ 2, 3, 3 үндсэн шалтгаан байна гэж хэлж байгаа юм. 1 дүгээрт цаг хугацааны хувьд 2 сонгууль тулчихсан, 2 сонгууль Их Хурал, орон нутгийн сонгууль дамжчихлаа. Энэ нөгөө эдэлбэр газарт газартай холбоотой маргаан, хүсэлт бүх юмыг чинь орон нутагт иргэдийн Хурал өөрсдөө шийдэж явж байгаа. 2-т нь би сая Байнгын хорооны хурал дээр хэлээд, гишүүдээс нэлээн шүүмжлэл авсан байгаа. Нэлээн олон гишүүд бол хэвлэл мэдээллийн хэрэгслээр ч хэлж байгаа. Энэ хууль Үндсэн хууль зөрчсөн, нийцэхгүй гээд ойлголтын зөрөөтэй байгаа юм болов уу гэхээр, саналын зөрөөтэй байгаад байгаа юм. Ийм байдлаар энэ хуулийг хэрэгжүүлэх гэж зүтгэвэл хэрэгжүүлж байгаа улсууддаа үнэхээр хүндрэл учирна. Ялангуяа орон нутгаас сонгогдсон гишүүд өөрсдөө гарч ирээд энэ болохгүй гээд байвал энэ чинь орон нутаг дээр хэрэгжих боломж хэцүү шүү дээ. Тэгээд сүүлийн үндсэндээ 4, 5 сар л манай энэ Хэрэг эрхлэхийнхэн, газрын харилцааныхан энэ эдэлбэр газрын хил хязгаарыг тогтоох дээр ажиллах тийм цаг хугацаа олдсон гэж бодож байгаа. Цаашдаа маш хурдацтай энэ ойлголтоо нэгтгэх, тэгээд ялангуяа тэр ерөнхий төлөвлөгөөгүй байгаа газруудаа маш хурдан хугацаанд ерөнхий төлөвлөгөөтэй болгох чиглэлээр ажиллаад явах ёстой байх гэж бодож байна.

Улаанбаатар хотын хувьд Нямбаатар дарга ч нэмээд хэлэх байх. Одоо Их Хурал дээр явж байгаа 2040-өө нэлээн харж байгаа. Энэ 2040-ийнхөө төлөвлөлттэйгөө уялдуулж явах ёстой гэж бодож байгаа.

Х.Булгантуяа: Сандаг-Очир гишүүн тодруулъя.

Ц.Сандаг-Очир: Би асуугаад байна шүү дээ ЗГ хэдэн удаа энэ чиглэлээр өнгөрсөн нэг жилийн хугацаанд уулзалт Дархан дээр очиж, Дарханы Засаг дарга, Хуралтай, Эрдэнэт дээр очиж Эрдэнэтийн хурал, Засагтай уулзсан юм бэ гэж. Ажил хийгээгүй, хийсэн юм уу, хийгээгүй юм уу? Үнэхээр энэ 4 аймаг чинь бие дааж хөгжихийг хүсэхгүй, газар нутгийнхаа маргаанаас болоод ингээд байгаа бол тэр маргаантай байгаа аймаг, орон нутгуудаа үлдээчих л дээ, үлдээчих л дээ. Тэгээд боломжтой газрууд дээр нь хуулиа хэрэгжүүлээд явъя л даа. Хот болгоод бие даасан байдлаар хөгжүүлээд явъя гээд ингээд Их Хурал хууль батлаад байхад орон нутгууд нь өөрсдөө том толгой гаргаж, газар нутгийн маргааны асуудлаа шийдэж чадахгүй байгаа бол энэ асуудлыг нь орхиод явах хэрэгтэй шүү дээ.

Х.Булгантуяа: Хэрэг эрхлэхийн, ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын дарга Саруул дарга хариулах уу? Зоригтбаатар Бүс, орон нутгийн удирдлага зохицуулалтын газрын дарга. 4 номерын микрофон. Хэдэн удаагийн уулзалт хийсэн бэ? 4 номерын микрофон асчихсан шүү.

А.Энхманлай: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой ажлын хэсгийн зүгээс бид бүхэн аймгийн удирдлагуудтай мэдээж албан бичиг хүргүүлж, уулзаж, холбож ярилцсан байгаа. Орон нутгуудад очиж ажиллаж байсан. Ингээд ер нь энэ эдэлбэр газар тогтооход заавал аймаг, орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санал зайлшгүй шаардлагатай. Тэгэхээр энэхүү саналыг авах асуудлаар ЗГ өөрөө иргэдийн Хурлын бүрэн эрхэд нөлөөлж үүрэг чиглэл өгч, хугацаа зааж ингэж авах бололцоогүй байгаад байгаа юм. Тийм учраас аймгийн иргэдийн Хурлууд маань саяын нэр дурдсан зөвхөн Эрдэнэт, Дархан биш, өөр хэд хэдэн аймгууд дээр ийм газартай холбоотой маргаантай асуудал байгаа юм эдэлбэр газар тогтоохтой холбоотой. Жишээлбэл Төв аймаг дээр байна. Ер нь манай энэ аймгуудын төвийн сумдын газар нутгийн хил зааг маш бага хэмжээтэй тогтоогдсон. Тийм учраас энэ төвийн сум дээр ойролцоогоор 100 орчим мянган хүн амтай ийм хот суурин үүсэж байгуулагдаж явж байгаа учраас эдгээрийн суурьшлын бүс бусад хил залгаа сумууд руу тэлэх ийм нөхцөл байдал үүссэн.

Тэгээд 72 дугаар тогтоолоор зарим нэг аймгууд дээр 3 сумыг дамнуулж эдэлбэр газрыг тогтоох хүртэл ийм шийдвэр гарсан байгаа. Мөн 72 дугаар тогтоолд заагаагүй хэр нь эдэлбэр газар нь буюу газар ашиглалт нь өөр аймгийн сум руу хүртэл ороод явчихсан тийм газар ашиглалттай, төлөвлөлттэй ийм аймгууд байна. Жишээлбэл Дархан-Уул аймгийн төв Сэлэнгэ аймгийн.../минут дуусав/

Х.Булгантуяа: Энхманлай даргаа яг хэдэн удаагийн уулзалт, хэдэн аймагтай хийсэн бэ гэж асуугаад байх шиг байна Сандаг-Очир гишүүн.

А.Энхманлай: Бид хэд, бид ер нь одоогоор 17 аймгаас санал ирсэн. 17 аймагтай холбогдож, бүрэн 21 аймагтай ажиллаж байсан. Тэгээд 17 аймгаас санал ирчихсэн байгаа. Газар дээр нь очиж 10 гаруй аймгуудтай бол ажилласан. Очиж ажиллаж энэ ажлаа танилцуулж ингэж ажилласан байгаа.

Х.Булгантуяа: Ганбатын Очирбат гишүүн асуулт асууна.

Г.Очирбат: Өдрийн мэнд хүргэе. Ер нь ингээд энэ хууль тогтоомжийн хэрэгжилтийн нөлөөллийн судалгаа гэдэг юмыг ер нь хийхгүй бол болохоо больчихоод байна. Өнөө өглөөхөн бид ингээд нэг жилийн өмнө баталсан хуулийг оруулж ирээд 2 тал болоод л үзлээ. Яг үдээс хойш нь дахиад л нэг сонгуульд зориулаад 2024 оны 6 сарын өдөр яаралтайгаар асар олон хэмжээний хуулиуд оруулж ирээд баталсан. Мэдээж тухайн үед хууль батлахад үндэслэлтэй, судалгаатай, тооцоотой гээд л оруулж ирсэн. Тэгээд хэрэгжилт нь ингээд жилийн дараа байхгүй, энийгээ сунгаж өгөөч гээд ороод ирдэг. Цаашдаа ийм байдалтай байвал ер нь энэ Улсын Их Хурлаас энэ гаргаж байгаа хууль санаачлаад тэр нь хэрэгжээд явах ийм боломж бололцоо байна уу, байхгүй юу?

Тэгэхээр уг нь энэ ЗГХЭГ-ын дарга байсан асуух гэж байсан юм. Энэ ажлыг хариуцаад, миний өрөөний хажууд тэр хурлын өрөөнд зунжингаа л хуралдаад

байсан юм даа. Тэгээд баахан хүн ирээд л хуралтай байна, хуралтай байна гээд л өрөөгөөр ороод ус уугаад л, кофе уугаад л яваад байсан юм. Тэгээд хурлынх нь үр дүн хаана байгаа юм байхгүй. Би бүүр бодитой жишээ ярина шүү. Яг манай хажуу талын өрөөнд л хуралдаад байсан. Тэгээд ямар ч үр дүн байхгүй. Тэгээд хотын дарга ирсэн байна өнөөдөр талархууштай. Та энэ дээр аягүй тодорхой манлайлж явж байсан хүн. Баахан хүн хуралдуулаад л байсан. Тэгээд яагаад энэ хуулийн төслөө нэг жилээр хойшлуулъя гэж оруулж ирээд байгаа юм бэ? Энийгээ үндэслэлтэй нэг сайхан тайлбарлаад өгчихмөөр байх юм.

Тэгээд 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр энэ Дархан, Эрдэнэт болон бусад аймгийн төвүүд энэ орон нутгийн хотуудын асуудлыг шийдэх ёстой байсан. Энэ Үндсэн хуулийн хэрэгжилт яагаад хэрэгжихгүй байна вэ? Тэн дээр хэн хариулах вэ? Хариулах хүн ерөөсөө ингээд байхгүй болчихоод байдаг. Ер нь цаашдаа хууль тогтоомжууд чинь энэ чиглэлээр яриад байвал тэгээд юу гэж ойлгох юм бэ? Иргэд ч гэсэн үнэхээр гайхаж байна шүү дээ. Их Хурал дээрээс энэ 72 дугаар тогтоол ингээд гарч ирээд нэлээн тийм бүүр ингээд хотуудын нэртэй нь ингээд сайхан гараад ирсэн. Энэ тогтоолын хэрэгжилт гэж бас юу ч байхгүй. Тэгээд бүгдийг нь нэг жилээр хойшлуулъя гээд ороод ирдэг. Энэ бүүр нээрээ бүүр инээд болж байна. Нямбаатар даргаа та хотын дарга хийж байгаа хүн. Тэгээд цаашдаа энэ Улаанбаатар хот чинь ер нь яах юм бэ 1-д?

2-т гэвэл бас нэг таныг байгаа дээр асуулт асуучихъя гэж бодоод байгаа юм. Энэ Сэлбэ дэд төвийн бүтээн байгуулалттай холбоотой асуудал байна. Бараг 1 их наяд төгрөгийг ингээд 2-хон гадаадын компанид ингээд өгчихсөн. Монголын барилгын салбар энэ металлын металл хийц хийдэг, бусад энэ барилгын дэд юмнуудыг үйлдвэрлэдэг үйлдвэрлэгчид, барилгын холбоод эд нар ингээд санал гаргаад байдаг, тан руу их гаргасан л юм гэсэн. Их Хурлын гишүүд рүү бүгд рүү нь л бичиг явуулсан. Их Хурлын Тамгын газар луу, бүх газар луу л явсан байх. Тэгээд яагаад энэ зөвхөн 2-хон компанид энэ асар их хэмжээний нэг нь энэ 373 тэрбум төгрөгийн тендерийг сонгон шалгаруулалт хийчихсэн, нөгөөдөх нь энэ 450 тэрбум төгрөг. Тэгээд БНХАУ-ын 2 компани шалгарчихсан.

Тэгээд Бүлгийн хурал дээр танай орлогч дарга Даваадалай ирээд танилцуулж байгаа хөөрхий амьтан. Та яах вэ гадаадад томилолттой байсан. Танилцуулаад бид бол энэ дотоодын үйлдвэрлэгч нараа, дотоодын аж ахуйн нэгжээ 20 хувь дээрээ л дэмжинэ гээд байдаг. Үгүй ээ яагаад бид энэ чинь Монгол хүмүүс, Монголынхоо газар нутаг дээр, нийслэл хотынхоо бүтээн байгуулалтад Монгол компаниуд оролцож болохгүй юм бэ Нямбаатар даргаа? Та энэ дээр нэг тодорхой хариулт хэлээд өгчхөөч. Олон компаниуд танд санал гаргасан гэсэн. Барилгын холбоод хүртэл санал гаргасан гэсэн. Тэгээд байгаа дээр чинь нэг асуучихъя гэсэн юм. Ингээд 3 асуулт асуучихмаар байна. Их Хурлын Тамгын газар энэ хуульдаа хууль, эрх зүйн нөлөөллийн судалгаа хийх юм уу, хийхгүй юм уу? Цаашдаа хууль хэрэгжихгүй бол яах юм бэ? ЗГ-аас.../минут дуусав/

Х.Булгантуяа: Очирбат гишүүний асуултад хэн хариулах вэ? 4 номерын микрофон. Хотын захирагч Нямбаатар дарга.

Х.Нямбаатар: Би сүүлийнхээс нь хариулъя. Та нөгөө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн шалгуур гэж зүйл байдаг юм. Тэр хуульд сүүлийн 3 жилийн орлогын 30-аас 50 хувиар дундчилж борлуулалтын хувь хэмжээг тавь гэдэг ийм шаардлага тавьчихсан.

Тэгээд бид Хятад компани шалгаруулъя гэдэг ерөөсөө хууль дээр тийм зохицуулалт тохируулга хийж орж ирээгүй. Бид 4 багц хувааж байгаа. 4 багцаа багц тус бүр дээр тухайн компанийн сүүлийн 3 жилийн борлуулалтын дундаж орлогын 30 хувь болгож бид босго л тавьж байгаа. Ерөөсөө л тавьсан зүйл. Энэ нь өөрөө Тендерийн хуульд тавигдсан өнөөдрийн байгаа хэрэгжиж байгаа заалт 1. 2 дугаарт багц тус бүр дээр 10 хэдэн компаниуд орж ирсэн. Шалгаруулалтыг нээлттэй сонгон шалгаруулалт хийсэн. Ямар нэгэн нууц тушаал шууд гэрээгээр хийгдээгүй гэдгийг хэлье.

2 дугаарт бид Тендерийн тухай хуульд одоогийн хүчин төгөлдөр хуулиар түншлэл болон туслангийн хувь хэмжээг заачихсан байгаа. Бид мөн түншлэлийг 20 хувь, туслан гүйцэтгэгчийг 20-оос доош хувь гэсэн ийм байдлаар бүх боломжуудыг зэрэг нээж оруулсан. Та өөрөө бизнес хийдэг хүн. Яг өнөөдрийн байдлаар манай хөдөлмөрийн зах зээл, барилгын салбарт ажиллах хүчний хомсдол байгаа гэдгийг маш сайн ойлгож байгаа. Уг нь бид энэ зүйлийг гэтлэн давах гээд гаднаас ажиллах хүч авах хуулийн төслийг энэ хавар оруулсан боловч харамсалтай нь Их Хурлын босго даваагүй унасан. Таныг ажлын хэсэг ахлаад энийг шалгаж өгнө үү. Энэ тендерийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу явагдаж байгаа юу, үгүй юү гэдэг дээр ажлын хэсэг гаргаж Их Хурлаар нээлттэй сонсгол, шалгалт явуулахад бид хамтарч ажиллахад бэлэн байна гэдэг нэг хариулт өгье.

2 дахь. Та хотын даргын, би бол хотын даргын хувьд хотын даргын л ажил хариулна. ЗГХЭГ яг энэ Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангахтай холбогдуулан ажил зохион байгуулах үүрэгтэй. Энэ хууль яагаад хэрэгжээгүй вэ 1 дүгээр шалтгаан нь хот, тосгоны хилийн эдэлбэр газрын хилийн заагийг тогтоох Их Хурлын тогтоол батлагдаагүй байгаа учраас энэ хуулийг шууд хэрэгжүүлэх боломжгүй байгаа гэдгийг 1 дүгээрт хэлье. Өнгөрсөн жил бид 5 сард анх энэ хуулийн төслийг оруулахдаа Улсын Их Хурлын тогтоолын хавсралтаар энэ байгуулагдах 40 гаруй хот, тосгоны хилийн зааг, нэршлийг тогтоолын төсөлтэй хамт оруулсан боловч эргэлтийн цэгийг оруулж ирээгүй байна гэдэг шалтгаанаар дараа Их Хурлаар хил, эдэлбэр газрын заагийг тогтоох нь зүйтэй гэдэг ийм тогтоол гараад, саяын таны уншдаг тэр 72 дугаар тогтоол батлагдсан. Бид Эрүүл мэндийн яам, Цагдаагийн ерөнхий газар, Боловсролын яам, Соёлын.../минут дуусав/

Х.Булгантуяа: Нямбаатар даргын микрофоныг нэмж өгье.

Х.Нямбаатар: Хамтраад 20 минутын хот, 14 хотынхоо саяын хүртээмжийг бий болгох чиглэлээр суурь судалгаануудаа бүгдийг нь хийсэн. Нийслэлийн зүгээс эргэлтийн цэгүүдээ гаргаад, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байгаа. Бусдыг нь Хэрэг эрхлэх газраас хариулах нь зөв байх. Тэр Эрдэнэт, Дархантай холбоотой асуудал дээр би хариулах нь зохимжгүй. Энэ уг нь 19 онд Үндсэн хуулийн өөрчлөлтөөр Эрдэнэт, Дарханыг хот болгоё гээд Үндсэн хуульд бүүр тусдаа заалттай байгаа. Энэ асуудлыг би Хэрэг эрхлэхээс хариулах нь зөв байх гэж бодож байна.

Х.Булгантуяа: Хэрэг эрхлэхээс Саруул дарга хариулах уу? ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын дарга Саруул, 4 номерын микрофон.

Д.Саруул: Нэмэлт хариулт өгье. ЗГХЭГ-аас болохоор ялангуяа нөгөө хот, тосгоны эдэлбэр газрыг тогтоохтой холбоотой асуудлаар ажлын хэсэг байгуулагдаад ажиллаад, орон нутгууддаа болохоор эхний байдлаар тухайн тэр оршин байгаа нутаг дэвсгэрийн хэмжээгээр эдэлбэр газрыг тогтоох саналыг хүргүүлээд ажиллаж байгаа боловч орон нутгаас ирж байгаа саналууд нь өөрөө тодорхой хэмжээгээр тэр хэмжээг багасгасан ийм саналууд ирж байгаа учраас хэлэлцэх асуудал явж байгаа. Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Газрын тухай хуулиар энэ хот, тосгоны эдэлбэр газрыг хэмжээг тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоох ийм эрх хэмжээтэй байдаг. Тийм учраас эхний ээлжид маргаангүйгээр эдэлбэр газрынхаа хэмжээг тогтоогоод, тэгээд орон нутгийн хурлаар батлуулах ажил явна. Тийм учраас энэ дээр уулзалт явж байгаа 1.

2 дахь нь болохоор тодорхой зарим нэг хот, тосгоны эдэлбэр газрууд маань зөвхөн тэр нөгөө нэг аймгийн ч гэдэг юм уу, нэг сумын ийм нутаг дэвсгэрийг хамаарах биш хэд хэдэн аймгийн болон хэд хэдэн сумын нутаг дэвсгэрийг дамнаж ингэж оршиж байгаа эдэлбэр газар тогтоогдох ийм байгаа учраас энэ дээр зөвхөн нөгөө харьяалагдаж байгаа аймаг, нийслэл нь гэлгүйгээр нэг хотын эдэлбэр газрын хэмжээг тогтооход 2-оос 3 аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар ч юм уу энийг хэлэлцүүлэх гэсэн ийм нэлээн тийм цаг хугацаа болон шат дараалалтай ийм ажлууд хийгдэх байгаа учраас энэ дээр ийм ажлын хэсэг маань нэлээн хугацаа гаргаж ажиллаж байгаа, ийм зохицуулалтууд байж байгаа.

Х.Булгантуяа: Очирбат гишүүн нэмж тодруулъя.

Г.Очирбат: Нямбаатар даргаа энэ нөгөө 4 багц гээд байгаа юм. 4 багц юм уу, 5 багц юм уу? Миний авч байгаа мэдээллээр 5 багц гээд байгаа юм. 158 га газрыг чөлөөлсөн. Энэ дээр ажлын хэсэг дээр чинь нэг энийгээ 10 хуваачихъя, нэг бол 15 хуваачихъя багасгаад, тэгээд дотоодын ААН-үүдээ оруулчихъя гээд танд шаардлагыг тавьсан юм байна лээ шүү дээ. Та явсаар байгаад үгүй ээ гээд 4, 5-хан багц болгож оруулж ирээд Монголын ААН-үүдийн босго давахгүй байх боломжийг та хийчихсэн юм биш үү? Ажлын хэсэгт байсан гишүүд чинь надтай уулзаад ярьж байна шүү дээ. Та энийгээ нэг хариулчих л даа. Үнэхээр та аж ахуйн нэгжүүд дэмжихгүй бол дэмжихгүй байгаа, ажил хийж чаддаггүй юм энэ Монголчууд гэдгийг нь үнэнээр нь хэл л дээ. Чаддаг бол чадаж байгаа бид дэмжинэ гээд явъя л даа. Ер нь энэ чинь аль ч том бүтээн байгуулалтад аль ч улс үндэснийхээ компаниудаа дэмжиж явдаг биз дээ. Тэгж байж энэ улс эх орны чинь хөгжил, цаашаа ажилтан алба.../минут дуусав/

Х.Булгантуяа: 4 номерын микрофон, хотын захирагч Нямбаатар.

Х.Нямбаатар: Их Хурлын гишүүн гэхээрээ камер, микрофон аваад хүн гүжирдэж, гүтгэж, үндэслэлгүй баримт ярихгүй. Ажлын хэсэг дээр надад ямар нэгэн тийм шаардлага тавьсан зүйл байхгүй. 2 дугаарт энэ өөрөө ансамбльтай босох хот гэдэг утгаараа 6 багц ажил байгаа. 4 орон сууцын багц байгаа. 1 багц нь гадна тохижилтын багц байгаа, 1 багц нь гадна инженерийн шугам сүлжээний багц байгаа 1 дүгээрт.

2 дугаарт би энэ тендерийг зарлахаас өмнө Монголын барилгын салбарын үйлдвэрлэл эрхлэгчидтэй 2 удаагийн уулзалт хийсэн. Нэг нь Хүүхдийн ордонд хийсэн, нэг нь Соёлын төв өргөөнд хийсэн санаж байна. 2-т нь Монгол Улсад

цемент үйлдвэрлэдэг ААН-үүдтэй уулзсан, арматур үйлдвэрлэдэг ААН-үүдтэй бүгдэд нь энэ асуудал.../минут дуусав/

Х.Булгантуяа: 4 номерын микрофоныг нэмж өгье. Нямбаатар дарга.

Х.Нямбаатар: Тэгэхээр бид аль болох дотооддоо ашиг, орлого үлдээсэй гэдэг энэ зорилгоор л ажиллаж байгаа юм. Харамсалтай нь арматур, цемент үйлдвэрлэдэг бүх компаниуд ямар хариулт өгсөн гэхээр бид энэ том бүтээн байгуулалтад бэлэн биш байна. 1 дүгээрт тээвэр логистик, 2 дугаарт ажиллах хүч, 3 дугаарт эрчим хүчний хязгаарлалт гэдэг энэ зүйлээр бид энэ том бүтээн байгуулалтуудаас ашиг шим хүртэх нь бага байна л гэдэг зүйл яригдаж байгаа юм. Тийм учраас бид энэ том бүтээн байгуулалтуудыг хийхийн тулд адаглаад Замын-Үүд Улаанбаатарынхаа замыг өргөсгөх, ачаа нэвтрүүлэх чадвараа нэмэгдүүлэх 1 дүгээрт шаардлагатай байна. 2 дугаарт цемент үйлдвэрлэдэг ААН-үүдээ тогны хязгаарлалтгүй ажиллуулдаг болгомоор байна. 3 дугаарт ажиллах хүчийг нь хангалттай бий болгосон хууль, эрх зүйн орчныг бий болгох эд нар, бид бүх суурь судалгаануудаа хийгдээд яг энэ дарааллаар явж байгаа гэдгийг хэлье. Инженерийн шугам сүлжээг дотоодын.../минут дуусав/

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Батын Батбаатар байхгүй байна. Улсын Их Хурлын гишүүн Отгоны Саранчулуун.

О.Саранчулуун: 1 асуулт байна. Шинээр 10 хоттой болно уу, 20 хоттой болно уу хамаагүй. Яг одоогийн хотод амьдарч байгаа хэдэн хүмүүсийнхээ өмнөөс энэ дараах 6 асуултыг яг асууж тодруулмаар байгаа юм. Ер нь энэ шинэ хоттой болсноороо шинээр зохицуулалттай болсноороо саадгүй орчин хэдэн хувь нэмэгдэх вэ? Эрүүл мэндийн хүртээмж, барилга саадгүй байдал нь тэр хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд, тусгай хэрэгцээт хүмүүст үзүүлэх үйлчилгээ хэр нэмэгдэх вэ? Тусгай хэрэгцээт боловсрол орчин хэдэн хувь нэмэгдэх вэ? Мэдээлэл харилцаа холбоо нь хэр хурдан болох вэ? Нийгмийн оролцоо, соёл амралтын хувьд ялангуяа олон нийтийн энэ арга хэмжээ, номын сан, театр, соёлын төв гэх мэт энэ олон нийт зорчдог газруудын саадгүй байдал хэдэн хувиар нэмэгдэх вэ, дээшлэх вэ? Хууль, эрх зүйн хувьд гомдол гаргах, олон хоттой болсноор хүмүүс олон газар гомдлоо өгдөг ийм хүртээмжтэй болох юм уу? Энийг ер нь яаж сайжруулах юм бэ? Иргэний оролцоогоо сайжруулах тал дээр энэ шинэ хуулиар ямар ахицыг авчрах юм бэ гэдэг энэ 6 зүйл дээр мэдээлэл өгөөч. Баярлалаа.

Х.Булгантуяа: Хэн хариулах юм бэ? Эрдэнэбүрэн сайд. Эрдэнэбүрэн сайд хариулъя.

Р.Эрдэнэбүрэн: Энэ хууль хэрэгжиж эхэлснээр саяын таны дурдсан 6 зүйлийг л сайжруулахад гол тийм чухал хууль юм байгаа юм. Яагаад гэхлээр бид энэ ялангуяа жишээлбэл Улаанбаатарт 14 хот болгож ингэж задалж өгснөөр хот тус бүрийн иргэд өөрсдийнхөө тэр тухайн хотынхоо төлөвлөлтөд оролцоод явах ийм боломж бүрдэж байгаа юм. Иргэд нь өөрсдөө оролцоод, иргэд нь дундаасаа хотынхоо төлөвлөлтөд оролцоод, тэр төлөвлөлтийнхөө хэрэгжилтийг шахаад шаардаад явдаг ийм нөхцөл бүрдэнэ гэж үзэж байгаа.

Тэгэхгүй бол одоо Зайсанд байгаа иргэн жишээлбэл Сонгинохайрханд хийгдэж байгаа ажлыг зохицуулаад яриад яваад байх ямар ч боломжгүй байгаад байгаа юм. Нэг л ийм том нүсэр тийм байдалтай байгаад байгаа учраас л ингэж

задалж, тэгээд тухайн хотынхоо төлөвлөлтөд оролцож, иргэд нь оролцож эхэлснээр таны түрүүний дээр дурдсан тэр нөхцөл боломжууд илүү сайжирна гэж ингэж үзэж байгаа юм.

3-д нь энэ хотынхоо захирагчийг тухайн хотын иргэд сонгодог болохоор ийм хууль байгаа. Ингэхлээр одоо бол та мэдэж байгаа манай энэ дүүргийн дарга нар, ер нь хотын дарга нар, аймгийн дарга чинь хотынхоо ажил гэхээсээ илүү улс төрийн ажил их хийгээд яваад байгаа шүү дээ. Гэтэл иргэд нь сонгочихсон тэр дарга, захирагчид илүү хотынхоо өөрчлөлтийн төлөө, хөгжлийн төлөө аж ахуйн ажил хийгээд яваад байх ийм боломж нь хангагдана гэж үзэж байгаа. Тийм учраас таны хэлсэн саяын 6 зүйлийг сайжруулах, тэр 6 өөрчлөлтийг бодитой болгох хамгийн сайн хууль гэж бодож байгаа. Олон жил яригдаж явсаар байж байгаад батлагдсан. Тэгээд энэ батлагдсан хуулиа үр дүнтэй хэрэгжүүлэхийн төлөө л бүгдээрээ ялангуяа энэ Их Хурал дээрээсээ эхлээд ойлголтуудаа нэгтгээд, тэгээд иргэддээ танилцуулаад, ингээд ойлголтыг улсын хэмжээнд их сайн өгч чадвал хуулийн хэрэгжилт үр дүнтэй болно. Тэгж чадахгүй яваад байвал хэрэгжиж чадахгүй, тэгээд энэ сайн зүйлээ үр дүнгүй болгочих вий л гэж санаа зовж байгаа юм. Тийм учраас цаг хугацаа хэрэгтэй байна л гэж үзэж байгаа.

Х.Булгантуяа: Жуковын Алдаржавхлан гишүүн.

Ж.Алдаржавхлан: Хамтарсан ЗГ байгуулчихсан байгаа шүү дээ манайх чинь Ардчилсан нам, Монгол Ардын нам. Тэгээд энэ ЗГ-ын мөрийн хөтөлбөрт орсон маш том ажил бол энэ 20 минутын хот гээд байгаа гэдэг мөрийн хөтөлбөрийн заалт байгаа. Энийг хэрэгжүүлэх үндэс нь өөрөө энэ Хот, тосгоны хууль байгаа юм л уг нь. Хэрвээ энэ хэрэгжиж чадахгүй дахиад хойшилбол ерөөсөө энэ 20 минутын хот Үндэсний хорооны ч хэрэггүй болно, ямар ч шаардлагагүй болно. Тэгээд гадуур буруу зөрүү ойлголт өгөөд бараг 14 хот, 14 захирагчтай болох юм байна гэсэн ярианууд гарсан. Яг үнэндээ анхны санаачилга нь энэ яг таны хажууд байгаа төрийн албан хаагчид бүх эрх мэдлийг шилжүүлэе л гэсэн ийм санаачилга байсан юм. Нөгөө муу хорооны дарга хөөрхий юу ч иддэггүй хүнд л, эрх мэдлүүдийг тэр доод шатад шилжүүлж, дор, дор нь асуудлаа шийддэг байя гэсэн санаачилгаар анх энэ хууль явж байсан юм. Би тухайн үед оролцоод явж байсан.

Одоо тэгээд би Эрдэнэбүрэн сайдаас ганц л юм хүсэх гээд байгаа юм. Яг үнэндээ өчигдөр намайг Бат-Эрдэнэ гишүүн Үндэсний хороон дээр очиж ажилласан гэж байна лээ. Би ажилласан. Тэгэхдээ би сэтгэлийн дуудлагаар ажилласан. Яагаад гэвэл би энэ хууль ... байсан, санаа зовж байсан хүний хувьд. Ажлын хэсэгт ороод ажиллаж байхад манай ЗГХЭГ хойрго ажилласан. Тэр газрын эдэлбэр газруудыг гаргаж өгөхөд 3 сар ухнатсан. Ерөөсөө сэтгэл гаргаагүй энэ хуулийг хэрэгжүүлэхэд. Тэр орон нутгийн хариуцсан ажилтнууд. Геодези, зураг зүйн газар, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар бүүр сүүлд ажиллаж эхэлсэн 2 сараас хойш. Хаана хаанаа ерөөсөө хичээгээгүй ийм л зүйл болсон юм. Тийм учраас одоо бэлтгэлээ хангая гээд ЗГ оруулж ирж байгаа нь би зөв гэж бодож байгаа юм.

2-т нь бид энэ хуулийг заавал хэрэгжүүлэх ёстой. 1992 оноос хойш явж байгаа, 30 гаруй жил явж байгаа Монгол Улсын засаг захиргаанд бид томоохон шинэчлэл хийхгүй бол болохоо байчхаад байгаа юм. Энэ доор чинь ерөөсөө ажил хийдэггүй, хүн ордоггүй төрийн байгууллагууд зөндөө болчихсон. Тэд нарыг

өөрчилье л гэж байгаа юм, цомхотгоё, нэгтгэе, тэдэнд эрх мэдлийг нь шилжүүлж өгье гэсэн ийм санаачилга гарсан юм. Тийм учраас энэ хуулиудыг бид бас анх ярьж байсан. Тэгээд манай Их Хурлын хэд сонгогдсон гишүүд энэ тэр ярьж байна лээ. Одоо Үндэсний хороонд орж болохгүй л гэж байгаа юм. Тэр бол байж болно. Гэхдээ энэ зарчмаа Их Хурал тогтоох ёстой. Их Хурлын гишүүн тийм, тийм ажилд орж болохгүй шүү, тэгээд бүгдээрээ мөрдөх ёстой. 1 хүн тийм субъектив байдлаар хандаж болохгүй л гэж би бодож байгаа юм. Ер нь 3 сонгогдчихлоороо хүний дээд, ухаантны охь болчихдог юм уу гэж би хааяа бодоод байгаа юм зарим гишүүдийг. Тийм учраас энэ хуулийг хойшлуулах нь зөв. Гэхдээ заавал хэрэгжүүлэх ёстой, дахиж битгий хойшлуулаарай гэж хүсэж байна. Энэ бараг санал юм даа. Баярлалаа.

Х.Булгантуяа: Алдаржавхлан гишүүн санал хэллээ. Одоо 1 гишүүний дараагаар 2 асуудал дээр 2-лан дээр нь санал хураалт явагдана. Улсын Их Хурлын гишүүд чуулганыхаа танхимд цуглана уу. Энэ хууль энэ 25 оны 6 сарын 1-нээс хэрэгжиж эхлэхээр байгаа. Тэгэхээр хэлэлцэх эсэхийг нь өнөөдөр шийдэж байж цаг, цагтаа багтаж батлагдахаар байгаад байгаа. Тэгэхээр Улсын Их Хурлын гишүүд яаралтай танхимдаа цуглана уу? Дараачийнх нь Улсын Их Хурлын гишүүн Дамбын Батлут гишүүн. Үг байхгүй, үг дээр нэрээ өгсөн хүмүүс татчихсан. Батлут гишүүн.

Д.Батлут: Гишүүдийнхээ оройн амгаланг айлтгая. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль нэлээн маргаан дагуулж байгаа. 20 оноос хойш яригдсан юм. Тэгээд энэ хуулийг тухайн үеийн Монгол Ардын намын бүлгийн дарга Тогтохсүрэн дарга ахлаад явж байсан. Яг үнэндээ Дархан, Эрдэнэтээс сонгогдсон гишүүд Дархан, Эрдэнэтийн иргэдийн эрх ашиг зөрчигдөөд байгаа учраас батлуулахгүй явсаар байгаад 4 жилийн нүүр үзсэн. Тэгээд яах вэ 24 оны 6 сард ингээд батлаад явж байгаа юм. Тэгээд одоо энэ хуулийг ингээд хэрэгжүүлэх гээд асуудлууд яригдангуут хууль, эрх зүйн хувьд зөрчилтэй байгаа улсууд байгаа учраас ЗГ түүн дээр тодорхой шийдэл гаргахгүй байгаа юм болов уу гэж харж байгаа юм. Уг нь энэ Улсын Их Хурлын 72 дугаар тогтоол болоод энэ хуулийн хэрэгжилтийг хангах субъект нь Засгийн газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар л гэж харж байгаа юм. Тэрнээс биш Улсын Их Хурлаас батлагдсан, байгуулагдсан ажлын хэсэг биш. Ажлын хэсэг тэрийг бол хууль, эрх зүйн хүрээндээ ажлаа хийж байгаа эсэх дүгнэлт гаргах, цаашлаад хууль, эрх зүйн хувьд нь өөрчлөлт оруулах асуудал дээр л анхаарч ажиллах ёстой гэж харж байгаа юм. Түрүүн Нямбаатар гишүүн 72 дугаар энэ тогтоолыг ажлыг хэрэгжүүлэхэд Улсын Их Хурлаас байгуулагдсан ажлын хэсэг ажлаа хийгээгүй байна гэж хэлж байх шиг байна лээ. Уучлаарай жоохон андуурсан байлгүй дээ эрх биш. Тийм зүйл байхгүй гэдгээ хэлье.

Нийслэл, энэ хотын статустай болох асуудлыг үгүйсгээд байгаа юм ерөөсөө биш. Гэхдээ энэ хууль хэрэгжихдээ эрх зүйн хувьд ямар нэгэн зөрчилгүй л байх ёстой. Ингээд хот байгуулаад энэ асуудал нь шийдэгдээд явъя гэж бодъё. Дархан-Уул аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь Хотын зөвлөлдөө, Засаг дарга нь хотынхоо захирагчийн асуудлыг түр орлон маягаар ингээд хууль, эрх зүйн хүрээнд нь үйлчлээд явах нь л дээ. Тэгвэл бусад сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 4 жилийн эрх авчихсан иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын асуудал яах юм бэ гэдэг асуудал босож ирж байгаа юм. Хот байгуулагдлаа 20 зөвлөлтэй байна, 21 гишүүнтэй байна. Тэгээд энэ Дархан чинь үндсэндээ Шарын голоос бусад сумд нь болохоор Дархан хотынхоо бүтцэд ороод явчхаж байгаа юм. Тэгэхээр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, багийн иргэдийн Нийтийн Хурал гээд бүр 4

жилийн бүрэн эрхийн хугацаанд баталгаажчихсан, сонголтоор баталгаажчихсан энэ хүмүүсийн асуудлыг хэрхэх вэ гэдэг асуудлыг ямар нэгэн хуулиар зохицуулж өгч чадаагүй. Магадгүй энэ нь өөрөө төлөөллийн зарчим алдагдаж байна, эргээд Үндсэн хуулийн зөрчил рүүгээ ч орчих магадлалтай болж өгнө. Тийм учраас энийг нэг тийш нь хандуулах зайлшгүй шаардлага байгаа юм.

Хотын даргын саналыг аваад, төсөв гэдэг дээр харъя. Хотын даргын, уучлаарай гишүүдээ жоохон чимээгүй аядахгүй юу. Хотын дарга төсвөө өөрөө батлах боломжгүй. Харин тухайн орон нутаг дээр байгаа аймгийн Засаг дарга Хотын захирагчийн саналыг аваад, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаараа төсвийг нь баталж өгнө. Энэ чинь ингээд баахан давхацсан бүтцийг л бий болгох гээд байгаа шүү дээ. Манай Эрдэнэт, Дархан дээр, Орхон, Дархан дээр. Орхон аймаг нь байна. Дархан-Уул аймаг нь байна, сумд нь яах юм бүү мэд, дээрээс нь хот гэж байна. Манай Эрдэнэт дээр Баян-Өндөр, Жаргалант гэж 2-хон сумтай, 2 сумын нутаг дэвсгэр дээр л 21 гишүүнтэй зөвлөл байгуулагдаж хотын үйл ажиллагааг зохион байгуулна. Тэгвэл нөгөө Жаргалант, Баян-Өндөр сумын 51 иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч хэрхэх юм бэ? Энэ төлөөллийн зарчим алдагдах уу гээд бөөн асуудлууд үүсэхээр ийм л асуудлууд байгаад байгаа юм. Тэгэхдээ энийг шийдэхийн тулд би бодож байгаа юм Үндсэн хуульдаа л өөрчлөлт хийчихье. Үндсэн хуульдаа Монгол Улс засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хувьд аймаг, нийслэл, улсын болон орон нутгийн.../минут дуусав/

Х.Булгантуяа: Батлут гишүүн 1 минут.

Д.Батлут: Ингэхээр Үндсэн хуульдаа л өөрчлөлт хийчихье. Ингэвэл нөгөө хот гэдэг статус нь жинхэнэ утгаараа орон нутагтаа улсын зэрэглэлтэй, орон нутгийн зэрэглэлтэй хот болж хөгжих боломжууд нь бүрдэнэ. Тэгэхгүйгээр ийм өнгөцхөн хийвэл бид зүгээр татвараа бүрдүүлээ гэж бодъё, татварыг нь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь батлахаар юунд ч зарцуулахаар батлах магадлалтай шүү дээ. Манай тайлбар хийж байгаа хүмүүс бол хотын дарга нь бараг төсвөө өөрөө мэднэ, хотын татвартай болно гээд л яриад байна. Яг үнэндээ батлах нь болохоор аймгийн иргэдийн Төлөөлөгч батлахаар хуульчилчихсан байгаа. Энэ мэтчилэнгээс авхуулаад маш их зөрчлүүд бий болох нөхцөл байдлууд үүсэж байгаа учраас Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулаад явах нь илүү зохимжтой юм гэж үзэж байгаа юм. Ийм тайлбарыг та бүхэндээ өгөх гэсэн юм. Баярлалаа.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан 17 цаг 24 минутаас хуралдааныг даргалав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүн алга байна. Улсын Их Хурлын гишүүд суудлаа эзэлъё. Бүртгэлийн санал хураалт. Дахиж санал хураалт явуулъя. Энэ бүртгэлийнх. Гишүүд суудалдаа сууя.

Байнгын хорооны саналаар Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгад өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжъё гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Алдаржавхлан гишүүн.

Ж.Алдаржавхлан: Миний сая төхөөрөмж ажилласангүй. Тэгээд саналыг хүчингүй болгож, дахин санал хурааж өгнө үү.

Д.Амарбаясгалан: Алдаржавхлан гишүүний саналаар санал хураая. Дэмжигдсэнгүй. Номтойбаяр гишүүн.

Н.Номтойбаяр: Үгүй ээ үгүй түрүүнийх чинь ороогүй байна. Гишүүдээ нэг ийм юм байгаа юм. Энэ хуулийн хэрэгжилтийг хойшлуулах нь зайлшгүй шаардлага байна. Яагаад гэхээр дутуу гэж үзэж байгаа, зөвхөн хотын хүрээнд хараад байгаа 1 дүгээрт тэр. 2 дугаарт ер нь эдийн засгийн чиг баримжаатай харах үүднээс Их Хурал дээр макро эдийн засгийнхаа бодлого, төлөвлөлтийг харъя гээд байгаа. Дээрээс нь хэд хэдэн ажлын хэсэг Их Хурлаас гарчихсан яваад байгаа. Адаглаад 2040-ийг Их Хурлаар батлах ажлын хэсэг гарчихсан байгаа. 2040-ийн хүрээнд энэ Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль чинь шууд холбогдож байгаа. Тэгэхээр өнөөдөр бид энэ хуулийг баталснаараа хэрэгжих ямар ч боломж байхгүй. Тэгэхээр аливаа асуудалд жоохон прагматик хандмаар байна. Тэгэхээр энэ хуулийн хэрэгжилтийг хангах боломжийг нь олгох үүднээс хойшлуулах нь зайлшгүй зөв байгаад байгаа юм. Энийг Төрийн байгуулалтын байнгын хороон дээр бид маш сайн ярьсан, мэргэжлийн улсуудтай нэлээн ярьсан. Тэгэхээр гишүүд саналынхаа энэ нөгөө техниктэйгээ харьцах дээрээ анхааралтай хандаад, дахиад санал хураах горимын саналыг Их Хурлын даргаа гаргаж байна. Адаглаад би өөрөө ажиллаж чадсангүй, уучлаарай.

Д.Амарбаясгалан: Тэгэхээр яах уу? Одоо танхимд бараг 80 гаруй гишүүд байгаад байдаг. Санал хураалт явахаар уначхаад байдаг. Номтойбаяр гишүүний гаргасан горимын саналаар энэ асуудлыг хэлэлцэх нь зүйтэй гэдэг, тийм хүчингүй болгоё гэсэн, эхлээд яах вэ санал хураалтыг хойшлуулах биш ээ, хүчингүй болгох томъёоллоор санал хураалт явуулъя. Горимын санал дэмжигдлээ. Үндсэн санал хураалт, үндсэн санал хураалт явуулъя. Санал хураалт. 57,6 хувиар санал дэмжигдлээ. Хамт өргөн мэдүүлсэн Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн саналын томъёоллоор, хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёолол. Санал хураалт. 59,8 хувиар санал дэмжигдлээ.

3.Тогтоолд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт. 59,8 хувиар санал дэмжигдлээ. Санал дэмжигдсэн учраас анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүллээ.

17.32 цаг

Байнгын хорооны, нөгөө өмнөх асуудал руу орно. Байнгын хорооны саналаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 27-гоос 28 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг үзэл баримтын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураана. Санал хураалт. 65,2 хувиар санал дэмжигдлээ.

2.Засгийн газрын өрийн удирдлагын 2026-аас 28 оны стратегийн баримт бичиг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн саналын томъёоллоор. Санал хураалт. 64,1 хувиар дэмжигдлээ. Ингээд санал хураалтаар дэмжигдсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байнгын хороодод шилжүүллээ. Байнгын хороодод бэлтгэл хангуулахаар шилжүүллээ.

17.35 цаг

Хэлэлцэх асуудал дууссан учраас өнөөдрийн нэгдсэн чуулган хаасныг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА